



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА

*Энэхүц гарын авлагыг БШУЯ, ЖАЙКА
хамтран хэрэгжүүлж буй "Багшлах арга зүйн
хөгжлийг түгээн дэлгэрцүлэх тогтолцоог
бэхжүүлэх нь" төслийн хүрээнд боловсруулав.*

БАГШЛАХУЙН ХӨГЖИЛ:

БАГШЛАХУЙН АРГА ЗҮЙН ХӨГЖЛИЙГ ТҮГЭЭН
ДЭЛГЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЕНЕЖМЕНТ

(ГАРЫН АВЛАГА)

Боловсролын бодлого боловсруулагч, судлаач, арга зүйч,
ЕБС-ийн удирдах ажилтан нарт зориулав.

Улаанбаатар хот

2013 он

DDC
371.102
D-147

БОЛОВСРУУЛСАН БАГ:

АХЛАГЧ:

Нэрэндоогийн Нэргүй

“Тэгш таван ухаан” боловсролын төв (ТББ)-ийн тэргүүн

ГИШҮҮД:

Чойжилсүрэнгийн Нямгэрэл

МУИС-ийн Хими, химийн инженерчлэлийн сургуулийн багш

Шагдарын Оюунцэцэг

БМДИ-ийн Хэл, нийгэм, хүмүүнлэгийн сургалтын албаны дарга

Өвгөний Цэндсүрэн

Нийслэлийн Боловсролын газрын ахлах мэргэжилтэн

Лувсанцэрэнгийн Сувдаа

Сэлэнгэ аймгийн Боловсролын газрын мэргэжилтэн

Ягаанбаатарын Нарангэрэл

Завхан аймгийн Боловсролын газрын мэргэжилтэн

Хандын Баясгалан

Дорнод аймгийн Боловсролын газрын мэргэжилтэн

Цогзолын Намжилдорж

Нийслэлийн 45 дугаар сургуулийн захирал

Дамдинсүрэнгийн Энхтуяа

“Багшийн хөгжил-Имидж” төв (ТББ)-ийн гүйцэтгэх захирал

ЭКСПЕРТИЙН БАГ:

АХЛАГЧ:

АлимаагийнТуяа

БШУЯ-ны Суурь, бүрэн дунд боловсролын хэлтсийн дарга

ГИШҮҮД:

Ноокоогийн Оюунцэцэг

МУИС-ийн Хими, химийн инженерчлэлийн сургуулийн профессор

Чодингийн Ганцэцэг

БШУЯ-ны Сургуулийн өмнөх, бага боловсролын хэлтсийн мэргэжилтэн

Жамцын Нарантуяа

БШУЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн

Оросоогийн Оюунтунгалаг

БМДИ-ийн дэд захирал

Бадамжавын Золзаяа

МУБИС-ийн Компьютер, мэдээллийн технологийн сургуулийн багш

РЕДАКЦИЙН БАГ:

Мөнхөөгийн Ганбат

МУИС-ийн Физик электроникийн сургуулийн багш, дэд профессор

Шагдарсүрэнгийн Сайнбилэг

МУИС-ийн Хими, химийн инженерчлэлийн сургуулийн багш

Шагдарын Оюунцэцэг

БМДИ-ийн Хэл, нийгэм, хүмүүнлэгийн сургалтын албаны дарга

ЗӨВЛӨХ БАГ:

Иший Тэцүя

Төслийн менежер

Сүзүки Саяака

Сургалт, хяналт үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Бадамсамбуугийн Хишигбаяр

Төслийн мэргэжилтэн

ISBN 978-99962-54-77-2



“Содпресс” ХХК-д хэвлэв.

АГУУЛГА

ОРШИЛ	4
I. Багшлах арга зүйн шинэчлэлийн менежмент	5
1.1. Өөрчлөлт, шинэчлэл, хөгжил	5
1.2. Боловсролын хөгжлийн чиг хандлага ба багшлах үйлийн өөрчлөлтүүд	6
1.3. Багшлах үйлийн ур чадварт тавигдах шинэ шаардлага	15
1.4. Багшлах арга зүйн шинэчлэлийн менежмент	16
II. Хичээлийн судалгааны менежмент	22
2.1. Хичээлийн судалгаа	22
2.2. Хичээлийн судалгааны төрөл, ангилал	25
2.3. Хичээлийн судалгааны зориулалт, ач холбогдол, талуудын оролцоо	26
2.4. Хичээлийн судалгааны менежмент	27
2.5. Хичээлийн судалгааны менежментийн загвар	28
2.6. Хичээлийн судалгааны менежментийн загварыг хэрэгжүүлэх зөвлөмж	33
III. Багшлах арга зүйн хөгжлийг түгээх дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежмент	35
3.1. Арга зүйн шинэчлэлийг түгээн дэлгэрүүлсэн менежмент	35
3.2. Багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх менежментийн загварууд	48
3.3. Хичээлийн судалгаанд суурилсан арга зүйг хөгжүүлэх төслийн менежмент	50
3.4. Хичээлийн судалгаанд суурилсан багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежмент	64
VI. Хичээлийн судалгааг хэрэгжүүлж буй зарим улс орны туршлага	68
4.1. Япон дахь багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт ба хичээлийн судалгаа	68
4.2. Хичээлийн судалгааг түгээн дэлгэрүүлж байгаа Индонез улсын туршлага	73
ТОВЧИЛСОН ҮГ	77
НОМ ЗҮЙ	78
ХАВСРАЛТ	79

ОРШИЛ

Монгол улсад нийгмийн өмнөх тогтолцоо доргиж, задран шинэ тогтолцоо бүрдэх үйл явц эхлээд 20 гаруй жил болж байна. Энэ нь улс орны түүхэн хөгжлийн хувьд тийм ч богино хугацаа бишээ. Боловсролын өөрчлөлт шинэчлэлийн эгзэгтэй (экстремум) төлөв байдал хэдийнээ ард үлдэж, Монгол Улс боловсролдоо тогтолцооны шинжтэй томоохон өөрчлөлтүүд хийж, шинэчлэлийн үйл явц өдгөө үргэлжилсээр л байна. Энэхүү “дуусдаггүй шинэчлэл” зарим тохиолдолд бэрхшээл учруулж, салбарынхан маань түүнийг даван туулах нэмэлт ачаа үүрч байна.

Аливаа үйлийн чанар түүнийг гүйцэтгэсэн аргаас хамаардаг. Иймээс багшлах үйлийн арга зүйг шинэчлэх, хөгжүүлэх чиглэлээр бид өнгөрсөн хугацаанд маш тодорхой бодлого, стратеги тодорхойлж, бүхий л нөөцийг дайчилсан боловсролын Мастер төлөвлөгөө боловсруулан, олон зуун сая төгрөг зарцуулсан хөтөлбөр төслийн хүрээнд багш, удирдах ажилтанд зориулсан олон тооны сургалтууд зохион байгуулсан билээ. Гэвч өнөөдөр багшлах арга зүйн шинэчлэл бодит үр дүнд хүрч, багш нарын багшлах ур чадвар хангалттай түвшинд хүрч чадсан уу гэвэл “энд олон асуудал” байна гэж хэн ч хариулна.

Бидэнд энэ олон асуудлууд мэдрэгдээд, ажиглагдаад байгаа нь зөвхөн үзэгдэл юм. Эдгээр асуудал бүрийн араас хөөгөөд байвал тэр асуудал хэзээ ч бүрэн шийдвэрлэгдэхгүй, өнгө төрхөө хувирган оршсоор, цаг хугацаа, хөрөнгө мөнгө, хүч чадлаа үр өгөөжгүй зарцуулсаар дампууралд хүргэх эрсдэлтэй. Харин эдгээр олон асуудлын шалтгааныг зөв оношилж, “эмчилбэл” олон асуудал зэрэг шийдвэрлэгдэх “синергетик” ач холбогдолтой гэдэгтэй хүмүүс маргахгүй байхаа.

Иймээс багшлах арга зүйн шинэчлэлийг бодит хөгжилд хүргэхэд БСШУЯ ба Японы ЖАЙКА байгууллагатай хамтран 2007-2012 онд хэрэгжүүлж байгаа “хичээлийн судалгаанд суурилсан багшлах арга зүйн хөгжил”-ийг хангах хоёр шаттай төсөл том хувь нэмэр оруулж байна. Энэ төслийн үйл ажиллагааны онцлог нь багш нар хамтдаа хичээлдээ судалгаатай, бэлтгэлтэй, ажил хэрэгч хандах арга барилд суралцуулдаг төдийгүй түүнийгээ заавал хэрэглэж байх сургалтын технологийн менежмент шаарддагт оршдог. Иймд “хичээлийн судалгаа”-г сургалтын технологийн менежментэд институтчилж, багшлах арга зүйн шинэчлэлийг “амилуулж” багшийн тогтвортой хөгжлийг хангах хичээлийн судалгааны далд хүч боломжийг ашиглах хэрэгцээ шаардлага урган гарч байна.

Багшлах үйл нь хүүхдийг хөгжүүлэх нарийн нийлмэл судалгааны ажил болох, сургалтын технологийн менежмент нь хичээлийн судалгааны менежментэд суурилсан байх талаар багшийн хөгжлийн асуудлаар төрөөс баримтлах бодлого, стратеги, эрх зүйн актуудад маш тодорхой тусгагдсан байдаг. Гэвч багшлах арга зүйн шинэчлэл дорвитой амжилтад хүрч чадахгүй байгаагийн шалтгаан нь энэ бодлого, стратегийн хэрэгжилтийн зохицуулалт, хяналт- шинжилгээ үнэлгээний арга менежмент дутагдалтай байгаад оршиж байна гэж үзэх үндэслэлтэй.

Төслийн 2 дахь шатны бүтээгдэхүүний нэг болох “Багшлах арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежмент” хэмээх энэхүү гарын авлага 4 бүлэгтэй. Гарын авлагын нэгдүгээр бүлэгт боловсролын хөгжлийн чиг хандлагаас үүдэлтэй багшлах үйлд гарсан өөрчлөлтүүд, багшийн ур чадварт тавигдаж буй шинэ шаардлагууд, 1990-ээд оноос эхлэлтэй багшлах арга зүйн шинэчлэх менежмент, түүнийг үнэлэхэд шалгуур болгож болох өөрчлөлт, шинэчлэл, хөгжил гэсэн ойлголтын хамаарлын талаар өгүүлсэн. Өөрөөр хэлбэл, ямар бодлого, стратегийн хүрээнд ямар төлөвлөлт, зохицуулалт, манлайлал, хяналт-шинжилгээний, үнэлгээний механизмаар юуг түгээн дэлгэрүүлэхийг тодруулахыг хичээсэн. Гарын авлагын хоёрдугаар бүлэгт ЖАЙКА-тай хамтарсан төслийн хүрээнд боловсруулж, нийтийн хүртээл болгож буй 40 орчим сургалтын модуль, гарын авлагад өгөгдсөн “хичээлийн судалгаа”-ны загварууд, тэдгээрийг хэрэгжүүлэх менежментийг ерөнхийлөн базаж дүгнэх, бусад модулуудтай холбох оролдлого хийлээ. Гарын авлагын гуравдугаар бүлэгт нэг ба хоёрдугаар бүлэгт тодруулсан багшлах арга зүйн шинэ зарчим, арга хэрэгслээ, сургалтын технологийн шинэ менежментээр түгээн дэлгэрүүлж ирсэн менежмент болон энэ менежментээ цаашид сайжруулахад чиглэлийн талаар тодорхой өгүүлсэн. Номын сүүлчийн бүлэгтээ зарим гадаадын улс орнуудын хичээлийн судалгаа хийдэг туршлагаас танилцуулсан.

Гарын авлага нь хэн нэгэн зорилтот бүлэгт тусгайлан зориулагдаагүй бөгөөд түүнийг шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчид, боловсролын болон сургалтын байгууллагын удирдах ажилтан судлаачид өөрийн үйл ажиллагаандаа ашиглах боломжтой.


I. БАГШЛАХ АРГА ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН МЕНЕЖМЕНТ

1.1. Өөрчлөлт, шинэчлэл, хөгжил

Аливаа хөгжлийн асуудал шинжлэх ухааны дэвшилтэт сэтгэлгээ, арга барил хэрэглэн шинжилгээ судалгаатайгаар хандахыг шаарддаг. Багшлах арга зүйн хөгжлийн асуудалд ч мөн л ийм арга барил, хандлага хэрэгтэй.

Багшлахуйн арга зүйн хөгжлийн чиг хандлага, шийдлийн үндэслэлийг тодорхойлохдоо юуны өмнө өөрийн гэсэн өвөрмөц мөн чанартай багшлах үйлийг сургалтын арга зүйн хөгжилтэй холбон шинжлэх ухаанч сэтгэлгээ, барилын дагуу шинжлэн судлах шаардлагатай (Зураг 1.1.).

Онолгүй үйл ажиллагаа нь үндэслээгүй модтой адил



Зураг 1.1. Багшлахуйн арга зүйн хөгжлийн асуудалд хандах нь

Бид хөгжлийн тухай асуудлыг хөндөхдөө аливаа зүйлийн өөрчлөлт, шинэчлэл, хөгжил гэж юуг ойлгож байгаагаа тодруулж, эдгээр ойлголт юугаараа төсөөтэй ба ялгаатай болохыг ухаарах нь чухал.

Буддын гүн ухаанд “Ертөнцөд бие даасан цул юм үгүй, бүгд харилцан нөхцөлдөж, шүтэн барилдан оршдог”, “Ертөнцийн цорын ганц үнэн бол мөнхийн хувьсал өөрчлөлт” хэмээн сургасан байдаг. Аливаа зүйл янз бүрийн эрэмбийн холбоотой олон хүчин зүйлсийн харилцан хамаарлын нөлөөгөөр тасралтгүй өөрчлөгдөж байдаг хэмээх дүгнэлттэй та санал нийлэх болов уу.

Байгаль цаг уур, нийгэм, улс төр, эдийн засаг, соёл боловсролын өөрчлөлтийн нөлөөгөөр сургалтын арга зүй ч тасралтгүй өөрчлөгдсөөр байна.

Гэтэл өөрчлөлт болгон дандаа эерэг үр дүн буюу шинэчлэл, хөгжлийг авчирдаггүй билээ. Ялангуяа хүний итгэл үнэмшил, ашиг сонирхол, субъектив хандлагаас шалтгаалж, зүй ёсны өөрчлөлтөд саад бэрхшээл учирч хөгжил дэвшил бус хоцрогдол ухралт гарах тохиолдол байдаг. Тэгвэл өөрчлөлт, шинэчлэл, хөгжил дэвшлийг хооронд нь ялгах шалгуур байна уу, эдгээр үг ухагдахуун юугаараа төсөөтэй, юугаараа ялгаатай юм бэ гэсэн асуулт гарна. Энэ асуултад олон талаас нь хариулж болно.

Бид хэлэлцэж байгаа сургалтын арга зүйн хөгжлийн асуудалтайгаа холбогдуулан асуултад дараах байдлаар хандаж болох юм. Хөгжил бол суралцах, багшлах үйл явцын гаралт дээр хүлээгдэх үр дүнг илүү илэрхийлэх тэдгээр үйлийг гүйцэтгэх аргад гарч буй ахиц дэвшил, шинэчлэл бол эдгээр үйл явцын оролтын төлөв байдлыг түлхүү тодорхойлох цогц шийдлүүд, өөрчлөлт бол суралцах, багшлах үйлийн явцад түлхүү баримжаалсан чанарын хувиргалт гэж үзэж болно. Мөн өөрчлөлт бол шинэчлэл, хөгжлийн аль алийг өөртөө агуулах илүү ерөнхий ойлголт юм.

Түүнчлэн арга зүйн өөрчлөлт нь тасралтгүй, шинэчлэл нь үе шаттай, хөгжил нь бодит үр дүнтэй байх учиртай. Монголын багш нар 1990 оноос хойш сургалтын чанарыг дээшлүүлэхийн тулд багшлах арга зүйгээ тасралтгүй өөрчилсөөр байна. Сургалтын арга зүйг шинэчлэх талаар Монгол улсын төрөөс баримтлах бодлого, стратеги тодорхойлогдож, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа үргэлжилсээр ирлээ. Харин өнөөдөр бүх багш нар багшлах шинэ арга зүйг бүрэн эзэмшиж, түүнийгээ тасралтгүй сайжруулж чадаж байна уу гэвэл “Тийм” гэж хэлэхэд хэцүү байна. Өөрөөр хэлбэл, сургалтын арга зүйн хөгжилд хүрч чадсан уу гэдэг нь “асуудал” хэвээрээ байсаар байна.

Суралцагчдад чанартай, үр өгөөжтэй боловсрол эзэмшүүлэх сургалтын арга зүйн хөгжлийн бодит үр дүн болон илрэх үндсэн нөхцөл нь шинэчлэлд хэр зэрэг судалгаатай, шинжлэх ухааны үндэстэй хандсанаас хамаарах учиртай.

Аливаа онол, үзэл санаа, арга барил, сэтгэлгээ, хандлагын “шинжлэх ухаанч чанар”-тай байх шалгуур бол (i) тогтолцооны хувьд дотоод зөрчилгүй байх,

(ii) амьдрал, практик, туршилтаар нотлогдож байх, (iii) эргэлзэж эргэцүүлэх боломжийг зөвшөөрсөн байх зарчмууд байдаг.

Иймд Монгол улсад сургалтын арга зүйг шинэчлэн хөгжүүлэхдээ суралцахуйн болон багшлахуйн парадигмд гарсан өөрчлөлтүүдийг шинжлэн судалж, уг шинэчлэл нь шинжлэх ухаанч чанартай байх дээрх шалгууруудыг давж гарахын төлөө манай боловсролын салбарынхан чармайн ажилласан билээ. Сургалтын буюу суралцахуй ба багшлахуйн арга зүйг шинэчлэхдээ онол арга зүйн ямар зарчмыг сонгож, ямар шийдлүүд хийгдсэн талаар Боловсролын Яам болон бусад байгууллагаас зохион байгуулсан олон тооны сургалтаар багш нарт танилцуулж, сургалтын материал, ном, товхимолуудыг сургуулиудад хүргэгдсэн.

Энэ удаа БСШУЯ болон Японы “ЖАЙКА” байгууллагаас “Хичээлийн судалгаа”-ны чиглэлээр 2006-2012 оны хооронд хамтран хоёр шаттай хэрэгжүүлсэн төслийн үр дүнг “Багшлахуйн арга зүйн хөгжлийн түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежмент” сэдвийн доор хураангуйлан нэгтгэж, нийтийн хүртээл болгож байна. Энэхүү гарын авлагад өнгөрсөн 20 гаруй жилийн турш Монгол Улсад багшлах арга зүйн хөгжлийн асуудал, шинэ арга зүйг түгээн дэлгэрүүлэх талаар хуримтлуулсан туршлагыг тойлон авч үзэх нь зүй ёсны хэрэг гэж үзлээ.

1.2. Боловсролын хөгжлийн чиг хандлага ба багшлах үйлийн өөрчлөлтүүд

“Багш” боловсролын хөгжлийн асуудалд хандахдаа боловсролын үйлчилгээний зах зээлийн хуулийн дагуу түүний эрэлтийг тодорхойлдог боловсролын стандарт ба нийлүүлэлтийг тодорхойлдог киррикулим хоорондын шүтэлцээнд тулгуурлан тэдгээрийг шинэчлэх, боловсронгуй болгож байх, хэрэгжүүлэх, үнэлж дүгнэхдээ боловсрол судлаачдын анхаарлыг татдаг олон асуудлаас парадигмийн шинжтэй өөрчлөлтөд орж байгаа түлхүүр асуудлыг тусгайлан авч үзэх шаардлагатай болдог. Тэр тусмаа амьдралын бүхий л талыг хамарсан хурдтай өөрчлөлтүүд хүн бүрд мэдрэгдэх болж, тухайн парадигмийн үйлчлэх хугацаа ч богиносх болсон өнөө үед, сургалтын түлхүүр асуудлын хөгжлийн чиг хандлагыг нь байнга үнэлж, агуулгад нь гарч буй өөрчлөлтийн мөн чанарыг тусгах замаар боловсрол судлаачид стандарт болон киррикулимээ тасралтгүй сайжруулан хөгжүүлж байх ёстой. Дэлхийн олон улс орны сургалтын практикт 1990-ээд оноос нэвтэрч эхэлсэн киррикулим хөгжлийн парадигмийн өөрчлөлтөд гарсан зарим түлхүүр асуудлын¹ агуулгыг товч авч үзье.

- Судлагдахууны мэдлэгээс → цогц чадамжийн боловсролд шилжих хандлага. Хүн төрөлхтний даяаршил болон нийгмийн хөгжлийн шалгуурыг ханган ажиллаж, амьдрах бодит чадвартай, хариуцлагатай бүтээлч иргэний төлөвшил нь мэдлэгийн тодорхой нэг салбарын гүнзгийрэлтээр ч биш, нэвтэрхий толь шиг олон талын салангид мэдлэгийн өргөн хүрээгээр ч биш, харин асуудлын мөн чанараас үл хамааран түүнийг шийдвэрлэх цогц чадамжуудаар тодорхойлогдох болсон.
- “Боловсрол эзэмших, эзэмшүүлэх” үйлийг үр ашигтай болгох хандлага. “Боловсролын гайхамшигт гурвалжин (тоо, чанар, өртөг гурвын шүтэлцээ)”-ны зарчмаар бол өртөг нэмэхгүйгээр чанар ахиулах бараг боломжгүй. Гэтэл өртгөө эрс нэмээгүй ч чанарт дэвшил гаргах арга зам бол сургалтын арга зүй, технологийг боловсронгуй болгох явдал юм. Иймээс мэдлэг асар хурдтай хуучирч буй өнөө үед суралцагчдад хэрэгцээтэй мэдлэгээ бүтээдэг арга эзэмшихэд нь туслахад чиглүүлэх үүднээс багш нар дидактик арга барилаа байнга боловсронгуй болгож хөгжүүлэх стратеги давамгайлах болсон.
- Эсвэл, өртөг нэмэхгүйгээр “тоо” ахиулах боломжгүй, “тоо” нэмэхгүйгээр “чанар” сайжруулахад учир дутагдалтай гэх мэт “гайхалтай гурвалжин”-ы талууд хоорондоо “хүйн” холбоотой, харилцан шүтэлцээтэйг анхаарч, сургалтын технологи, арга зүйг боловсронгуй болгохдоо суралцагчдад суралцах арга барилаа байнга сайжруулж байх дадал хэвшил суулгах замаар “насан туршийн боловсрол”-ын ерөнхий арга зүйг эзэмшүүлэх стратеги баримтлах болсон.
- Боловсролын үр дүнг тоогоор биш, чанараар илэрхийлэх хандлага. Энэ хандлага боловсрол судлалд төдийгүй боловсролын бүхэл бүтэн тогтолцооны өөрчлөлт шинэчлэлийг шаардсан асуудал бөгөөд боловсролын

¹ Ч.Лхагважав, Н.Нэргүй, Багш боловсролын стандарт, киррикулимийг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал, “Багш боловсролын хөгжлийн шинэ чиг хандлага”, УБ, 2003, хх.6-8.

чанарын менежмент болон шинжлэх ухааны бусад олон салбар шинээр үүсэн хөгжих хэрэгцээ, үндэслэлийг бий болгосон. Боловсролын үр дүнг чанараар илэрхийлэхтэй холбоотойгоор хүний хөгжлийг тодорхойлохдоо юу мэдэж, чадаж байна гэхээсээ илүү асуудал шийдвэрлэх ямар цогц чадамж (competence)-тай байна гэдгээр нь үнэлэх шинэ үнэлэмж бий болж, энэ үнэлэмжийг хэмжээсжүүлэх боловсролын стандарт, түүний хэрэгжилтийг тодорхойлох хяналт-шинжилгээ, үнэлгээний шинэ тогтолцоо бүрэлдэн тогтож байна. Энэ хандлагыг бүхэлд нь “Стандартад суурилсан боловсрол”-ын хөгжил гэж тодорхойлдог.

- Боловсролын философид, тухайлбал, суралцахуйн сэтгэл зүйд конструктивист чиглэл хүчтэй нөлөөлж байгаа хандлага. Боловсролын философид бас өөрчлөлт гарч “суралцахуй” нь конструктивист чиглэл баримтлах арга буюу суралцагчийн өмнөх мэдлэгт түшиглэн өөрийнх нь үйл ажиллагаагаар “шинэ мэдлэг” бүтээлгэх хандлага юм. Энэ хандлага ёсоор суралцагч нь суралцахуйн идэвхгүйгээс → идэвхтэй төлөвт шилжиж, шинжлэн судлаачийн арга барилд суралцах, асуудал шийдвэрлэхдээ мэдлэгээ бүтээлчээр хэрэглэх сэтгэлгээний дадал зуршлыг илүү эрхэмлэх болсон. Түүнчлэн багш нь багшлахуйн идэвхгүйгээс → идэвхтэй төлөвт буюу эксперт, менежер-зөвлөн туслагчийн арга барилд илүү мэргэших болсноор тэдний ажил үйл гүйцэтгэх арга зүйн түвшин дээшилж, боловсролын үр ашиг нэмэгддэг байна. Үүнийг дидактикт “багшлахуйд төвлөсөн сургалт”-аас “суралцахуйд төвлөсөн сургалт”-д шилжих шилжилт буюу сургалтын менежментэд “бэлэн мэдээлэл дамжуулах технологи”-ийг² мэдээлэл боловсруулж, шинэ мэдлэг бүтээлгэх технологи” болгон шинэчлэх стратеги гэж нэрлэдэг. Бидний 1990-2001 оны хооронд ярьж, бас хэрэгжүүлэх гэж чармайж байсан “Шавь төвтэй сургалт”-ын технологи нэвтрүүлэх, сургалтыг прагматик төлөвт шилжүүлэх гэсэн стратегийн хийгээд 2004 оноос өнөөг хүртэл нь цогц чадамжид суурилсан боловсролын шинэ стандарт, тогтвортой хөгжлийн боловсролын агуулга, үзэл санаанд суурилсан үндэсний нээлттэй кирриолимийг хэрэгжүүлэх тулгамдсан зорилтууд нь зайлшгүй хэрэгцээтэй, бас тэгээд сонирхолтой боловч маш нарийн нийлмэл, хүнд хүчир, ээдрээтэй сорилт болохыг бид өөрсдийн өдөр тутмын үйл ажиллагаагаар улам илүү мэдэрч байгаа билээ.
- Боловсролын глобальчлал-локальчлалын оновчтой шүтэлцээг хангах хандлага. Боловсролын даяаршил, боловсролын хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлэхдээ бид Монгол ардын сурган хүмүүжүүлэх мэдлэг, туршлагын шилдэг өв уламжлалаа боловсронгуй болгон боловсролын бүх түвшинд, сургалтын бүх төрөлд ашиглана гэсэн стратеги баримтлах нь зүйтэй юм. Хүн төрөлхтөн түүхэн хөгжлийнхөө туршид хүнийг хүмүүжүүлэх, иргэншүүлэх талаар сургалтын арга технологио өнө эртний үеэс өдгөөг хүртэл уламжлан сайжруулсаар, өөрийн гэсэн өвөрмөц соёлоо бүтээсээр ирсэн. Иймд сурган хүмүүжүүлэх мэдлэг туршлагын маань цогц болох үндэсний өвөө бид анхааралтай судлан сорчлон авч, бүтээлчээр хэрэглэж чадваас дэлхийн боловсролын өв санд өөрийн хувь нэмрээ оруулах боломжтой. Монгол ардын сурган хүмүүжүүлэх өв уламжлал нь нутгийнхаа байгалийн болон нийгэм ахуйн орчинтойгоо салшгүй холбоотой хөгжиж ирсэн нь ойлгомжтой. Иймээс Монголын уламжлалт сургалтын арга, хэрэглэгдэхүүн болох²
 - Ардын аман зохиол (зүйр цэцэн үг, оньсого таавар, ертөнцийн гурав, бэлэг дэмбэрэлийн үгс, уран холбоо хэллэгүүд, ардын дуу, үлгэр туульс, домог хууч яриа);
 - Ёс заншил (угсаатны эд өлгийн соёл болох хувцас, гэр орон, хоол унд, утга соёлын холбогдолтой хэв ёс, найр хурим, мэндлэх, хүндлэх, хуримлах, оршуулах зан заншил гэх мэт);
 - Ардын тоглоом наадгайн зүйлс (хөлөгт тоглоом, шагайн тоглоом, хөдөлгөөнт тоглоом, гар хурууны тоглоом, эвлүүлэх тоглоом, оньсон тоглоом, уран эвхээс, уяа зангилаа, илбэ ухааны тоглоом, хөзөр, даалуу, хорол, үүчир гэх мэт);
 - Ардын урлаг, баяр ёслол (баяр наадам, дуу, хөгжим, бүжиг гэх мэт);
 - Эх хэл бичиг (уйгаржин, кирилл болон бусад бичиг гэх мэт);
 - Амьдрал үйл ажиллагааны туршлага, технологи;
 - Бичгийн зохиол, бүтээл зэрэг хүнээ боловсролжуулах олон хэрэглүүрийн агуулга, хэрэглээ нь маш нарийн тул тэдгээрээс арга

² Н.Оюунцэцэг, Монгол ардын сурган хүмүүжүүлэх өв уламжлал, “Сургууль соёлын хөгжлийн шинэ чиг хандлага”, УБ, 2008, х85-86

технологийн шинжтэй санааг ялган тодорхойлж, шинэ арга технологи бүтээх, дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч байгаа нийтлэг арга, хэрэглэгдэхүүнийг өөрийн гэсэн өнгө аясаар баяжуулах, түүнийгээ бүтээлчээр хэрэглэх шаардлага улам бүр нэмэгдэж байна. Бид ардын сурган хүмүүжүүлэх өв уламжлалаа орчин цагийн нийгэм, боловсрол, шинжлэх ухааны орчинтой нь уялдуулан, шинэ соёлын орчныг үүсгэн хөгжүүлж чадваас дэлхийн боловсролын даяарших үйл явцын давалгаанд өөрийн нэмэр хандив болох оюуны сантай байж, тэр давалгаанд монгол соёл бүдгэрэх биш, орчин цагийн монголын гэсэн тодотголтой шинэ соёл хөгжиж товойх болно. Ингэж чадваас мэдээллийн нээлттэй өрсөлдөөнд Монголын иргэд боловсролоороо, боловсролын чанараараа шалгарах боломжтой юм.

Ийнхүү нэг талаас, боловсрол судлаачдын анхаарлын төвд оршиж, дэлхийн улс орнуудын боловсролын шинэчлэлийн гол стратегийн мөн чанарыг илэрхийлж буй боловсролын хөгжлийн чиг хандлага болон боловсролын түлхүүр ухагдахууны агуулгад орсон дээрх өөрчлөлт нөгөө талаас, тусгаар улсынхаа хувьд монгол ардын сурган хүмүүжүүлэх үүцээ задлан үнэ цэнтэй болгох хэрэгцээ нь боловсролын стандарт, киррикулим, сургалтын технологийн шинэчлэл болон боловсролын хөгжлийн стратегийн сонголтод зайлшгүй тооцох хүчин зүйлийн нэг төдийгүй, ерөөсөө тэдгээрийг шинэчлэн хөгжүүлэх арга зүйн зарчмыг тодорхойлж байдаг. Түүнчлэн боловсролын гол гол түлхүүр ухагдахууны агуулгад гарсан өөрчлөлт нь боловсролын болон сургалтын тогтолцооны бүрдэл хэсэг бүрийн тусгайлсан шинэчлэл, хөгжлийн чиг хандлагыг ч тодорхойлдог. Тухайлбал, тэдгээр өөрчлөлт нь “багш” мэргэжлийн шинжүүр, “багш” хүний мэдлэг, ур чадвар, цогц чадамж, үүрэг, хариуцлагыг ч нийгмийн захиалга хэлбэрээр илэрхийлэх, мөн тэдгээр өөрчлөлтийн чиг хандлагыг тодорхойлоход суурь үндэслэл болно.

Агуулга, арга зүйд нь парадигмын өөрчлөлт орж буй дээрх асуудлуудыг тус тусад нь салангид шийдвэрлэх боломжгүй бөгөөд харин тэдгээрийг харилцан уялдаа холбоонд нь харж, амьдралд бодитоор хэрэгжих олон төрөл хувилбартай байхаар шийдвэрлэх тийм хүчтэй арга хэрэгсэл байгаа тохиолдолд л хөгжлийн асуудал харьцангуй амжилттай шийдвэрлэгдэх боломжтой билээ. Иймээс ийм хүчтэй арга хэрэгслийг бүтээнэ гэдэг нь тодорхой үзэл баримтлал, онолын шинэ загвар боловсруулна гэсэн хэрэг юм. Иймээс гадаад улс орнуудын төдийгүй Монголын боловсролын судлаачид багшийн боловсролын стандарт, киррикулимийг шинэчлэх үзэл баримтлал, түүнд тулгуурласан стандарт, киррикулимийн тодорхой хувилбар боловсруулсаар байгаа билээ.

Багшлах
үйлийн
агуулга, чиг
үүрэгт гарч
буй өөрчлөлт

Багшлахуй үйлийн агуулга, багш мэргэжилтний үндсэн чиг үүрэгт гарсан өөрчлөлтийг сэргээн саная. Шинжлэх ухаан, технологи, нийгэм, эдийн засгийн хөгжлөө дагаад хүн төрөлхтний түүхэнд багшийн ажил мэргэжлийн агуулга, чиг үүрэг өөрчлөгдсөөр ирсэн байна.

Багш гэж хэн бэ? Энэ асуултад хариулахын тулд дээр дурдсан хүчин зүйлсийн нөлөөллөөс гадна шинжлэх ухааны болон нийгмийн хөгжлийн шаардлагаар энэ ухагдахуун хэрхэн өөрчлөгдөж ирсэн түүхэн үйл явцыг судалсан гол гол дүгнэлтэд анализ хийх шаардлагатай. Тухайлбал, багш боловсролын *философи үндэслэлийг* тодорхойлсон судалгаанд³:

- Багш бол суралцагчийн мэдлэгийг сэргээн хөгжүүлэгч (идеализм)
- Багш бол бодит мэдээллийг боловсруулан дамжуулагч (реализм)
- Багш бол суралцагчийн оршин байхад нь туслагч, зөвлөгч (экзистенциализм)
- Багш бол суралцагчид мэдлэгээ хүч болгон хувиргахад нь туслагч, дэмжигч (прагматизм)
- Багш бол өдөөгч-хариу үйлдлийн диалектик холбоогоор бусдыг дасгалжуулагч, сургагч (бихевиоризм)
- Багш бол суралцагч мэдлэгээ өөрөө бүтээх үйл ажиллагааны менежер (конструктивизм) гэж тодорхойлсон байна.

Харин “багш” боловсролын агуулга хөгжлийн явцад хэрхэн өөрчлөгдөж ирсэн талаар дурдсан судалгаанд⁴

³ Ts.Luvsandorj, Towards the problem to rationalize curriculum development & education standardization, Dissertation summary, UB, 2001, p.23.

⁴ Research in Science Education – Past, Present and Future, Edited by Helga Behrendt, Helmut Dahncke (Faculty of Education, University of Kiel, Germany); Reinders Duit, Wolfgang Graber, Michael Komorek, Angela Kross (Institute for Science Education, University of Kiel, Germany) and Priit Reiska (University of Educational Sciences, Tallin, Estonia), Kluwer Academic Publishers Dordrecht /Boston/ London, 2001, 351p.

- Багш бол оюун ухааны болон зан үйлийг дасгалжуулагч, сурган хүмүүжүүлэгч (trainer, educator)
- Багш бол тухайн шинжлэх ухааны мэргэжилтэн, судлаач (subject matter specialist, scientist)
- Багш бол тодорхой шинжлэх ухааны дидактикч (didactist of subject matter)
- Багш бол боловсролын киррикулимч, сургалтын менежер, тухайн салбарын мэргэжилтэн судлаач (curriculumer, teaching & learning manager, scientist) гэж үеэс үед түүхэн хөгжлийн явцад өөрчлөгдөж байсан хэмээн үзжээ.

Манай нийгэм, бидний амьдарч буй ХХI зуун багш хүний дүр төрхийн тухайд ямар захиалга өгч ямар шаардлага тавьж байна гэдгээс “багш” боловсролын эрэлт хэрэгцээ тодорхойлогдох учраас дээрх зарчим, арга зүйн шинжилгээ, дүгнэлт болон сонголт нь багшлах арга зүйн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх гарааны цэг болох нь ойлгомжтой.

Багшийн хөдөлмөрийн агуулга, чиг үүргийг тодорхойлсон дээрх үзэл баримтлалаас чухам аль нь өнөөдөр Монгол улсын боловсролын хөгжилд илүү нийцтэйг судалж, сонгох асуудал нь онол арга зүй, хөгжлийн бодлого стратеги, хэрэгжилтийн менежмент, эрх зүйн орчны аль алиных нь тухайд Монгол Улсын төрөөс баримтлах бодлого, холбогдох эрх зүйн актуудаар баталгаажин шийдвэрлэгдсээр байгаа билээ.

Хөгжлийн хүчин зүйлсийн өөрчлөлт, үйл явцын их хурдаас шалтгаалан шинжлэх ухаан, технологийн соёлд гарсан парадигмийн өөрчлөлтүүд, мөн түүнчлэн ажил үйлдвэрлэл, ахуй амьдрал, аж төрөх ёсонд ч гарч буй шинэ хандлага нь Монгол улсад багш боловсролын хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулан, багш боловсролын стандарт, киррикулимийг шинэчлэн хөгжүүлэх стратегийг тодорхойлж, тэдгээрийг туршин хэрэгжүүлэх явдал бол манай салбарт зайлшгүй шийдэх ёстой тулгамдсан асуудал-боловсролын шинэчлэлийн бодит хэрэгцээ болоод байна.

Асуудлыг яаж тавихаас шийдлийн үндэслэл, хэрэгжүүлэх арга зам хамаардаг төдийгүй дэвшүүлэх зорилго, зорилт илүү тодордог. Бас зорилтоо хэр бие даан нарийвчилж байгаа нь бидний хөгжиж буйн нэг шалгуур болдог. Иймд бид Монголын боловсролын тогтолцооны шинэчлэлийг эхлүүлж байх тэр цаг үед ийм байдлаар асуудалд хандаж байсан юм. Тэр цаг үед *сургалтын арга зүйг яаж шинэчлэн сайжруулах вэ?* гэсэн асуулт тавигдсан. Нийгмийн болон хүмүүсийн эрхэмлэх үнэт зүйлс, үнэлэмж өөрчлөгдөн хөгжихийн хэрээр боловсролын зорилго, агуулга, сургалтын арга зүй шинэчлэгдэх учиртай. Иймд юуны өмнө боловсролын түлхүүр ухагдахуунуудад анхаарал төвлөрүүлж, боловсролыг шинэчлэн хөгжүүлэхийн тулд дараах асуулт дэвшигдэн гарсан.

1. Хүн яаж суралцдаг вэ?
2. Багш яаж сургадаг вэ?
3. Сургалт гэж юу вэ? Сургалтын арга зүй гэж юуг ойлгох вэ?
4. Иргэний хөгжилд тавигдах нийгмийн захиалга яаж өөрчлөгдсөн бэ?
5. Суралцагчийн хэрэгцээ, сонирхол яаж өөрчлөгдсөн бэ?
6. Багшийн чиг үүрэг яаж өөрчлөгдөх вэ?
7. Стандарт, киррикулим гэж юу вэ? Хоорондоо ямар хамааралтай вэ?
8. Стандарт, киррикулимийн тогтвортой хөгжлийг хангах арга зүйн сонголт ямар ерөнхий зарчим, үндэслэлд тулгуурлах вэ?
9. Сургалтын арга зүйн хөгжлийг хангах ямар стратеги сонгож, ямар таамаглал дэвшүүлэх вэ?

Эдгээр асуултад хариулт олох эрэлд боловсролын салбарын бодлого боловсруулагч, эрдэмтэн судлаачид мордож билээ. Асуултад өгөх хариултын хувьд боловсролын хөгжлийн чиг хандлагад баримжаалсан, шинжлэх ухааны үндэслэлтэй, баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга зүйн шийдэлтэй байх шаардлага тавигдсан. Яагаад гэвэл, өөрчлөлт шинэчлэлийн эхэн үед хуучин систем бүхэлдээ задарч, шинэ систем үүсэх эрх зүйн орчин л дөнгөж бүрэлдэж байсан тул боловсролын хөгжлийн стратеги, хэрэгжүүлэх арга замыг сонгох нь “дэндүү” хариуцлагатай сорилт байсан юм. Хэрвээ боловсролын зорилго, агуулга, арга зүйн хөгжлийн чиг хандлагыг буруу тогтоосон тохиолдолд “Буруу замаар будаа тээвэл, буцахдаа шороо тээнэ” гэгчийн үлгэр болохоор, харин тэдгээрийг дутуу эсвэл, оновчгүй хийвэл “цоорхой шанаганд шингэн хийв” гэгчийн үлгэр болохоор байлаа.

Боловсролын хөгжлийн чиг хандлагад гарч буй өөрчлөлтийн цөм санааг Зураг 1.2-д үзүүллээ. Энэхүү тулгуур дохиог олон сургалтад удаа дараа хэрэглэж

Асуудлыг яаж тавихаас шийдлийн үндэслэл хамаарна.


Багшлах үйлийн онол арга зүйд гарсан өөрчлөлт

Боловсролын хөгжлийн чиг хандлагын тухайд

байсан учир манай салбарынхан сайн мэддэг, бас сургууль, багш нарын үйл ажиллагаагаа шинэчлэх чиг баримжаа болгон хэрэглэдэг гэдэгт итгэж байна. Иймд түүнийг энэ удаа тайлбарлах шаардлагагүй гэж үзлээ.

Боловсролын хөгжлийн талаарх олон улс дахь нийтлэг өөрчлөлтийн чиг хандлага нь суралцахуй, багшлахуйн үйлд ч зарчмын өөрчлөлт хийхэд хүргэсэн билээ. Тухайлбал,

- *Боловсролын зорилго* нь нийгмийн хэрэгцээнээс хувь хүний хэрэгцээнд түлхүү суурилах
- *Боловсролын агуулга* нь судлагдахуунд суурилсан категорчилсан салангид агуулгаас цогц чадамжид суурилсан интеграцчилсан (айлсан) агуулгад
- *Сургалтын арга зүй* нь



Зураг 1.2. Боловсролын хөгжлийн чиг хандлага

- багшлахуйгаас суралцахуйд
- бэлэн мэдээлэл дамжуулахаас шинэ мэдлэг бүтээлгэхэд
- цээжилж суралцахуйгаас хэрэглэж суралцахуйд
- *Үнэлгээ* нь цээжилсэн салангид мэдлэгийг үнэлэхээс мэдлэгийн эзэмшилтийн түвшин, хэрэглээний явцын өөрчлөлтийг үнэлэх шаардлагатай болсон.

Онол, арга зүйн шийдлийн шинжлэх ухааны үндэслэлийн тухайд

Боловсролын шинэчлэл хийхэд тулгарсан асуудлын нэг нь боловсролын үндсэн нэр томьёо, ухагдахуун (Хавсралт: Нэр томьёоны тайлбар) нь танин мэдэхүйн хувьд гүнзгийрэн хөгжиж байдаг үйл явц гэдгийг хүлээн зөвшөөрөх, тэдгээрт парадигмийн шинжтэй ямар өөрчлөлт орсныг мэдэх, улмаар эдгээр ухагдахууны талаарх өмнөх төсөөлөл маань шинэ шинэ өөрчлөлтийг хүлээн авч шинэ мэдлэг, чадвар, хандлага болгоход ямар бэрхшээл тулгарч байна, түүнийг хэрхэн даван туулах вэ гэсэн олон асуудал боловсролын салбарынхны өмнө тавигдсан. Өөрөөр хэлбэл, мэдээллийн нээлттэй шинэ орчинд бид өөрсдийн хур туршлагадаа суурилан шинэ мэдээллийг хэрхэн “ассимляцалж” ойлголтын зөрөөгөө багасгах замаар боловсролын шинэчлэлийн онол арга зүйн оновчтой шийдэл боловсруулах, шинэчлэлийг хэрэгжүүлэхдээ “дуугарвал дуу нэгтэй, дугтарвал хүч нэгтэй” болох явдал зайлшгүй бөгөөд чухал ач холбогдолтой алхам байлаа.

Хүний амьдрал, үйл ажиллагаа, хөгжлийн асуудлыг судалдаг олон салбар ухааны огтолцлын зааг дээр үүсдэг дидактикийн ухаан нь сурагцагчдын нас, сэтгэцийн онцлогт нийцсэн боловсролын агуулга, арга зүй, үнэлгээний шалгуур үзүүлэлт зэргийг сонгон боловсруулах зарчим, арга зүйг тодорхойлдог⁵ (Зураг 1.3.).



Зураг 1.3. Сургалтын онолын цндсцүд

Иймээс ч бид боловсролын стандарт, кинрикулумийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхдээ заавал дидактик боловсруулалт хийх шаардлагатай болдог.

Боловсролын онол, арга зүйн үндсийг бүрдүүлэгч дээр дурдсан шинжлэх ухаануудын хөгжлийн нөлөөгөөрб дидактикийн шинжлэх ухаанд 1980-аад оны үеэс парадигмийн шинжтэй өөрчлөлтүүд гарч, боловсролын хөгжилд томоохон түлхэц үзүүлсэн юм.

⁵ Сургалтын менежмент, Сургалтын материал, УБ, 2000,

⁶ Сургууль, соёлын хөгжлийн шинэ чиг хандлага: Кинрикулум хөгжлийн онол, арга зүй, МУИС, МДССТ, УБ, 2008

Хүн судлалын шинжлэх ухаануудын парадигмийн өөрчлөлтийн огтолцол дээр дидактикт боловсролын нийц, чанарыг дээшлүүлэх олон шинэ арга зүй боловсрогдсон билээ.

Иймээс тэдгээрийг харьцуулан судалж, Монгол Улсын боловсролын агуулга, сургалтын технологийг шинэчлэх үндсэн стратегийг “боловсролын академик талыг бууруулахгүйгээр прагматик талыг хөгжүүлэх замаар агуулгаа цогц чадамжуулж, агуулгын түвшнийг бүхэлд нь эрэмбэ ахиулах” явдал хэмээн томъёолж, түүнийг хэрэгжүүлэхдээ дидактик түвшний дараах стратегийг баримталж ирсэн. Үүнд:

- Агуулга, арга зүйн дидактик нэгжийг томсгох
- Агуулга, арга зүйг элементарчлах
- Бүх түвшинд кирриkyолим боловсруулахдаа шинжлэх ухааны ерөнхий арга судлалын зарчимд тулгуурлах, ТХБ-ын үзэл санаа, агуулгад нийцүүлэх
- Монгол ардын өв уламжлалтай нягт холбох
- Сургалтын менежментийг нээлттэй кирриkyолим тогтолцоонд шилжүүлэх зэрэг болно.

Дидактик түвшний дээрх стратегийг бодитоор хэрэгжүүлж чадваас боловсролын шинэчлэлийн дүнд хүрэх дам болон нөлөөт үр дүнгийн талаар дараах таамаглал дэвшүүлэх боломжтой. *“Хэрвээ бид шинжлэх ухааны орчин үеийн ерөнхий арга судлал болон тодорхой шинжлэх ухааны арга судлалын холбоонд тулгуурлан сургалтын агуулгын судлагдахууны болон ур ухааны харилцан эсрэг гэхээр парадокс талуудын нэгдлийг буюу хөгжлийг оновчтой тодорхойлж, агуулгын дидактик нэгжийг томсгож чадвал сургалтын агуулгын онол (академик)-ын түвшнийг бууруулахгүйгээр сургалтын прагматик шинжийг түлхүү хөгжүүлж, суралцагчдад агуулгын инвариант элементар болох “тогтолцоон” баримжаа эзэмшүүлж, хурдацтай хувьсан өөрчлөгдөж байгаа орчинд асуудлаа шийдвэрлэх бодит чадвартай, бүтээлч, хариуцлагатай иргэн төлөвших гол нөхцөл хангагдана.”*

Монгол улс шинэ зууны соёл иргэншлийг бүтээлцэж, тусгаар тогтнол, эрх чөлөөгөө бэхжүүлсэн жинхэнэ утгаараа бие даасан улс байх уу? Эсвэл, өглөг хандив горьдож, өнөөдрөө л өнгөрөөсөн, элдэвчилсэн болгонд тал зассан бусдын хараат, нэр төдий улс байх уу гэдэг нь олон хүчин зүйлийн шүтэлцээг тайлсан холч мэргэн шийдвэрээс хамаарах боловч ийм шийдвэрийн нэгээхэн үндэслэл нь бусдаас суралцах, өөрийгөө илэрхийлэх, хэрэгжүүлэхийн нэгдлийг хэрхэн хангах тухай асуудал билээ.

Боловсрол нь Монгол улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, ард иргэдийн чанартай амьдралын баталгаа болно гэсэн төрийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх энэ хариуцлагатай цаг үед хөгжлийн зангилаа асуудлуудын бэрхшээлээс халгаж, шантралгүй тэдгээр асуудлаа үйл ажиллагааны цөм болгон барьж ажиллах шаардлага тулгарсан. Ийм асуудлын нэг нь боловсролын стандарт болон кирриkyолим хөгжлийн асуудал байлаа. Монгол улсын Бага, дунд боловсролын үндэсний стандарт, кирриkyолимыг шинэчлэн хөгжүүлэх асуудлын хүрээнд манай салбарын бодлого боловсруулагч, эрдэмтэн судлаач, багш сурган хүмүүжүүлэгчид шинжлэх ухаанч хандлага, арга барил, мэргэжлийн ур чадвараа дайчлан ажиллаж, хамгийн гол нь боловсролд эрэмбэ ахисан чанарын өөрчлөлт гаргаж, цаашдын хөгжил дэвшилд хөтөлж чадахуйц орчин үеийн шинжлэх ухааны үндэстэй, амьдрал, практикт хэрэгжүүлэх боломжтой, стандарт, кирриkyолим шинэчлэлийн шийдлийг боловсруулж, турших шаардлагатай болсон юм.

Боловсролын стандарт нь боловсролын түвшин бүрээр суралцагчийн эзэмшсэн боловсролын чанарыг хэмжих зориулалттай байна хэмээн үзэж, Засгийн газрын 2000 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн “Боловсролын агуулгыг ажилд сургах, амьдралд бэлтгэх, өөрийн орны уламжлалт болон орчин үеийн үйлдвэрлэлийн үндэс суурийг эзэмшүүлэх чиглэлээр шинэчлэх” зорилтыг хэрэгжүүлсэн. Ийнхүү хэрэгжүүлэхдээ сургалтын академик талыг бууруулахгүйгээр, прагматик шинжийг түлхүү хөгжүүлэх стратеги баримталж, боловсролын үйл явцын оролтод суурилж байсан агуулгын стандартыг гаралтад суурилсан боловсролын зорилго, агуулга, арга зүйн зарчим, үнэлгээг харилцан уялдаанд нь тодорхойлсон боловсролын стандарт болгон шинэчлэх зорилттой ажилласан. Өөрөөр хэлбэл, аль нэг улсын болон хэн нэгний бэлэн загвараар гадаад хэлбэрийг нь дуурайж гүйцэтгэх бус шинэ үзэл санаа, дэвшилтэт уламжлалдаа тулгуурлан *хөгжлийн чиг хандлага, шийдлийн үндэслэлээ хамтран боловсруулж, стандартаа хөгжүүлэхэд шаардагдах шинэ мэдлэгээ өөрсдөө бүтээж ажилласнаар* Монгол Улсын боловсролын агуулга, стандарт хөгжлийн түлхэнд эргэлтийн шинжтэй өөрчлөлт шинэчлэл хийсэн юм.

Баримтлах стратеги, хэрэгжүүлэх арга зүйн шийдлийн тухайд

Боловсролын стандартын шинэчлэл

Тухайлбал, шинэ стандартад дараах зарчмын өөрчлөлт⁷ хийгдсэн.

Стандартыг бүтээсэн үндсэн шийдэл

2004 онд Бага, дунд боловсролын стандартад хийгдсэн зарчмын өөрчлөлтийг ерөнхийлөн дүгнэж Хүснэгт 3.1-ээр үзүүлэв. Бид боловсролын удирдлагын төвлөрлийг сааруулах, сургалтын нээлттэй киррикулимийн хөгжлийг дэмжих бодлогын хүрээнд шинээр төлөвшиж буй тогтолцооныхоо мөн чанарт нийцүүлэн стандартаа шинэчлэн сайжруулахдаа боловсролын гүн ухаан, сэтгэл судлал, мэдлэгийн онол, дидактик, менежментийн шинжлэх ухааны үндсүүдэд тулгуурлан дараах цогц шийдлийг хийсэн. Үүнд:

- Боловсрол нь хүний мэдлэг, чадвар, хандлага, төлөвшилд чанарын хувиргалт хийгддэг тасралтгүй үйл явц байна.
- Боловсролын үйл ажиллагаа нь боловсролын хэрэгцээ, зорилго, агуулга, арга зүй, үнэлгээ, орчин нөхцөл бүхий тогтолцоо байна.
- Боловсролын чанар нь суралцагчдын эзэмшсэн цогц чадамжаар үнэлэгдэнэ.
- Боловсролын хэрэгцээ нь хувь хүний хөгжил, нийгмийн эрэлт хэрэгцээгээр тодорхойлогдоно.
- Боловсролын зорилго нь суралцагчдад цогц чадамж төлөвшүүлэхэд оршино.
- Боловсролын агуулга нь цогц чадамж төлөвшүүлэхээр сонгогдож, бүтэцчилэгдсэн байна.
- Боловсролын стандартчлал нь суралцагчдын эзэмшсэн боловсролын шатлал, танин мэдэхүйн түвшнийгээр тогтоогдоно.
- Боловсролын арга зүйн үндэс нь суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх дидактик зарчмууд байна.
- Цогц чадамжийн төлөвшил нь суралцагчийн танин мэдэхүйн түвшний шалгуур, таксономийн онолын үйлийн үзүүлэлтээр үнэлэгдэнэ.

Хүснэгт 3.1. 1998 болон 2004 оны стандартуудын харьцуулалт

Агуулгын стандарт Судлагдахуун төвтэй	Боловсролын стандарт Цогц чадамж төвтэй
<ul style="list-style-type: none"> • Боловсролын үйл явцын оролтод суурилсан, зөвхөн судлагдахууны агуулгыг стандартчлах замаар киррикулим боловсруулж хэрэгжүүлэх үндсэн дээр суралцагчдын эзэмшсэн мэдлэг чадварыг үнэлэхэд чиглэсэн 	<ul style="list-style-type: none"> • Боловсролын үйл явцын гаралтад суурилсан, сургалтын бүх бүрэлдэхүүн хэсгийг стандартчилах замаар боловсролын чанарыг суралцагчдад төлөвшсөн цогц чадамжаар хэмжиж, киррикулимийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх үйлийг хөгжилд хөтлөхөд чиглэсэн
<ul style="list-style-type: none"> • Судлах агуулга нь тухайн шинжлэх ухааны болон ажил үйлийн судлагдахуунд суурилсан. • Боловсролын шатлал бүрийн агуулга нь тухайн шинжлэх ухааны түүхэн хөгжилд суурилсан бүтэцтэй, эзэмших мэдлэг, чадвар нь тухайн бүлэг, сэдвийн хүрээгээр хязгаарласан агуулгын тогтолцоотой. • Судлах агуулгыг судлагдахуунд баримжаалж, цөм хөтөлбөрийн хүрээнд сургууль багш нар өөрсдөө баяжуулж хэрэгжүүлэх боломжтой 	<ul style="list-style-type: none"> • Судлах агуулга нь суралцагчийн чанартай, хариуцлагатай, бүтээлчээр сурч, ажиллаж, амьдрахад нь зайлшгүй шаардлагатай цогц чадамжид суурилсан. • Агуулгын нэгжийг томсгон айд багцалж, агуулгын айг шатлал бүрд инвариант байхаар бүтэцчилсэн, ай бүрийн хүрээнд эзэмших мэдлэг чадвар нь хэрэглэгдэж байх шатлан эрэмбэлэгдсэн агуулгын тогтолцоотой. • Судлах агуулгыг цогц чадамжид баримжаалж, агуулгын айн хүрээнд сургууль, багш нар өөрсдөө сонгож хэрэгжүүлэх боломжтой.
<p>Арга зүйн хувьд:</p> <ul style="list-style-type: none"> • Багшийн заах, номлох үйл ажиллагаанд төвлөрсөн • Мэдээлэл дамжуулах технологи илүү шаардсан • Судлагдахууны түвшинд категоричилсан агуулгыг эзэмшүүлэх цээжлэн тогтоох арга зүй давамгайлсан 	<p>Арга зүйн хувьд:</p> <ul style="list-style-type: none"> • Сурагчийн суралцах үйл ажиллагаанд төвлөрсөн • Мэдлэг бүтээлгэх технологи илүү шаардсан • Цогц чадамжийн түвшинд интеграцчилсан агуулгыг эзэмшүүлэх мэдлэгээ хэрэглэх арга зүй давамгайлсан
<ul style="list-style-type: none"> • Үнэлгээ нь судлагдахууны жагсаалтын дагуу эзэмшсэн салангид мэдлэг, чадварыг түвшин бүрд нарийвчлан хэмжээсжүүлээгүй ерөнхий үзүүлэлтээр илрүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Үнэлгээ нь цогц чадамж бүрийг танин мэдэхүйн түвшин бүрийн тодорхой шалгуураар үнэлж илрүүлэх
<ul style="list-style-type: none"> • Киррикулим нь хичээл заах, цалин авах эрх олгодог баримт бичиг гэж үзэх 	<ul style="list-style-type: none"> • Киррикулим нь боловсролын чанарыг дээшлүүлэх үйл явц, хүчин чармайлт гэж үзэх
<ul style="list-style-type: none"> • Стандарт нь агуулгын ерөнхий шаардлагыг тодорхойлоход чиглэгдсэн 	<ul style="list-style-type: none"> • Стандарт боловсролын үйл ажиллагааны бүтэцчилсэн хүрээг тодорхойлоход чиглэгдсэн


⁷ Н.Нэргүй, Бага, дунд боловсролын стандартчлалын үзэл баримтлал, Бага, дунд боловсролын стандартын ерөнхий зөвлөмж, УБ, 2003, хх 5-23

Эдгээр шийдлийн тогтолцоонд тулгуурлан стандарт ба кирриkjолимийн агуулгыг дараах байдлаар тодорхойлсон.

Боловсролын стандартыг агуулга, мөн чанарынх нь хувьд, нийгмийн хөгжлийн захиалга, хувь хүний хэрэгцээг хангах боловсролын үйл ажиллагааны чанарын түвшнийг тогтоохын тулд тухайн шатлалын, тухайн агуулгын боловсролын зорилго, агуулга, арга зүйн үндэс, орчин нөхцөл, үнэлгээнд бүхэлд нь зайлшгүй тавигдах наад захын жишиг шаардлагын тогтолцоо, харин хэлбэрийнх нь хувьд энэ тогтолцоог тодорхойлсон норматив баримт бичиг гэж тодорхойлсон.

Харин *боловсролын кирриkjолимийг* стандартын шаардлагыг хангахын тулд Монголын нийгэм болон дэлхий нийтийн дэвшилтэт соёлын үнэт зүйлсээс сургууль боловсролын байгууллагаар дамжуулан иргэддээ эзэмшүүлэхээр тусгай зөвлөмжийн дагуу сургууль, багш нараас сонгосон тодорхой зорилго, агуулга, арга зүй, орчин, үнэлгээ бүхий сургалтын үйл ажиллагааны тогтолцоо гэж үзсэн.

Ийнхүү бид боловсролын чанарын асуудлаар гаргасан анхны суурь шийдэлдээ “Боловсролын стандарт нь боловсролын аливаа кирриkjолимийн чанарыг үнэлэн түүнийг хөгжилд хөтөлж чадахуйцаар бүтээгдэж, харин боловсролын кирриkjолим нь стандартаар чанараа үнэлүүлэн хөгжсөөр байхаар боловсрогдож байна.” хэмээн тэдгээрийн харилцан хамаарлыг тодорхойлсон билээ. (Зураг 3.1.).



Зураг 3.1. Боловсролын стандарт ба кирриkjолимийн шүтэлцээ

Багшлах арга зүйг стандартчилж болохгүй ч цогц чадамжид суурилсан боловсролын стандартыг хэрэгжүүлэхэд баримтлах *сургалтын арга зүйн үндсэн зарчмууд, тэдгээрийн агуулгыг* тодорхойлж, шинэ стандартын нэг бүрэлдэхүүн хэсэг болгон боловсруулсан (Хүснэгт 3.2.).

Хүснэгт 3.2. Стандартыг хэрэгжүүлэх арга зүйн зарчмууд

Зарчим	Зарчмын утга санаа-агуулга
Боломжийг тэнцүү олгох зарчим	<ul style="list-style-type: none"> • Боловсрол эзэмших боломж адил тэгш байх • Суралцагчдыг боловсрол эзэмшүүлэх үйл явцад нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн байдал, яс үндэсээр нь ялгаатай байдлаар нь ялгаварлахгүй байх
Судлах агуулгыг сонгох зарчим	<ul style="list-style-type: none"> • Судлах агуулгыг кирриkjолим өөрчлөлтөнд инвариант байхаар, хувь суралцагчийн хэрэгцээ, сонирхолд тулгуурлан, танин мэдэх боломжийг нь харгалзсан байхаар, шинжлэх ухаанч байхаар сонгох
Багшлахуйн зарчим	<ul style="list-style-type: none"> • Багшлах арга зүйн аливаа шийдлийг боловсролын философи, боловсролын психологи, мэдлэгийн онол, менежмент, эрүүл ахуй, дидактик, боловсролын бодлого зэрэг шинжлэх ухааны зарчимд нийцүүлэн боловсруулж байх
Суралцахуйн зарчим	<ul style="list-style-type: none"> • Сурахуйг танин мэдэхүйн үе шат бүхэнд тодорхой хууль зүй тогтлын дагуу сэрэхүй, хүртэхүй, бодохуй, мэдэхүй, хэлэхүй, учирлахуй, асуудал шийдвэрлэхүй зэрэг танин мэдэхүйн бусад процесстой нягт уялдаа холбоотой явагддаг оюуны үндсэн үйл явц хэмээн үзэх
Технологийн зарчим	<ul style="list-style-type: none"> • Бага, дунд боловсролыг иргэдэд эзэмшүүлэхэд орчин цагийн мэдээлэл, харилцааны технологийг ашиглах • Иргэдийг мэдээлэл харилцааны технологийн хэрэглэгч болгон бэлтгэх
Үнэлгээний зарчим	<ul style="list-style-type: none"> • Суралцагчийг үнэлэх ажлын зорилго нь тэднийг хөгжүүлэхэд чиглэсэн байх • Суралцагчийн хөгжил, төлөвшлийг тэдний танин мэдэхүйн үйл ажиллагааны чанарын ахицаар үнэлэх

Өнөөдөр Монголын багш нар *боловсролын болон төрийн албаны хоёр том салбарын шинэчлэлийн* үйл явцын дунд ажиллаж, амьдарч байна. Тухайлбал,

- Төрийн албаны ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох, албан тушаалын үндсэн чиг үүргийг хуульчлах, ажлын байрны тодорхойлолтыг тухайн албан тушаалын үндсэн чиг үүрэгт нийцүүлэн боловсруулах, ажлын ачаалал,

Багшлах үйлийн хууль, эрх зүйн орчинд гарсан өөрчлөлт

нормативийг шинэчлэн тогтоох, цалин хөлсний доод жишгийг салбар бүрээр тогтоох, салбарын шинэчлэлийн бодлоготой уялдуулан нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох зэрэг шинэчлэл хийгдсэн.

- Боловсролын салбарт боловсролын агуулгыг шинжлэх ухааны судлагдахуунаас хүний тогтвортой сурч, ажиллаж, амьдрахад шаардлагатай цогц чадамжид хувирган өөрчилж, олон улсын жишигт хүргэх, сургалтын технологийг бэлэн мэдээлэл дамжуулахаас суралцагч өөрийн үйл ажиллагаагаараа шинэ мэдлэг бүтээлгэдэг болгон өөрчлөх, боловсролын менежмент болон сургалтын технологид мэдээлэл харилцааны технологийг нэвтрүүлэх, сургуулийн арван жилийн тогтолцооноос 11, 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх, хүн амын бүлэг бүрийн нийгэм, эдийн засаг, соёлын ялгаатай байдлаас үл хамааран суралцагч бүрийг чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор хангах зэрэг зэрэгцсэн, цогц өөрчлөлт хийгдэж байна.

Боловсролын салбарт хийгдэж буй тогтолцооны мөн чанартай холбоотой дээрх цогц өөрчлөлтийн хувь заяа эцсийн дүндээ сургууль, анги танхимийн түвшний үйл ажиллагааны чанар, өөрөөр хэлбэл, цогц шинэчлэлийн онол арга зүйн үзэл баримтлалд суурилсан багшийн хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлого, түүний хэрэгжилтийн менежмент төдийгүй багш нэг бүрийн гүйцэтгэлийн чанараас шууд хамаарах нь ойлгомжтой. Иймд Монголын төрөөс өөрчлөлт шинэчлэлийн он жилүүдэд багшийн хөгжлийн асуудлаар тодорхой бодлого

ЗГ-ын тогтоол	БСШУ-ны сайдын тушаал
<ul style="list-style-type: none"> • “Төрийн албан тушаалын ангилал, зэргэлэл” 2007 оны 354 • “Төрийн албан хаагчын цалингийн сүлжээ, доод жишиг” 2010 оны 239 • “Боловсролын салбарын албан хаагчдын нэмэгдэл хөлсний хувь хэмжээ” 2007 оны 219, 2010 оны 148 • “Багш бэлтгэх мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр” 2008 оны 316 • “Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал” 2008 оны 54 	<ul style="list-style-type: none"> • “ЕБС, цэцэрлэгийн багшийн ёс зүйн дүрэм” 2007 оны 41 • “Ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт” 2007 оны 354, 179 • “Улс, аймаг, нийслэлийн “Оны тэргүүний багш” шалгаруулах болзол, түүнийг дүгнэх аргачлал 2007 оны 440 • “Багш ажилтны мэргэжил дээшлүүлэх журам” 2008 оны 72 • “Багшийн мэргэжлийн зэрэг олгох, хасах журам” 2008 оны 73 • “Багшлах эрх олгох, хасах журам” 2008 оны 74 • “Багшийн хөгжлийн танхмын стандарт” 2008 оны 114 • “Хүний нөөцийн үр чадварыг дээшлүүлэх 2010-2012 он үйл ажиллагааны төлөвлөгөө” 2009 оны 555 • “Багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэх аргачлал” 2009 оны 561
Хамтарсан тушаал	
<ul style="list-style-type: none"> • “ЕБС, цэцэрлэгийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцох, олгох журам” 2007 оны 307/91/237 • ЕБС, цэцэрлэгийн багш, зарим албан тушаалтанд үр чадварын нэмэгдэл олгох шалгуур, үзүүлэлт” 2010 оны 326/112/183 	

Зураг 1.4. Багшлах эрх зүйн орчны шинэчлэл

баримтлан хэрэгжүүлсээр ирсэн. Ялангуяа, дээр дурдсан сургуульд суралцах хугацааг нэмэгдүүлэх, сургалтын агуулга, арга зүй, технологи дахь зарчмын өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд багшийн оролцоог зохицуулсан хууль, эрх зүйн шинэ орчныг 2007 оноос эхлэнбүрдүүлж мөрдүүлэх талаар УИХ, ЗГ, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас цогц шийдвэр гарган ажиллаж байгаа билээ (Зураг 1.4).

Эдгээр шийдвэр нь асуудлын дараах хүрээг хамарсан. Үүнд:

- Багшийн албан тушаалын ангилал зэрэглэл (албан тушаалын ангилал, зэрэглэл)
- Багшийн ажлын агуулга, бүтэц, норм норматив (багшийн ажлын байрны тодорхойлолт: ажлын агуулга, бүтэц, норм, нэгж)
- Багшлах эрх, багшийн ёс зүй
- Багшийн мэргэжлийн үр чадварын хөгжил (мэргэжил дээшлүүлсэн байдал, мэргэжлийн зэрэг, үр чадвар)
- Багшийн ажиллах орчин (багшийн ажлын байрны нөхцөл, интернэт, бусад)
- Багшийн ажлын төлөвлөлт, үнэлгээ (хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээ, багшийн ажлын төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, дүгнэлт)
- Багшийн цалин хөлс (үндсэн цалин нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал)
- Багшийн нийгмийн хамгаалал (амралт, нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, тэтгэмж, тэтгэвэр, хөнгөлөлттэй зээл)

1.3. Багшлах үйлийн ур чадварт тавигдах шинэ шаардлага

Багшийн хөгжлийн асуудал нь угтаа багшийн ур чадварын өөрчлөлтийн асуудал юм. Багшийн ур чадварын хөгжлийг боловсрол, нийгэм, хүн төрөлхтний хөгжлийн харилцан хамааралд авч үзэх нь зохистой.

Багшлах үйлийн ур чадварын хөгжил



Энэ хэсэгт зөвхөн киррикулимийн хөгжил нь багшийн ур чадварын өөрчлөлттэй ямар холбоотойг товчхон тодруулахыг хичээе. Хүн соёлын болон бодит ахуйн орчинд амьдарч, соёлд суралцан соёлоо бүтээлцэж байдаг. Нийгэм нь соёлыг эзэмшүүлэх хөгжүүлэх шашин, урлаг, боловсрол гэх мэт олон институттэй байдаг бөгөөд үүнээс сургууль, боловсролоор дамжуулан эзэмшүүлэх соёлыг киррикулим тогтолцоо буюу сургалтын хөтөлбөр хэмээн үздэг. Олон төрөл, хувилбарын киррикулим байдгаас орчин үед *тогтвортой хөгжлийн агуулга, арга зүйд суурилсан нээлттэй киррикулимийн үзэл санаа* давамгайлж байгааг дээр дурдсан. Энэ киррикулим нь амьдралд бүх хүмүүсийн бодит оролцоо зайлшгүй бөгөөд ингэж оролцохдоо өөрийнхөө болон бусдын төлөө хариуцлага хүлээх чадвартай, бүтээлч иргэн болж төлөвших явдал сурч боловсрохын зорилгыг тодорхойлно гэсэн үзэл санаанд тулгуурладаг. Хэрэв бид киррикулимийн энэ төрлийг сонговол, багшийн ур чадварт тавигдах шаардлага ихээхэн өөрчлөгдөх болно. Өөрөөр хэлбэл, өмнө нь хичээлийг тухайн шинжлэх ухааны түүхэн хөгжилд суурилсан бүтцийн дагуу тайлбарлан *зааж сургадаг багшийн ур чадварыг* илүүд үздэг байсан бол одоо хүүхдийг бодит чадвартай, хариуцлагатай, бүтээлч иргэн болж төлөвшүүлэхийн тулд тэдэнд нийгэмших явцдаа суралцаж, *идэвхтэй цйлээр өөртөө хэрэгцээтэй шинэ мэдлэгээ бүтээхэд нь дэмжин туслах ур чадварыг* тэргүүлэх ач холбогдолтой гэж үзнэ гэсэн үг.

Шинэ киррикулимийг хэрэгжүүлэгч багш нь

- тодорхой шинжлэх ухааныхаа салбарт сайн мэргэжилтэн
- хүний сэтгэл оюуныг эзэмдэгч сэтгэл зүйч
- киррикулимээ байнга хөгжүүлэгч судлаач
- хүнийг хөгжүүлэх арга техникийг гарамгай эзэмшсэн технологич
- сургалтын үйл ажиллагааг чанартай, үр ашигтай зохион байгуулагч менежер зэрэг олон мэргэшлийн ур ухааныг төгс эзэмшсэн *“цаг үеэ дагуулсан дархан”* хүн шиг байх ёстой болж байна. “Багш” бол мэргэшил биш мэргэжил. Дээр дурдсан олон мэргэшлийн мэдлэгийг зүйж эвлүүлснээр бус суралцагчаа хөгжүүлэх үйл ажиллагаандаа энэ олон талт мэдлэгээ бүтээлчээр хэрэглэх ур чадварт суралцсанаар Багш мэргэжлийг эзэмших нь ойлгомжтой. Өөрөөр хэлбэл,

Багшлах үйлийн ур чадварт тавигдах шинэ шаардлага

Энэ цаг үеийн багш мэргэжлийн ур чадварын өөрчлөлт нь олон шинэ салбар ухаанаар өргөжин тэлж, багшлах арга зүйн эрэмбэ ахин гүнзгийрэх үйл явцаар тодорхойлогдож байна.

Ер нь багш мэргэжлийн ур чадварын өөрчлөлт тасралтгүй явагдах үйл явц бөгөөд энэ тухай манай нэрт яруу найрагч Ш.Сүрэнжав гуайн “Багш” найраглалд шүлэглэсэн ахмад үеийн багш, шинэ үеийн багшийн ур чадварын харьцуулалтаас бид сайн мэдэх билээ.

Иймд юуны өмнө багш боловсролын стандарт киррикулимийг сургалтын шинэ парадигмийн үзэл санаанд тулгуурлан шинэчлэн хэрэгжүүлэх нь багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааны тулгамдсан зорилтын нэг байсаар

байна. Ялангуяа, одоо ажиллаж байгаа багш нарынхаа мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг зохих ёсоор институтчилж, харилцан уялдаа холбоо бүхий модулийн систем боловсруулан бүтээж, багш нэг бүрийн арга зүй шинэчлэгдсэн байхаар мэргэжил дээшлүүлэх менежментийн бодлогоо тодорхойлж, түүндээ тохирсон сургалтын олон загварыг сонгон хэрэгжүүлэх замаар бид боловсролын чанар, үр ашгийг дээшлүүлэн ахиц гаргаж чадна.

1.4. Багшлах арга зүйн шинэчлэлийн менежмент

Багшлах арга зүйг шинэчлэх стратеги

Сургалтын арга зүй гэдгийг зөвхөн заах арга бус, сургалтын тогтолцоог бүхэлд нь шинэчлэх бүхий л үйл ажиллагааг гүйцэтгэх аргын тогтолцоо гэсэн өргөн утгаар ойлгож, сургалтын технологийн шинэчлэл буюу сургалтын арга зүйн шинэчлэлд гарч буй *шинэ хандлага, аргын талаар маш тодорхой баримжаатай* байлгах зорилгоор 1999-2001 оны хооронд багшлах арга зүйг шинэчлэх дараах стратеги тодорхойлогдсон. Үүнд:

- Аливаа асуудалд *хөгжлийн* үүднээс, өөрөөр хэлбэл, үйл явц талаас нь түлхүү хандах
- Хөгжлийн тасралтгүй явцыг хангаж байхаар сонирхогч бүх талын оролцоог нээлттэй байлгах
- Шинэчлэлийн талаар шийдэл, шийдвэр гаргахдаа нэг талыг барьж туйлшралгүй тухайн асуудлыг нөхцөлдүүлэгч нөгөө талтай нь холбох буюу хөгжлийг хангагч *парадоксын* зарчимд тулгуурлах
- Шинжлэх ухааны ерөнхий арга судлалын зарчим (тогтолцооны шинжилгээ), арга барилуудыг оновчтой хэрэглэн хичээл хоорондын холбоог хангах
- Сургалтын агуулгын багтаамжийг ихэсгэх, чанар, үр ашгийг дээшлүүлэхийн тулд сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний аль алиных нь дидактик нэгжийг томсгох
- Киррикулим тогтолцооны инвариантад суурилсан нээлттэй киррикулимийг хөгжүүлэх
- Багшийн ч, суралцагчийн ч үйл ажиллагааг шинжлэн судлах мөн чанартай, хамтын, бүтээлч шинжтэй болгон өөрчлөх зэрэг болно.

Багшлах арга зүйг шинэчлэх менежмент

Багшлахуйн арга зүйн шинэчлэлийн менежмент нь бусад менежментийн нэгэн адил (i) бодлого, төлөвлөлт, (ii) хэрэгжилтийн зохицуулалт, (iii) манлайлал, (iv) мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ гэсэн хэсгүүдтэй байх нь ойлгомжтой.

Бодлого, төлөвлөлт

Багшийн хөгжлийн талаар баримтлах бодлогоо тодорхойлох, төлөвлөгөөгөө боловсруулж батлах, үйл ажиллагаагаа хөтөлбөржүүлэхийн тухайд:

Мастер төлөвлөгөө боловсруулах эхний үе шатны ажлын хүрээнд 2005 онд “*Бүх нийтийн боловсролын орчлын нэгдсэн үнэлгээ*” ба “*Салбарын нөхцөл байдлын судалгаа*”-г тус тус явуулсан. Эдгээр судалгаагаар боловсролын салбарын өнөөгийн төлөв байдал, хөгжлийн чиг хандлага, олон эрэмбийн хүчин зүйлсийн нөлөөллийг тус тус тодорхойлох замаар салбарын оношилгоо хийгдсэн. Энэхүү үнэлгээ, оношилгоонд тулгуурлан “*Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө*” боловсруулж, Засгийн газрын 2006 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. Түүнчлэн УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолоор “*Монгол Улсын мянган хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого*” батлагдсан билээ. Эдгээр стратегийн баримт бичгүүдэд 2006-2015, 2016-2021 гэсэн хөгжлийн хоёр үе шатанд баримтлах боловсролын хөгжлийн бодлого, стратеги, төлөвлөгөө тодорхойлогдсон юм. Боловсролын шинэчлэл, хөгжлийн талаар баримтлах бодлого, стратеги, хэрэгжүүлэх үйл ажиллагаа тодорхой болж, улсын төсөв болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэж, боловсролын нийлүүлэлтэд тодорхой ашиг сонирхол бүхий оролцогчдын оролцоо нээлттэй болсон тэр цаг үед боловсролын шинэчлэлийн хувь заяаг шийдвэрлэгч багш нартайгаа дэвшүүлсэн зорилтуудаа хэрхэн хэрэгжүүлж, тулгамдсан асуудлаа хэрхэн шийдвэрлэх, арга замын талаар хэлэлцэж зөвлөлдөхөөр БСШУЯ-аас *Багш нарын улсын зөвлөгөөнийг* зохион байгуулах санаачилга гаргасан. Яамны энэ санаачилгыг Засгийн газар дэмжиж, тус зөвлөгөөнийг 2007 оны 4 дүгээр сарын 26-27-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан юм. Багш нарын улсын зөвлөгөөнөөр БСШУ-ны сайд Ө.Энхтүвшнийгийн тавьсан “Боловсролын шинэчлэлийг гүнзгийрүүлж, багшийн манлайллыг дээшлүүлэе” сэдэвт илтгэлийг хэлэлцэж, боловсролын шинэчлэл, багшийн хөгжлийн тулгамдсан олон асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар зөвлөгөөний төлөөлөгч 272 багш санал бодлоо илэрхийлсэн нь уг зөвлөгөөний ажил хэрэгч чанарыг тод илэрхийлдэг.

Багшийн хөгжлийн зорилтуудыг бодит үйл хэрэг болгоход тодорхой дэмжлэг болохуйц бие даасан үндэсний хөтөлбөртэй болох талаар дээрх зөвлөгөөнөөс гаргасан багш нарын санаачилгыг дэмжиж, БСШУЯ-аас “Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр” боловсруулан Засгийн газрын 2008 оны 316 дугаар тогтоолоор батлуулуулан хэрэгжүүлж байна. Үндэсний хөтөлбөрийг 2008-2015 онд хэрэгжүүлэх бөгөөд, дараах хоёр гол зорилтыг хүрээнд 12 товлосон зорилт, 55 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан болно. Үүнд:

- “Багш” боловсролын зорилго, агуулгын өөрчлөлт, бага, дунд боловсролын чанарыг тасралтгүй сайжруулж байх хэрэгцээ шаардлага, ерөнхий боловсролын сургуулийн бүтэц, хэмжээ, хэв шинжийн онцлогт нийцсэн, багшийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтэд баримжаалсан, багш бэлтгэх нээлттэй, уян хатан, тогтвортой тогтолцоог бүрдүүлж төлөвшүүлэх;
- Нийгмийнхээ аж төрөх ёсонд нийцсэн, багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих бодит хэрэгцээнд нь суурилсан, сургууль төвтэй мэргэжил дээшлүүлэх нээлттэй, сонголттой, тогтвортой тогтолцоог хөгжүүлэх;

Багшийн хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэх, бүтэц, зохион байгуулалтаар хангах, хүчний нөөцөө чадавхжуулалтын тухайд:

Хэрэгжилтийн зохицуулалт

Дээр дурдсан хөгжлийн стратеги, урт, дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгасан багшийн арга зүйг шинэчлэх, ур чадварыг нэмэгдүүлэх, тэдний өөрийн ажил хөдөлмөртөө хандах хандлага, хариуцлагыг шинэчлэх, тэдэнд үзүүлэх нөлөөллийн механизмуудыг боловсронгуй болгох, багш ажлын байрандаа мэргэжил дээшлүүлэх, ээлжит хичээлдээ чанартай бэлтгэх нөхцөлийг бүрдүүлэх, багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэх ажиллагаагаа “Төрийн албаны тухай” болон “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн зарчмууд, боловсролын салбарын шинэчлэлийн бодлого, багшийн ажлын онцлогт нийцүүлэх зорилттой эрх зүйн цогц шинэчлэлийг 2007-2010 онд хийсэн (Зураг 1.4.).

Эдгээр журам, эрх зүйн баримт бичгүүдэд бага, дунд боловсролын суурь шинэчлэл болох цогц чадамжид суурилсан боловсролын шинэ стандарт болон 12 жилийн сургалтад шилжих сургалтын шинэ төлөвлөгөө, үндэсний киррикилюмийг хэрэгжүүлж, боловсролын чанар, нийц, хүртээмжийг нэмэгдүүлэхэд салбарын гол нөөц болох сургалтын байгууллагын багш, удирдах болон мэргэжлийн албан хаагчдын үйл ажиллагааг чиглүүлэхэд чиглэсэн дараах шийдлийг хийсэн. Үүнд:

- Багш нэг бүрд тэгш боломж олгосон мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг төрөөс хариуцан тодорхой хугацааны давтамжтайгаар явуулдаг болох
- Боловсролын хөгжлийн хэрэгцээ, сургалтын технологид гарч буй өөрчлөлтийн шаардлагыг хангаж байх түвшинд багш тасралтгүй суралцаж байх боломж олгохоор сургуульд суурилсан мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлэх
- Багшийн ажлыг хэмжих нэгжийг томсгож, тэдний ажлаа төлөвлөх, үнэлэх аргыг өөрчлөх үндсэн дээр багшийн анхаарал, бүхий л хүч, боломжийг боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд төвлөрүүлдэг болгох,
- Тэдний бүтээлээ сурталчилж, туршлагаа хуваалцаж хамтран ажиллах сонирхлыг төрүүлэх замаар багшлах арга зүйн шинэчлэлийг түгээн дэлгэрүүлэх дотоод механизмтай болох
- Багш, ЗАН, Багш нарын зөвлөлийн оролцоог нэмэгдүүлэх замаар сургууль дээрх шийдвэр гаргах эрх мэдлийн төвлөрлийг сийрэгжүүлэх, шилжүүлэх
- Мэргэжлийн ур чадварын өсөлт, сургалтын чанар, цалин хөлс, ажлын байрны төлөө нээлттэй, шударга өрсөлдөх механизмууд бий болгох
- Цалин хөлсний тэгш байдлыг хангах зэрэг болно.
- Багшлах үйлийн эрх зүйн орчны цогц шинэчлэлийн салшгүй хэсэг нь багш хангалтын талаар баримтлах дээрх бодлогуудыг, хэрэгжүүлэхэд шаардлагатай нөлөөллийн хөшүүргүүд, манлайллын арга механизм, зохион байгуулалтын арга хэлбэрийн шинэчлэл гэж үзэж боловсронгуй болгосоор ирсэн билээ. Тухайлбал,
- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журмыг шинэчилж, сургууль, цэцэрлэгийн багшийн ажил нь сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын стандартыг хэрэгжүүлэх ажил ба бусад

ажил гэсэн үндсэн хоёр хэсэгтэй, эхний хэсэг нь сургалтын хөтөлбөрөө (киррикюлим) төлөвлөн боловсруулах, сургалтын хөтөлбөрийн дагуу хичээлээ заах, хөтөлбөрийнхөө хэрэгжилтийг үнэлэх гэсэн 3 үе шаттай ажлаас, хоёр дахь хэсэг нь сургалтын үйл ажиллагааг дэмжих, багшийн хөгжлийг хангах, иргэд, нийгэмтэй харилцах гэсэн 3 төрлийн ажлаас тус тус бүрдсэн бүтэц, агуулгатай байхаар тодорхойлсон. Түүнчлэн сургалтын хөтөлбөр боловсруулах, уг хөтөлбөрөөр хичээл явуулах, түүнийгээ үнэлж сайжруулах дидактикийн цогц үйл ажиллагааг сургуулийн багшийн сургалтын нэгж ажил гэж тооцож, хичээлийн төлөвлөлтийг 40-45 минутаар биш, тухайн хичээлийн онцлогтойгоор дидактик нэгжийг томсгож, дундажаар 5 орчим ээлжит хичээлээр тооцон, нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байх зарчмын том өөрчлөлт оруулсан. Энэ нь мэдлэг бүтээлгэх технологийг сургалтад нэвтрүүлж, багшлах арга зүйн шинэчлэхэд багшийн ажлын шинэ менежмент нэвтрэхэд хүргэсэн. Түүнчлэн багш “Хөдөлмөрийн тухай” хуулийн дагуу долоо хоногт 40 цаг ажиллаж, ажлын 34 цагтай тэнцэх стандартыг хэрэгжүүлэх ажил (үүний 19 цаг нь хичээл заах цаг), хөдөлмөрийн гэрээгээр зохицуулсан 6 цагтай тэнцэх бусад ажлыг тус тус гүйцэтгэхээр шинэ норм тогтоож журамласан.

- Багшийн ажлын шинэ агуулга, бүтэц, нэгжид тулгуурлан ерөнхий боловсролын сургуулийн багш, сургалтын менежер, ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтыг тус тус шинэчлэн боловсруулсан бөгөөд багшийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтод орсон өөрчлөлт нь багшийн үндсэн ба нэмэгдэл ажил, улмаар үндсэн цалин, нэмэгдэл хөлсний ялгааг тодруулах боломж олгосон. Багшийн ажлын агуулга, бүтэц, хэмжих нэгжийг ийнхүү өөрчилснөөр багш “Боловсролын тухай” хуульд заасан багшийн үндсэн үүрэг болох стандартыг хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа төвлөрч, багш ажлаа бодитоор төлөвлөж, гүйцэтгэлээ ил тод, шударга үнэлж дүгнүүлэх үндсэн дээр цалин хөлсөө тооцуулан авах шинэ тогтолцооны үндсийг бүрдүүлэх зэрэг шийдэл хийгдэж, тэдгээр нь эрх зүйн багц актаар⁸ нарийвчлагдсан болно.
- Багшлах эрхтэй холбоотой журамд оруулсан өөрчлөлт нь багшаас тасралтгүй суралцан нарийн мэргэшиж, өндөр ур чадвартай байхыг шаардсан, багшийн мэргэжлийн онцгой шинж чанарыг багшлах эрхээр дамжуулан ажлын байрны эрэлт, нийлүүлэлтийн чанарын түвшнийг дээшлүүлэх үндсэн шалгуур байлгах бодлогын илэрхийлэл юм. Өөрөөр хэлбэл, шинжлэх ухааны бэлэн мэдээлэл дамжуулах сургалтын арга зүй давамгайлж байсан нөхцөлд тухайн шинжлэх ухааны салбарын сайн мэргэжилтэн сайн багшид тооцогддог байсан бол суралцагчийн өмнөх төсөөллийг оношилж, тэдний онцлогт тохируулах үйл ажиллагаагаар нь мэдлэг бүтээлгэх сургалтын арга зүй шаардагдах болсон өнөөгийн нөхцөлд салбарын сайн мэргэжилтэн багшлах боломжгүй бөгөөд багш бүр ерөнхий болон тусгай дидактикийн боловсролыг зайлшгүй эзэмшсэн байх шаардлагатай. Тэгээд ч боловсролын зэрэгцсэн, цогц шинэчлэл хийгдэж байгаа өнөө үед багш клиник орчиндоо тасралтгүй ажиллахгүйгээр шинэ арга зүйд суралцах боломжгүй юм.
- Багшийн мэргэжлийн зэрэг нь боловсролын чанарыг дээшлүүлэх дотоод арга механизм гэхээсээ илүү цалин хөлс нэмэгдүүлэх арга хэрэгсэл болон үйлчилж байсныг өөрчлөх шаардлага гарсан. Иймд шинэ журамд багшийн мэргэжлийн зэрэг олгох зорилтот бүлгүүдийг тодорхой болгож, тэдэнд багшийн мэргэжлийн зэрэг олгох нийтлэг шалгуурын зэрэгцээ зорилтот бүлэг бүрийн ажлын байрны тодорхойлолтод нийцсэн тусгай шалгуурыг ялгаатайгаар тогтоож өгсөн. Тэдгээр шалгуурыг үнэлэх үзүүлэлтийг багш арга зүйгээ хөгжүүлж, ур чадвараа ахиулах үйл ажиллагааны оролт, явц, гаралтын үе шатуудын үр дүн болон илэрч хэмжигдэхээр болгож өөрчилсөн. Мэргэжлийн зэрэг олгох нэг гол шалгуураар тухайн багшийн заадаг хичээлийн сурагчдын сурлагын амжилт нь улсын дундаж, түүнээс дээш байхаар тогтоосон нь үнэлгээг бодит болгон, боловсролын чанарын үнэлгээний тогтолцоог шинэчлэхэд дам нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой зохицуулалт болсон.
- 1990 оноос хойш бараг “Мэргэжил дээшлүүлэх журам”-гүйгээр 2008 он хүрсэн юм. Энэ шинэ журам нь багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх шинэ тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх үндсэн зориулалттай. Мэргэжил

⁸ www.Legalinfo.mn, БСШУЯ-аас ажлын хэрэгцээнд зориулан гаргадаг эрх зүйн актуудын эмхэлтгэлүүд

дээшлүүлэх сургалт нь үндсэн, төрөлжсөн, бие даах гэсэн хэрэгцээ, зорилго, арга хэлбэрээрээ ялгаатай гурван төрөл бүхий сургуульд суурилсан мэргэжил дээшлүүлэх үндэсний нэгдсэн тогтолцоо бүрдүүлж, эдгээр сургалтын төлөвлөлт, зохион байгуулалт, зардлын санхүүжүүлт, мэдээлэл, хяналт-шинжилгээний асуудлыг цогцоор шийдвэрлэсэн. Шинэ журмаар багш нэг бүр багшаар ажиллах 1, 6, 11 дахь жилдээ 7, 14, 21 хоногийн хугацаатай гурван удаагийн мэргэжил дээшлүүлэх сургалтад улсын төсвийн санхүүжилтээр хамрагдах боломж бүрдүүлсэн бөгөөд энэ нь багш бүрд арга зүй, ур чадвараа дээшлүүлэх тэгш боломж олгож, багш нарт адил тэгш хандах зарчмыг хэрэгжүүлж байгаагаараа ихээхэн ач холбогдолтой юм. Төрөлжсөн сургалтууд нь сургууль, багш нарын тусгай эрэлт хэрэгцээнд түлхүү суурилах, бие даах сургалтад мэдээлэл харилцааны технологийг түлхүү ашиглах бодлогыг тус тус баримталсан.

- ЕБС-ийн багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэх чиглэл нь 2007 онд БСШУ, НХХ, Сангийн сайдын хамтарсан тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын агуулга, бүтэц, норм, нормативт оруулсан зарчмын шинэ өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд нь сургууль, багш нарт дэмжлэг болгох 2007-2009 онд Японы Жайка байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн “Сурагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” сэдэвт гурван жилийн төслийн цөм агуулга болох “Хичээлийн судалгаа”-ны арга зүйг түгээн дэлгэрүүлэх эрх зүйн механизм болгох чухал ач холбогдолтой.
- Багшийн ажлыг хэмжих нэгж, агуулга, бүтэц, норм норматив, төлөвлөлт, үнэлгээ, хэрэгжүүлэх арга хэлбэр өөрчлөгдсөнөөр багш нэгж болон ээлжит хичээлдээ чанартай бэлтгэх, ажлын байран дээрээ бүтээлчээр хамтран ажиллаж, тасралтгүй суралцахад нь шаардлагатай ая тухтай материаллаг болон технологийн орчныг бүрдүүлэхээр 2008 онд БСШУ-ны сайдын 2008 оны 114 дүгээр тушаалаар “Багшийн хөгжлийн танхим” ажиллуулах зөвлөмж батлан гаргасан. Уг зөвлөмжид багшийн хөгжлийн танхимд тавигдах ерөнхий шаардлага, түүнийг тоноглох тавилга, тоног төхөөрөмжийн жагсаалт, хүртээмж, тэдгээрийг санхүүжүүлж, нийлүүлэх арга зам, танхимыг ашиглах зориулалтыг тус тус тодорхойлсон. Сайдын тушаалд төрийн өмчит 574 сургуулийн 650 танхимыг 2009-2012 онд багтаан үе шаттайгаар байгуулах, танхим байгуулахтай холбогдон гарах зардлыг улсын төсөв, БСХХ болон бусад хөтөлбөр, төслөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. 2009 онд Дэлхийн Банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Үр дүнд түргэн хүрэх санаачилга” төслөөс энэ арга хэмжээнд 1300000 америк доллар зарцуулжээ.
- 2010 онд Японы Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Улаанбаатарт “Багшийн ордон”-ны барилга баригдахаар шийдвэр гарч, 2012 онд энэ ордон ашиглалтад ороод байна. Түүнчлэн Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 23-ны 180 дугаар тогтоолоор “Багш нарын мэргэжил дээшлүүлэх институт” байгуулагдсан явдал нь багшлах арга зүйг шинэчлэх олон жилийн үйл явцад бүрэлдэн бий болсон онол арга зүй, эрх зүй, төсөв санхүү, хүний нөөцөд суурилан бүтэц, байгууллагын хувьд хэлбэржиж, багшлах арга зүйг шинэчлэн хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх менежментийн үйл ажиллагаа бүрэн институтчилэгдэж дууссаныг харуулж байна.

Багшийн хөгжлийг дэмжих манлайлал (нөлөөлөл)-ын арга механизм бий болгох тухайд:

Манлайлал

Багшийн хөгжлийг дэмжих манлайллын асуудал нь багшлахуйн хангамж (teacher requirtment) хэмээх нарийн нийлмэл ойлголттой холбогддог. Багшийн хөгжлийн чанарыг үнэлэхэд хэрэглэгддэг энэхүү ойлголт нь мэргэжлийн багшаар хангах, багшийг үндсэн ажилд нь төвлөрүүлэх, ажлын байранд нь тогтвортой ажиллуулж тогтоох, өөрийгөө тасралтгүй хөгжүүлж байх шаардлага боломжийг хослуулах, өөрийгөө илэрхийлэх, шударгаар үнэлүүлэх боломж олгох, бусадтай мэдлэг туршлагаа хуваалцах ёс зүй, хандлагатай болгох зэрэг олон чухал асуудлыг хамардаг.

Иймд Монгол Улсын төрөөс багшлах арга зүйг шинэчлэн шинэ арга зүй эзэмшсэн багшаар хангаж, тэднийг үр бүтээл гарган тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд олон чухал арга хэмжээг авч ирсэн.

Өнөөдөр Монголын багш нар ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үүргийг гүйцэтгэснийхээ төлөө авах үндсэн цалингаас гадна 1.5 зурагт үзүүлсэн

олон нэмэгдэл, нэмэгдэл хөлс, мөнгөн урамшуулал, тэтгэмж⁹ авч байна (Зураг 14.)¹⁰. Тухайлбал,

- Багш болгон хийдэггүй, ажлын байрны тодорхойлолтод нь тусгагдаагүй нэмэлт ажил хийвэл, багшид нэмэгдэл хөлс олгодог. ЕБС-ийн багш нар анги даан ажиллах, ЗАН удирдах, лаборатори, кабинет хариуцан ажиллуулах гэсэн 3 төрлийн нэмэгдэл ажилд нэмэгдэл хөлс авдаг.
- Төрийн албан хаагчид олгодог нийтлэг болон багшийн ажлын онцлогтой холбоотойгоор багш нарт хэд хэдэн нэмэгдэл олгогддог. Тухайлбал, аймаг, сумын багш нарт орон нутгийн нэмэгдэл, мэргэжлийн ур чадвараас хамааруулж, ур чадварын нэмэгдэл, илүү цагийн хөлс, гүнзгийрүүлсэн сургалт явуулсан нэмэгдэл, мэргэжлийн зэргийн нэмэгдэл зэрэг болно.
- Боловсролын салбарт зэрэгцсэн, цогц шинэчлэлийг хэрэгжүүлж байгааг үнэлж, Монгол Улсын Хөгжлийн сангаас 2008 оноос эхлэн бүх багшид төдийгүй сургуульд ажиллаж байгаа бүх хүмүүст сар бүрээр тооцож, улирал тутамд мөнгөн урамшуулал олгож байна. Мөн 2005 оноос эхлэн жил бүр аймгийн болон улсын оны тэргүүний багш шалгаруулан урамшуулдаг.
- Боловсролын тухай хуулийн дагуу 2006 оноос сум, тосгон багт ажилладаг багш нар 5 жил тутамд зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх тэтгэмж авсан ба 2013 оноос эхлэн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан зэрэг бусад албан тушаалтнууд энэ нэмэгдлийг авч эхэлнэ.



Зураг 1.5. Багшийн цалин хөлс, урамшууллын төрөл, хэмжээ, хуртээмж

- Боловсролын салбарт 25 ба түүнээс дээш жил ажилласан багш нар тэтгэвэр тогтоолгохдоо 12-18 сарын үндсэн цалинтай тэнцэх тэтгэмж авч байсан бол 2013 оноос энэ тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэн олгоно.

Дээрх бүх нэмэгдэл, нэмэгдэл хөлс, мөнгөн урамшуулал нь бүгд багшийн үндсэн цалингаас тооцогддог тул цаашид тэдгээрийг шинээр нэмэх бус харин үндсэн цалинг нэмэгдүүлэх нь олон талын ач холбогдолтой нь ойлгомжтой.

Мөн нэмэгдэл, урамшуулал, шагналын шалгуур, үзүүлэлтийг сонгохдоо багшийн үндсэн ажлын гүйцэтгэлийн явц, үр дүнг үнэлэхэд чиглүүлж, бараг адилхан болгосон бөгөөд гагцхүү тухайн үзүүлэлтийн хэмжээ, ахицаар шатлал, түвшин нь тогтоогдож байх бодлого баримталсан. Энэ бодлого нь багш цалин хөлсөө нэмэгдүүлэхийн тулд илүү дутуу ажил хийлгүйгээр зөвхөн үндсэн ажилдаа төвлөрч, боловсролын шинэчлэлийг бодит үйл хэрэг болгоход хувь нэмэр оруулж, түүнийгээ бусадтайгаа хуваалцан шинэчлэл, хөгжлийг манлайлахад нь хөшүүрэг болох учиртай.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо бүрдүцлэх тухайд:

Боловсрол, Шинжлэх Ухааны Яамнаас багшийн хүрэлцээ хангамж, чанар, нийцийг үнэлэх статистик мэдээллийг олон улсад хэрэглэгддэг аргачлалын

⁹ www.open.gov.mn

¹⁰ www.mes.gov.mn

дагуу тооцож, сургууль, орон нутгаас гаргуулан мэдээллийн сан бүрдүүлэхийн зэрэгцээ, яамны жил бүрийн тайланд яамнаас зохион байгуулсан болон зохицуулсан үйл ажиллагааны мэдээллүүд бичигдэн хадгалагддаг. ЮНЕСКО-д багштай холбогдох мэдээллийг хүргүүлснээр багшийн хөгжлийн индикаторыг бусад улстай жиших боломж гардаг ч манай хот хөдөөгийн ангилал олон улсын жишигтэй нийцдэггүй тул тодорхой дүгнэлт гаргахад хүндрэлтэй байдаг.

Багшийн хөгжил, багшлах арга зүйг шинэчлэх талаар орон нутаг, сургууль, багш бэлтгэдэг их, дээд сургууль, бусад байгууллагаас яамны зөвшөөрөлтэйгөөр зохион байгуулдаг кредит олгох төрөлжсөн сургалтаас бусад үйл ажиллагааны талаарх мэдээлэл улсын хэмжээнд нэгтгэгдэж, үнэлгээ, дүгнэлт хийгдэж чадахгүй байна.

2005 онд хийгдсэн Боловсролын салбарын орчлын нэгдсэн үнэлгээнээс хойш ийм нэгдсэн үнэлгээ хийгдээгүй тул цаашид ийм түвшний үнэлгээ, оношилгоо хийж, багшийн хөгжил, багшлах арга зүйн шинэчлэлд үнэлгээ өгч байж, дараагийн шатны хөгжлийн стратегийг тодорхойлж, бодлогоо нарийвчлан, үйл ажиллагаагаа төлөвлөх шаардлагатай.

II. ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ МЕНЕЖМЕНТ

Японд сүүлийн жилүүдэд багшлах зөвшөөрлийг 10 жил тутамд шинэчилж байх дүрэм хэрэгжиж эхэлснээс сургалтад хандах хандлага дээшилж, багш бэлтгэх сургуулиуд нэлээд үүрэг гүйцэтгэж байна. (Фүкүчи)

“Хичээлийн судалгаа нь япон хүний онцлог болох жижиг юманд ч гэсэн нарийн ханддаг япон шинжтэй үйл ажиллагаа юм”


Судалгаат хичээл бол хичээлийн судалгааны үндсэн нэгж юм.

Нэг талаас, төрөөс ерөнхий боловсролын чанарт тавьж буй шаардлагын дагуу, нөгөө талаас, өөрийн мэргэжлээ тасралтгүй дээшлүүлж байх багшийн хувийн хэрэгцээний улмаас, мөн сурагчдын сонирхол хэрэгцээ гэх мэт бусад олон шалтгааны улмаас багшлахуй арга зүйн хөгжил тасралтгүй хийгдэх болдог. Багшлахуй арга зүйг хөгжүүлэхэд “хичээлийн судалгааны арга” дэвшилтэт нөлөөтэй болохыг олон улсад хэрэгжүүлсэн хичээлийн судалгааны төсөл хөтөлбөрүүд харуулж байна.

БСШУЯ болон ЖАЙКА-ийн хамтран 2006-2009, 2009-2012 оны хооронд 2 шаттай хэрэгжүүлсэн төслийн үр дүнд манай улсын хэмжээнд сургуульд суурилсан хичээлийн судалгааг хэрэгжүүлэх эх суурь тавигдаж, хүний нөөц тодорхой хэмжээнд бэлтгэгдээд байгаа билээ. Энэ хоёр төслийн хүрээнд боловсруулж, Та бүхэнд хүргүүлсэн зөвлөмж, сургалтын гарын авлага, VCD хичээлд суралцагчдын суралцахуйг дэмжсэн арга зүй, хичээлийн судалгаа хийх арга, хичээлд мониторинг хийх арга зүй зэргийг тусгасан байна. Хавсралтад үзүүлсэн зөвлөмж, гарын авлага, VCD хичээлүүдээс хичээлийн судалгааг хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа бүтээлчээр ашиглахыг зөвлөж байна.

2.1. Хичээлийн судалгаа

Хичээлийн судалгааг 3, 4, заримдаа 5 алхамтай хэмээн тайлбарласан байдаг ч үнэндээ хичээлийн бэлтгэл, хичээл зааж, түүнийг ажиглах, хэлэлцүүлэг хийх гэсэн үндсэн гурван алхам (Зураг 2.1.)-аас тогтоно.




Зураг 2.1. Хичээлийн судалгааны үндсэн алхам

Тухайн хичээлийн судалгааны зорилго, хамрах хүрээ гэх мэт олон хүчин зүйлээс хамааран дээрх гурван алхмыг дэлгэрүүлэн задлах гэх мэт байдлаар авч үзэж болно. Төслийн хүрээнд гарсан зөвлөмжүүдээс алхам тус бүрийн талаар, мөн судлагдахууны онцлогоос хамаарах тусгай зөвлөгөөг үзэж судлах боломжтой.

Тиймээс энд бид давхцал гаргахгүй үүднээс одоогийн байдлаар тулгамдаад байгаа зарим ойлголтыг тодруулан тайлбарлая.

Хичээлийн судалгаа ба судалгаат хичээл. Төсөл хэрэгжүүлсэн 6 жилийн туршлагаас харахад зарим үед хичээлийн судалгаа болон судалгаат хичээлийг нэг зүйл гэж үзэх, ялгааг нарийн гаргахгүй байдал ажиглагддаг. Төслийн загвар болон загвар бус сургуулиудад хийсэн мониторингийн үед, ялангуяа төслийн эхний жилд манай багш нар мониторингийн багийн гишүүдэд зориулан заасан “нээлттэй хичээл (угтаа энэ нь судалгаат хичээл байх ёстой)”-ээ хичээлийн судалгаа гэж ташаа ойлгох нь элбэг байсан. Гэтэл хичээлийн судалгаа гэдэг бол багш өөрийн багшлах арга зүйгээ сайжруулах, ажлын байран дээрээ мэргэжлээ дээшлүүлэх, сургалтын чанараа дээшлүүлэх гэх мэт олон шатны зорилгыг хангахад чиглэсэн тасралтгүй үйл ажиллагаа юм. Энэхүү тасралтгүй байх чанарыг нь хангасан хичээлийн судалгааг явуулах үед бидэнд хичээлийн судалгаа ба судалгаат хичээлийн ялгаа, эрэмбэ тодорхой харагдах болно. Судалгаат хичээл бол хичээлийн судалгааны үндсэн нэгж юм. Хичээлийн судалгааны гурван алхмыг нэг удаагийн ээлжит хичээлд буулгаж хэрэгжүүлсэн судалгааны нэгжийг судалгаат хичээл гэж нэрлэж болно. Японы зөвлөх профессор Фүкүчи өөрийн илтгэлдээ хичээлийн судалгааг “Багшийн хувийн хичээлийн судалгаа”, “Хамтарсан нээлттэй хичээлийн судалгаа” гэж ялгаж нэрлэсэн байдаг. Үүнийг судалгаат хичээлд буулгаж хэрэглэвэл тодорхой тооны ажиглагч бүхий судалгаат хичээлийг “хамтарсан нээлттэй судалгаат хичээл” гэж нэрлэж болно. Үнэндээ бид ингэж ялгахгүйгээр судалгаат хичээл гэдэг. Харин хичээлийн судалгаа бол харьцангуй урт хугацааг хамарсан тасралтгүй үйл ажиллагаа гэж үзвэл судалгаат хичээлүүдийн хооронд багш

тухайн хичээлийн судалгааны зорилгод чиглэсэн “багшийн хувийн судалгаат хичээл”-ийг зохион байгуулах ёстой байдаг. Бид ингэж нэрлэдэггүй учраас манай багш нар ажиглагчгүй хичээлдээ хуучин барилаараа хандах нь элбэг байна. Мэдээж “багшийн хувийн судалгаат хичээл”, эсвэл ажиглагчгүй ээлжит хичээлд хэлэлцүүлэг хийгдэхгүй боловч багш ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу заасан хичээлийнхээ үр дүнг үнэлэх сайжруулахын тулд “өөрийн үнэлгээ/хэлэлцүүлэг” хийж байж сая “хичээлийн судалгаа” жинхэнэ утгаараа хийгдэх нэг нөхцөл бүрдэнэ (Зураг 2.2. Хичээлийн судалгаа ба судалгаат хичээл).



Зураг 2.2. Хичээлийн судалгаа ба судалгаат хичээл

Хичээлийн судалгаагаар бид олон зүйлийг судлах боломжтой. Тухайлбал:

- багшийн багшлахуй арга зүйн хөгжлийг
- хэрэглэгдэхүүний боловсруулалтын хөгжил, тохирцыг
- шинэ багшлах арга зүйн хэрэгжих боломжийг
- сурагчдад гарч буй мэдлэг, чадварын хөгжлийг
- сурах хүсэл сонирхолд гарч буй хандлагын өөрчлөлтийг
- өөрийгөө илэрхийлэх, бусадтай хамтран ажиллах зэрэг харилцааны чадварт гарч буй өөрчлөлтийг тус тус судалж болно.

Ийм төлөвлөлтийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг төслийн бүтээгдэхүүн болох “Удирдлагын сургалтын модуль”-аас тодруулж үзээрэй. Тухайн хичээлийн судалгааны баг хичээлийн судалгааны зорилгодоо нийцүүлэн дээр дурдсан зүйлийн заримыг, эсвэл өөр зүйлийг ч судалж болно. Юуг судалж байгаагаас үл хамааран “хүний хөгжлийг бодитой илрүүлэх” нь нэг удаагийн, эсвэл цөөхөн хэдэн удаагийн, эмх цэгцгүй үйл ажиллагаагаар “огтхон ч” боломжгүй гэсэн нэгэн нийтлэгийг анхаарч байнга санаж явах ёстой болно. Иймээс судлагдахуунд суурилсан хичээлийн судалгааг нэгж хичээл, бүлэг сэдэв, курс хичээлийн хэмжээнд, сургуульд суурилсан хичээлийн судалгааг улирал, хагас жил, хичээлийн жилээр төлөвлөн зохион байгуулахыг зөвлөж байна.

Хичээлийн бэлтгэл судалгаа ба хичээлийн төлөвлөлт. Хичээлийн бэлтгэл судалгааг нэгдүгээрт, ерөнхий боловсролын сургуулийн багшийн, хоёрдугаарт, боловсролын салбар дахь судлаачийн гэсэн хоёр түвшинд ялгаатай авч үзэх нь зохистой болно. Багшийн өдөр тутмын үйлийн түвшин (явцуу утгаар)-д хичээлийн бэлтгэл судалгааг Японы зөвлөх профессор Каматагийн зөвлөснөөр дараах байдлаар ойлгож болно. Үүнд: “Кёсай кэнкю гэдэг үгийн утга нь хэрэглэж байгаа хүнээсээ хамааран өөр өөр байдаг ч үнэн хэрэгтээ “хичээлийн бэлтгэл” гэдэг утгаар хэрэглэх нь олонтоо. Гэхдээ бэлтгэл гэж байгаа боловч өмнө нь сурах бичгээ хальт харах, туршилтад шаардлагатай багаж төхөөрөмжийн тоог шалгаж үзэх гэх мэт хэлбэр төдий үйл ажиллагаа биш ээ. Суралцагч болон суралцах орчны нөхцөл байдалд тулгуурлан хичээлийн явцад юуг авч үзвэл илүү сайн байх талаар нарийвчлан тооцож үзэх нь гол зүйл юм. “Судалгаа” гэдэг үгийг хэрэглэх нь энэ үйл ажиллагааг явуулж байгаа багшийн төлөвийг

(өмнөх өгөгдөл болон дадлага туршлагадаа тулгуурлан илүү сайн зүйлийг бүтээе гэсэн байдал) илэрхийлж байгаа гэж ойлгоход болно”. Өөрөөр хэлбэл, багш тухай тухайн ээлжит хичээлд “тохиолдол”-ын шинжтэй бэлтгэл хийхээс илүүгээр өмнөх ба дараах хичээл, өнгөрсөн жил ба дараа жил, сурагчийн болоод ангийн онцлог, сэдвийн онцлог зэргийг тооцож ямар учраас бэлтгэлийг ингэж хийснээ ухамсарлан хийнэ гэсэн хэрэг болно.

Агуулга, хэрэглэгдэхүүн болон сурагчдын бодит чадварт голлон анхаарч “хичээлийн бэлтгэл судалгаа”-ны чухлыг сайн ойлгон судлах аргаа харилцан мэдэх нь чухал юм¹¹. Судалгаат хичээлийг явуулах багш хэр зэрэг бэлтгэл судалгаа хийсэн нь хичээл дээр харагддаг. Хүүхдийн алдаа болон танин мэдэхүйн түвшин (өсөлт хөгжил)-г мэдэх нь хичээл явуулахад чухал бөгөөд хэр зэрэг гүнзгий мэдэж байгаагаас хамаарч хичээл үр дүнтэй эсэх нь шийдэгдэнэ. Тэдгээр нь хичээлийн дараа шууд явуулах хэлэлцүүлэг дээр шалгагдана.

Хичээлийн бэлтгэл судалгаанд агуулгын, хэрэглэгдэхүүний, сурагчийн алдааны гэх мэт хэд хэдэн судалгааг хамруулан ойлгодог. Ахмад туршлагатай багш нар сурагч ямар сэдвээр, ямар ойлголт, ямар туршлагад ямар алдаа голлон гаргах хандлагатай байдгийг туршлагаараа мэддэг учраас хичээлдээ түүнийг тооцон төлөвлөж, хичээлийн явцад сурагчийн хариултаас маш нарийн мэдэрч чаддаг. Гэхдээ багшийн онцлогоос хамааран ийм туршлагатай болоход харилцан адилгүй хугацаа зарцуулдаг. Харин хичээлийн судалгаанд оролцоноор энэ хугацааг богиносгож, богино хугацаанд илүү их туршлагыг хуримтлуулах боломжтой болно. Хичээлийн бэлтгэл судалгааны нэгэн бүрэлдэхүүн болох хэрэглэгдэхүүний судалгааны нэгэн жишээ¹²г тайлбарлая: Байгалийн ухааны хичээлээр биетийн сүүдрийн өндөр түүний байрлалаас хэрхэн хамаарахыг туршлагаар судлах хичээл байжээ. Багш 3 удаагийн хичээлээр хэрэглэгдэхүүний судалгааг хэрхэн хийж сайжруулсныг дараах хүснэгтэд үзүүлжээ.

Энэ жишээгээр биет, дэлгэц, гэрэл үүсгэгч, хэмжилтийн шугам зэргийг бэлтгэж байгаа нь багшийн хичээлийн бэлтгэл, харин хэдэн биет, хэдэн гэрэл үүсгэгч, ямар хэмжээний дэлгэц авах, хэчнээн хэмжилтийн шугам гэх мэт өмнөх хичээлийн явц, хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн “илүү сайн зүйлийг бүтээе гэсэн байдал”-аар хандсан нь хичээлийн бэлтгэл судалгаа болж байна.

№	Хэрэглэгдэхүүн	Хичээлийн товч тэмдэглэл
1		Туршилт хийх үед сурагчид биетийг дэлгэцээс холдуулахад сүүдрийн өндөр ихсэж, дэлгэцэд ойртуулахад өндөр багасаж байгааг олж харсан боловч туршилтын дүнг графикаар илэрхийлэхэд маш их бэрхшээлтэй тулгарав.
2		Дэлгэц болон биетийн замд хэмжилтийн шугам байрлуулсан дараагийн хичээлд биетийн сүүдрийн өндөр биетээс дэлгэц хүртэлх зайнаас хэрхэн хамаарч байгааг графикаар илэрхийлэх зарчмыг ойлгоход тустай байв.
3		Дэлгэц болон биетийн замд хэмжилтийн гурван параллель шугам байрлуулж, нэгэн ижил гурван биетийн сүүдрийн өндрийг туршлагаар тодорхойлсноор хичээлийн нягтрал сайжирч багшид сурагчдын төсөөлөл, алдаа зэрэгтэй нарийн ажиллах боломж олгов.

¹¹ Фүкүчи

¹² Охара багш, Хүн-Байгаль багт хийгдсэн ажил

2.2. Хичээлийн судалгааны төрөл, ангилал

Хичээлийн судалгааны ийм тийм загвар байдаг гэсэн мэдээлэл одоогоор олж үзээгүй байна. Манай зарим судлаачид хичээлийн судалгаа (судалгаат хичээл)-г янз бүрийн шалгуураар ангилах оролдлого хийсэн байдаг¹³. Индонези дахь хичээлийн судалгааны туршлага судлах багийн тайлангаас үзвэл тус улсад хичээлийн судалгааг түүнд оролцдог гишүүдийн бүрэлдэхүүнийг шалгуур болгон өөр өөр сургуулийн нэг мэргэжлийн багш нарын явуулдаг “Судлагдахуунд суурилсан хичээлийн судалгаа¹⁴”, нэг сургуулийн өөр өөр мэргэжлийн багш нарын явуулдаг “Сургуульд суурилсан хичээлийн судалгаа¹⁵” гэж хоёр ангилан үзэж байна¹⁶.

Макото Ёшида өөрийн “Overview of Lesson Study in Japan” илтгэлдээ Японд зохион байгуулагдаж байгаа хичээлийн судалгааг хэлбэр болон зохион байгуулах газрыг үндэслэн дараах байдлаар ангилж авч үзсэн байна¹⁷.

- Сургууль дээрх (In-school)
 - Нийлмэл бүлэг (Whole group)
 - Судлагдахууны судалгааны бүлэг (Content-area study groups)
- Сургууль хоорондын (Across schools)
 - Бүсчлэн зохион байгуулсан (Regionally organized)
 - Багшлах эрх олгох сургалтын хэсэг (Part of mandated beginning teacher education)
 - Сайн дурын үндсэн дээр байгуулагдсан клуб, дугуйлан (Voluntarily organized clubs and circles)
 - Боловсролын нийгэмлэг, сургуулиас зохион байгуулсан (Organized by educational associations and institutions)

АНУ, Канад, Мексикийн 38 боловсрол судлаач, багш нар Японд ирж хичээлийн судалгааны туршлага судлах аяллын үед хийсэн илтгэлдээ профессор Dr. Akihiko Takahashi Японд хийгдэж байгаа хичээлийн судалгааны үндсэн хоёр төрөл¹⁸-ийг танилцуулсан байна. Үүнд:

- Хамгийн түгээмэл төрөл нь сургуульд суурилсан хичээлийн судалгаа юм. Сургуульд суурилсан хичээлийн судалгаагаар нэг сургуульд ажилладаг багш нар нэгдмэл ерөнхий зорилгыг 5-аас 7 жилд хангах, сургуулийн эрхэм зорилгыг хөгжүүлэхээр ажилладаг.
- Дараагийн хичээлийн судалгааны төрөл нь дүүргийн хэмжээний хичээлийн судалгаа бөгөөд сургуулиудын багш нар хамтран дүүргийн хэмжээнд дэвшүүлсэн зорилгыг хангахын тулд өөр өөр хичээлүүдээр бүлэг болон судалгаат хичээлийг зохион байгуулдаг байна. Энэ төрлийн хичээлийн судалгааны зорилго нь сургуулиудын хооронд туршлага солилцох, хамтын ажиллагааг хөгжүүлэх, дүүргийн хэмжээнд багшлах арга зүйг хөгжүүлэх явдал байдаг.

Японд бодитоор хэрэгжиж байгаа хичээлийн судалгааг “хэн”-ээс “хэн”-д зориулсан байгаагаар нь авч үзээд Гакугей Их Сургуулийн профессор Такавата:

1. Шинээр ажилд орж байгаа багшид зориулсан ахмад багш нараас заах загвар хичээл
2. Ахмад багш нараас удирдамж, заавар авах зорилготой шинэ багшийн хичээл
3. Сургалтын үеэр ахмад багшийн заах загвар хичээл
4. Идэвх санаачилгатай багшаас үзүүлэх тайлан хичээл,
5. Их сургуулиудын түшиц сургуулийн багш нарын нээлттэй хичээл
6. Шинэ арга зүйг нэвтрүүлэх хичээл зэрэг төрлүүдийг нэрлэсэн байна.

Эдгээр төрлүүдөөс хамаарч хичээлийн судалгааны гурван алхмын алинд илүү анхаарах вэ гэдэг нь ялгаатай байна. Жишээлбэл, Шинэ арга зүйг нэвтрүүлэх 6-р төрлийн хичээлд алхам 1, 2-ыг чухалчлах ба 3-р алхамд хичээл заасан багш дүгнэлт хийх гэхээсээ илүү ажиглагч асуулт тавих нь олон байх жишээтэй. Харин ахмад багш нараас удирдамж, заавар авах зорилготой шинэ багшийн

¹³ Боловсролын хүрээлэн, Ш.Оюунцэцэг, 2011 оны сургалт-семинарт хэлэлцүүлсэн илтгэл, Нийслэлийн боловсролын газар, Ө.Цэнсүрэн, 2011 оны сургалт-семинарт хэлэлцүүлсэн илтгэл

¹⁴ Muhammad Hatta (Ministry Of National Education)-ийн илтгэлээс, Teacher Subject Working Group (Cluster) Based Lesson Study,

¹⁵ Muhammad Hatta (Ministry Of National Education)-ийн илтгэлээс, School Based Lesson Study

¹⁶ 2012 оны 6 сар, семинар

¹⁷ Overview of Lesson Study in Japan, Makoto Yoshida (Global Education Resources) илтгэлээс

¹⁸ <http://www.thedailyriff.com/articles/what-american-teachers-can-learn-from-japan-315.php>

хичээл буюу 2-р төрлийн хичээлийн судалгааны хувьд алхам 1 чухал байна. Өөрөөр хэлбэл, хичээлд бэлтгэх алхамд залуу багш ахмад багштай маш нягт ажиллаж суралцана гэсэн үг юм¹⁹. Энэ мэтчилэн хичээлийн судалгааны тухай ярилцахдаа ямар зориулалттай, ямар төрлийн хичээлийн судалгаа вэ? гэдгийг тодорхой болгож зорилгодоо чиглэх баримжаагаа чанд баримтлах хэрэгтэй. Эс бөгөөс уян хатан биш, хэлбэр төдий хичээлийн судалгаа болох аюултай гэсэн байна.

Хичээлийн судалгааны дараах төрлийг санал болгож байна.

Хичээлийн судалгааны багийн гишүүдээр нь:

- Судлагдахуунд суурилсан хичээлийн судалгаа
- Сургуульд суурилсан хичээлийн судалгаа

Хичээлийн судалгааны хамрах хүрээгээр нь:

- Сургуулийн түвшний
- Сургууль хоорондын болон дүүргийн/Аймгийн түвшний
- Бүсийн түвшний
- Үндэсний түвшний

Хичээлийн судалгааг удирдан зохион байгуулж байгаа нэгжээр нь:

- Сайн дурын хичээлийн судалгааны багийн
- Сургууль, боловсролын тогтолцооны нэгж (ЗАН, сургууль, аймаг дүүргийн БСГ)-ийн зохион байгуулсан хичээлийн судалгааны багийн
- Судалгааны байгууллага (Багш бэлтгэдэг их дээд сургууль, судалгааны хүрээлэн, багшийн мэргэжил дээшлүүлэх байгууллага, төсөл, хөтөлбөрийн хэрэгжүүлэх нэгж)-аас зохион байгуулсан хичээлийн судалгааны багийн

Хичээлийн судалгааг хийж буй зориулалтаар нь:

- Суралцах (хамтран суралцах, бусдаас суралцах, мэргэжил дээшлүүлэх сургалт)
- Хуваалцах (ижил түвшний багш нар харилцан туршлага солилцох)
- Түгээн дэлгэрүүлэх (сайн туршлага, тодорхой арга зүйг түгээх)
- Хөгжүүлэх (тодорхой арга зүйг сайжруулах)
- Бүтээх (шинэ, шинэлэг арга зүй, хэрэглэгдэхүүн, дидактик шийдэл г.м.)

2.3. Хичээлийн судалгааны зориулалт, ач холбогдол, талуудын оролцоо

“Хичээлийн судалгаа бол багшлах арга зүйг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, цаашилбал багш ажлын байран дээрээ мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх хамгийн үр дүнтэй аргын нэг юм” гэсэн энэ өгүүлбэр та бүхэнд нэлээд танил байгаа биз ээ. Гэвч энэ мэтээр гадаад хэлбэр талаас нь дуурайгаад хийвэл бид хичээлийн судалгааг бодитоор хэрэгжүүлж чадахгүй юм. Тиймээс багш, сургуулийн удирдлага хичээлийн судалгааны талаарх мэдлэгээ тасралтгүй нэмэгдүүлж, хичээлийн судалгаанд хандах хандлагаа өөрчлөх хэрэгтэй юм. Тухайлбал,

Багш нар:

- Багш хичээлээ өөрчилснөөр өөрөө, улмаар хүүхдүүд ч бас өөрчлөгдөж байгааг мэдрэх, мөн яагаад багшлах аргаа өөрчлөх ёстой талаар ойлгож мэдрэх
- Хичээлийн судалгаа, хичээлийн бэлтгэл судалгааг ашиглан хичээлийн чанарыг сайжруулахад үнэн санаанаасаа чармайн ажиллаж, өдөр тутмын үйл ажиллагаагаар хичээлийн судалгаа явагдаж байдгийг ойлгож мэдрэх
- Хичээлд хариуцлагатай хандан, суралцагчдын суралцах чадварыг нэмэгдүүлэх үүрэгтэй багш бүр өөрийнхөө чадварыг сайжруулъя гэж бодохгүй бол илэрхий өөрчлөлт гарахгүй болохыг ухаарах.

Сургалтын чанарыг дээшлүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх шинэчлэлийн нэг чиглэл нь сургалтад хичээлийн судалгааны арга зүйг нэвтрүүлэх явдал гэж үзвэл хичээлийн судалгааг киррикулимийн шинэчлэлтэй холбож, багшийн арга зүйг хөгжүүлэх ажлын агуулгыг тодорхойлох боломжтой. Энэ шийдэл нь сургалтын технологид хичээлийн судалгааг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн тохиолдолд үр дүнгээ өгнө. Хичээлийн судалгаа нь ямар нэгэн нэмэлт ажил бус, харин багшийн үндсэн үүрэгт ажил гэдгийг ойлгохоос багш, удирдлагын хандлагын өөрчлөлт эхэлнэ. Иймээс төсөл хэрэгжих хугацаанд Засгийн газар, БСШУЯ-аас багшийн ажлын байрны тодорхойлолт, багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэх болон бусад холбогдох журмуудыг хичээлийн судалгааны арга зүйг хэрэгжүүлсэн байхаар тооцож цогцоор нь шинэчилсэн. Ингэснээр хичээлийн

Чин сэтгэл

Тасралтгүй чармайлт

Хувийн хариуцлага

Сургууль дахь эрдэм шинжилгээний ажлын удирдагч нь сургуулийн удирдлага

¹⁹ Гакугей их сургууль, Проф Такахата, Судалгаат хичээлийн төрөл

судалгааг хэрэгжүүлэхдээ эрх зүйд суурилсан менежментээр зохион байгуулах бүрэн боломж бүрдсэн. Энэ талаар төслийн бүтээгдэхүүн болох “Удирдлагын сургалтын модуль”-аас тодруулан үзэх боломжтой.

Сургуулийн удирдлага:

- Хичээлийн судалгаа явуулна гэдэг нь сургуульд эрдэм шинжилгээний ажил явуулах гэсэн үг. Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааны орчин нь хичээлийн судалгааны ердийн орчин болох хүртэл нь сургууль доторх эрдэм шинжилгээний зохион байгуулалттай үйл ажиллагааг зорьж ажиллах
- Хичээлийн судалгааг зүгээр л нэг багшийн заах аргыг сайжруулах зүйл гэж ойлгохгүй сургуулийн эрхэм зорилго, сурган хүмүүжүүлэх зорилгод хичээлийн судалгаагаар хүрэхээр зорьж “Хичээлийн судалгааны сэдэв, зорилго”-ыг оновчтой тогтооход ач холбогдол өгөх, өөрөө гол үүрэг гүйцэтгэн манлайлах
- Багшийн ажил, амьдралын туршлагаас хамааран багш бүрийг арга зүй, чадварын хувьд түвшин ахих хувийн төлөвлөгөөтэй ажиллахад нь чиглүүлэх
- Багшид хичээлийн бэлтгэл судалгаа, судалгаат хичээл явуулах эрхийг чөлөөтэй байлгах

Багшийн арга зүйн хөгжлийг хүүхдийн хөгжлийн адил урт хугацаанд харах

Боловсролын бодлого боловсруулагчид

- Хичээлийн судалгаа нь нэг талаас нийт оролцогчид хэлэлцэж, илүү сайн багшлах арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм. Тиймээс оролцогч бүр үр дүнг хүртэгч, бас хувь нэмэр оруулагчид юм. Хичээлийн судалгааны үр дүнг богино хугацаанд, нүдэнд харагдаж байгаа төдийхнөөр үнэлэх нь даанч тоогүй. Мөн хичээлийн судалгаа хийж байгаа нь энэ гээд урсгалаар нь хараад байж болохгүй. Хэдийгээр багш бүр өөр өөр бодолтой байж болох боловч ажиглагч багшийн байр сууринаас тодорхой нэгдмэл зорилго тавьж ажиглахгүй бол болохгүй. Тэгснээр ажиглалт үр дүнтэй, угтатой болно. Багшийн арга зүйн хөгжлийг хүүхдийн хөгжлийн адил урт хугацаанд харах нь зүйтэй бөгөөд дээр нь оюуны хөдөлмөр хийж байгаа багш хүн хичээлийн судалгаанаас юуг олж мэдэх вэ? хичээлийн судалгааг яаж бүтээлчээр ашиглах вэ гэдгээ бодож хийх хэрэгтэй²⁰. Үүний тулд бодлого боловсруулагчид бодлогоор дэмжиж, хичээлийн судалгааг хөгжүүлэх, хөгжих хугацаа олгох хэрэгтэй болно.
- Нэг талаас, хичээлийн судалгааны багт орох эсэх нь багшийн, судлаачийн хувийн сонголт байдаг. Энэ нь багш, судлаач өөрөө чадвараа сайжруулах зорилготой байгаатай холбоотой. Нөгөө талаас, өөрийнхөө хичээлд үнэн санаанаасаа хандаж, хичээлийн бэлтгэл судалгаанд хандах хандлага, мэдээллийг цуглуулах боломж, хувь хүний судалгааны амжилт нэмэгдсэнээр багш, судлаачид өөрийн ажлын үнэлгээ болон албан тушаал ахих боломжтой болох төдийгүй багшийн ажлын чанарын үнэлгээний болон хүний нөөцийн бодлого хэрэгжүүлж хичээлийн судалгаанд оролцох багшийн сонирхлыг дэмжих нь чухал юм.
- Аливаа судалгааны нэгэн адил сурган хүмүүжүүлэх судалгааны чанар нь эрдэм шинжилгээний хурлаар сайжирч байдаг. Иймд боловсролын бодлогын тодорхой асуудлыг шийдвэрлэх, хэрэгжүүлэхэд тодорхой сэдвээр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах нь нэлээд үр дүнтэй аргуудын нэг юм.


Хичээлийн судалгаанд оролцох багшийн сонирхлыг дэмжих

2.4. Хичээлийн судалгааны менежмент

Хичээлийн судалгаа нь үйл явц учраас хичээлийн судалгаагаар багшлах арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлэхэд менежментийн ухааны үүднээс хандах зайлшгүй шаардлага тулгарч байна. Хичээлийг төлөвлөх, зааж ажиглах, хэлэлцэж сайжруулах гэсэн үндсэн гурван алхмын дагуу хичээлийн судалгаанд оролцохдоо багш бүр шинийг суралцаж, тэрхүү суралцсанаа өөрийн өдөр тутмын хичээлдээ хэрэглэснээр багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгждөг нь хичээлийн судалгааг “өөрчлөлтийн менежмент”-ийн үүднээс авч үзэх боломжийг олгодог байна²¹. Тиймээс хичээлийн судалгааны менежментэд хичээлийн судалгааны зорилго (хичээлийн чанарыг дээшлүүлэх, сургуулийг хөгжүүлэх г.м.) тодорхойлох, үйл ажиллагааг төлөвлөх, хичээлийн судалгааг хэрэгжүүлэх, үр дүнг дүгнэх тасралтгүй цикл үйл явцыг багтааж үздэг.

²⁰ Такахата

²¹ Hiroyuki Kuno, Aichi University of Education, Japan, Conceptualizing Lesson Study as Change Management Recipe



Зураг 2.3. Хичээлийн судалгааны менежмент

Яагаад хичээлийн судалгаа хийх хэрэгтэй вэ? Сургуулийн удирдлага, сургалтын менежер, багшид хичээлийн судалгаа хийх эрх зүйн ямар шаардлага тавигдаж байгааг, мөн хичээлийн судалгааг хэрэгжүүлэх байгууллагын менежментийн талаар энэхүү төслийн хүрээнд боловсруулан Та бүхний гар дээр хүргүүлсэн “Багшлахуйн хөгжил: Удирдлага” сургалтын модулиас дэлгэрүүлэн үзнэ үү²².

Харин энэхүү гарын авлагад Та бүхэнд хичээлийн судалгааны менежментийн загвар, загвар тус бүрийг хэрэгжүүлэх боломж, давуу сул тал, ач холбогдол зэргийг товч танилцуулах болно.

2.5. Хичээлийн судалгааны менежментийн загвар

Бид нэг удаагийн, эсвэл цөөхөн хэдэн удаагийн, эмх цэгцгүй судалгаат хичээл явуулснаар хичээлийн судалгааг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх боломжгүй болохыг хэлэлцсэн билээ. БСШУЯ болон ЖАЙКА-ийн хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд хийгдсэн хичээлийн судалгаа, мөн Японы профессор багш нарын өгсөн зөвлөгөө, гадаадын зарим улс оронд хэрэгжүүлж буй хичээлийн судалгааны төрөл, ангиллын талаар гарсан судалгааны материалд үндэслэн судалгаат хичээлүүд (хичээлийн судалгаа)-ийг ямар менежментээр зохион байгуулж болохыг илэрхийлсэн менежментийн дараах 3 загвар байж болохыг танилцуулж байна. Загварыг манай сургууль багш нарт танил байх гэдэг утгаар нь дугаарлаж эхэлсэн бөгөөд загварын дэс дугаар нь хичээлийн судалгааг хэрэгжүүлэх менежментийн загварын эрэмбэ дарааллыг илэрхийлэхгүй болохыг анхаарна уу. Та бүхэн өөрийн сургуулийн онцлог, хичээлийн судалгаа хийх хэрэгцээ шаардлага, бодит нөхцөл байдалдаа нийцүүлэн аль ч менежментийн загварыг хэрэгжүүлэх боломжтой юм. Мөн зарим загваруудыг хавсран хэрэглэх, бүр шинэ загвар ч бүтээх боломжтой.

Хүснэгт 2.1. Хичээлийн судалгааны менежментийн загварыг хэрэглэх боломж

Загвар	Хугацаа			Зориулалт					Баг		Хамрах хүрээ			
	богино	дунд	урт	суралцах	хуваалцах	түгээн дэлгэрүүлэх	сайжруулах	бүтээх	судлагда-хууны	сургуулийн	Сургууль	Дүүрэг/Аймаг	Бүс	Үндэсний
Загвар 1а	+	+	+				+	+	+	+	+			
Загвар 1б	+	+		+	+	+	+		+			+	+	
Загвар 1в	+	+		+	+	+			+	+	+	+	+	+
Загвар 2	+	+			+	+			+			+	+	+
Загвар 3		+	+				+	+	+		+	+	+	

Хичээлийн судалгааны менежментийн энэ гурван загвар хэрэглэх боломжийг Хүснэгт 2.1-д хичээлийн судалгааг хэрэгжүүлэх боломжит хугацаа болон хичээлийн судалгааны ангилал (зориулалт, ХС-ны баг, хамрах хүрээ)-ын хувьд нэгтгэн харуулсан байна. Загвар тус бүрийн хувьд энэхүү боломжийг дэлгэрүүлэн, зарим нэг онцлогийг тусган тайлбарласан болно. Жишээлбэл,


²² Ажлын байрны тодорхойлолт, үнэлэх, урамшуулах журам зэрэг үндсэн баримт бичгийн хүрээнд дэлгэрэнгүй тайлбарлажээ.

Загвар 1а-г сургуульд суурилсан, эсвэл судлагдахуунд суурилсан хичээлийн судалгаанд боломж нь олон бүлэгтэй том сургууль, цөөн бүлэгтэй орон нутгийн сургуульд хэрэгжүүлэх боломж харилцан адилгүй ялгаатай байна.

2.5.1. Тодорхой арга зүйг хөгжүүлэх хичээлийн судалгааны менежментийн загвар

БСПУЯ болон ЖАЙКА-ийн хамтран хэрэгжүүлсэн “Суралцагчийн суралцахуйг дэмжсэн арга зүйн хөгжил” төслийн хүрээнд гурван жилийн хугацаанд 8 мэргэжлийн баг жил бүр тодорхой нэрлэсэн арга зүйг хэрэгжүүлэх нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулж, түүнийгээ төслийн загвар сургуулиуд дээр туршин сайжруулж, эцэст нь багш нарт арга зүйгээ сайжруулах зөвлөмж болгон нийтийн хүртээл болгосон билээ. Энэхүү төслийн 1-р шатанд загвар сургууль дээр явуулсан туршилт хичээлийг илүү боловсронгуй, хөгжингүй болгохын тулд ашигласан арга барил нь “Хичээлийн судалгаа” байсан юм. Мөн төслийн 2-р шат “Багшлах арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” төслийн хүрээнд зохион байгуулсан сургалт семинараар хичээлийн судалгааны аргад сургах зорилгоор ихэнхдээ ээлжит 40 минутын судалгаат хичээлийн тохиолдолд хичээлийн судалгаа хийж байсан билээ. Тиймээс манай багш нарт бидний “Тодорхой арга зүйг хөгжүүлэх хичээлийн судалгааны менежментийн загвар” гэж нэрлэсэн энэхүү гурван дэд загвар нэлээд танил байх болно. Энэ загвар дахь судалгаат хичээлийг 40 минутын ээлжит хичээлд судалгаа хийхээс гадна хэд хэдэн цаг үргэлжлэх нэгж хичээлд хичээлийн судалгаа хийх гэсэн хоёр хувилбараар авч үзэх боломжтой.

1а. Тодорхой арга зүйг сайжруулж хөгжүүлэх хичээлийн судалгааны менежментийн загвар (Загвар 1а.)-ыг сургуульд суурилсан байдлаар хэрэгжүүлэх боломжтой юм. Тухайн багш эхний судалгаат хичээл (багш-1 ба сурагчид-1)-ийн хэлэлцүүлгээс олж авсан санаагаа үндэслэн хичээлийн төлөвлөлтөө сайжруулж дараагийн судалгаат хичээл (багш-1 ба сурагчид-2)-ийг зохион байгуулах гэх мэтээр олон бүлэгтэй сургуулийн хувьд тухайн хичээлийн жилд цаг хугацааны хувьд богино хугацаанд хийгдсэн дараалсан судалгаат хичээл бүхий хичээлийн судалгаагаар тодорхой арга зүй (хичээлийн судалгааны зорилгоос хамааран дидактик шийдэл, сорил туршилтын хэрэглэгдэхүүний тохироц гэх мэт)-г хөгжүүлж сайжруулж болно. Цөөн бүлэгтэй сургуулийн хувьд өмнөх хичээлийн жилд хийгдсэн хичээлийн судалгааны дүнг тусган сайжруулсан хичээлийн төлөвлөлтөөр дараагийн жилд судалгаат хичээл зохион байгуулах байдлаар арга зүйн тодорхой шийдлийг хөгжүүлж болно. Энэ тохиолдолд цаг хугацааны алслалтаас болоод өмнөх хичээлийн жилд туршсан арга зүйг сэргээн санах шаардлагын улмаас нэгдүгээрт, эхний судалгаат хичээлийн баримт материалыг иж бүрэн бүрдүүлж хадгалах, хоёрдугаарт, өмнө хийгдсэн судалгаат хичээлийн тайланг нягт нямбай судлаж бүрэн ойлголт авах, сэргээн санах, энэ жилийн судалгаат хичээлээр анхаарах зүйлээ тогтох гэх мэтэд анхаарах хэрэгтэй болно.




Загвар 1а.Тодорхой арга зүйг сайжруулж хөгжүүлэх

Мөн ойролцоо байрладаг, ижил хөтөлбөрөөр хичээллэж байгаа сургуулиудын нэг мэргэжлийн багш нар хамтран энэ загвараар судлагдахуунд суурилсан хичээлийн судалгааг хэрэгжүүлж болно. Шинжлэх ухааны агуулга өндөр, заахад хүндрэлтэй сэдвийн багшлах арга зүйг, эсвэл тодорхой сорил туршилтын хэрэглэгдэхүүнийг төгөлдөржүүлэн боловсруулах гэх мэт зорилгоор энэ загварын менежмент бүхий “бүтээх” төрлийн хичээлийн судалгааг олон жилээр үргэлжлүүлэн (урт хугацаанд) хийхэд боловсролын судлаачийн оролцоо чухал болно.

Энэхүү хичээлийн судалгааны менежментийн загварт хичээлийн бэлтгэл, хичээл зааж ажиглах, хичээлийг хэлэлцэх алхамд жигд анхаарч, судалгааны багийн гишүүдийн идэвхтэй жигд оролцоо шаардагдана.


16. Туришлага судлах, тодорхой арга зүйг уламжлан хэрэглэх, сайжруулах хичээлийн судалгааны менежментийн загвар /Загвар 16./-ыг орон нутаг, бүсийн хэмжээнд нэг мэргэжлийн багш нарын хамтлаг хэрэгжүүлэх боломжтой юм. Мөн багш нарын мэргэжил дээшлүүлэх болон бусад төрлийн сургалтын үеэр ийм загварыг хэрэгжүүлдэг. Сургалтын үргэлжлэх хугацаа болон эргэх холбоог хэрэгжүүлж буй аргаас хамааран эхний судалгаат хичээлээс уламжилж байгаа судалгаат хичээлийн хэлэлцүүлгийн үр дүнг өөр өөр аргаар хэрэглэдэг.



Загвар 16. Туришлага судлах, тодорхой арга зүйг уламжлан хэрэглэх, сайжруулах

Магадгүй энэ нь Такахата багшийн бидэнд зөвлөснөөр “1. Шинээр ажилд орж байгаа багшид зориулсан ахмад багш нараас заах загвар хичээл”, “3. Сургалтын үеэр ахмад багшийн заах загвар хичээл”-д хамаарч байвал тухайн орон нутаг бүсийн мэргэжлийн багш нарын хичээлийн судалгааны баг нь сургалтад хамрагдсан шинэ, залуу багш нарын уламжилсан судалгаат хичээлд оролцож эргэх холбоог хангаж болно. Эхний судалгаат хичээлийн үед сургалтад хамрагдаж байгаа шинэ залуу багш нь хичээлийн хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож хичээл заасан багшаас асууж, тодруулж нарийвчлах нь уламжилсан судалгаат хичээлээ амжилттай зааж, арга зүйд суралцахад нь тус нэмэр болох юм. Харин “4. Идэвх санаачилгатай багшаас үзүүлэх тайлан хичээл”, “5. Их сургуулиудын түшиц сургуулийн багш нараас нээлттэй хичээл”-д хамаарч байвал уламжилсан судалгаат хичээлийн үр дүнг туршлага судалж байгаа тухайн баг өөрийн ажилдаа тусгах байдлаар цааш хэрэгжүүлэх бөгөөд заавал эхний судалгаат хичээлийг зохион байгуулсан баг, хамтлагт тайлагнах албагүй болно.

1в. Өмнө хийгдсэн хичээлийн судалгааны дүнг хэрэглэх хичээлийн судалгааны менежментийн загвар /Загвар 1в./-ыг хамрах хүрээ нь сургуулиас эхлээд бүсийн, үндэсний хэмжээнд харьцангуй урт хугацаанд хэрэгжүүлэх боломжтой юм. Хамгийн гол нь нэлээд өндөр түвшинд, жишээ загвар болохуйц хэмжээнд зохион байгуулагдсан хичээлийн судалгааны сайтар боловсруулсан тайлан байх шаардлагатай. Одоогийн байдлаар манай сургууль багш нар хичээлийн судалгааны тайланг бүрдүүлж, хэрэглэх тал дээр харьцангуй бага туршлагатай байгаа билээ.



Загвар 1в. Өмнө хийгдсэн хичээлийн судалгааны дүнг хэрэглэх


Мөн алслагдсан, цөөн бүлэгтэй сургуулийн багш нарын хувьд өөрийн сургууль дээр хийх хичээлийн судалгааг эхлүүлэх, үр дүнг бусад сургуультай жишихэд хэрэглэх боломжтой. Залуу болон шинээр ажилд орж байгаа багшид тухайн сургууль дээр хийгдсэн хичээлийн судалгааны тайлангуудтай танилцах нь хичээлдээ, арга зүйгээ төлөвлөхдөө, тухайн сургуулийн сурагчдын онцлог, төлөв байдлыг тодорхойлоход чухал эх сурвалж болно. Шинэ арга зүйг туршсан хичээлийн судалгааны тайлан нь орон нутаг, бүсийн төдийгүй үндэсний хэмжээнд тухайн арга зүйг нэвтрүүлэх эх сурвалж, зайны сургалтын үнэтэй материал хэрэгсэл болж болох юм.

2.5.2. Ялгаатай байдлыг тогтоох хичээлийн судалгааны менежментийн загвар
Хичээлийг юу гэж үзэхээс хичээлийн судалгаа хэрхэн явагдах нь хамаарна. “Мэдлэг дамжуулах” хэлбэрийн хичээлд “хүүхдийн толгойд их хэмжээний

мэдээллийг хурдан бөгөөд оновчтой аргаар дамжуулж оруулж өгөх” гол эзэн нь “багш” байх бөгөөд багшийн заах ур чадвараас бүх юм шалтгаалдаг. Харин орчин үед “Мэдлэг олж авах, бүтээх арга барилыг эзэмших” хэлбэрийн хичээлд “явал хүүхэд бүр орчин тойрны хүн, юмс, үзэгдэлтэй харилцах явцдаа мэдлэг олж авч бүтээх аргад суралцах вэ” гэдэг хамгийн гол анхаарах зүйл болж, хичээлийн гол нь “хүүхэд” байх тул хичээлийн судалгаанд ч “хүүхэд”-ийг голлож үзэх болсон²³.

Олон улсад хичээлийн судалгааны хэрэгжиж байгаа байдалд шинжилгээ хийсэн тойм илтгэлдээ эрдэмтэн John Elliott багш нарын зарим хамтлаг хичээлийн судалгаагаар хичээлийн “төгс” загвар боловсруулах гэж оролддог ташаа ойлголт (*a tendency to misunderstand lesson study as something groups of teachers may engage in as a form of product development aimed at producing ideal lesson templates*, which teachers generally may have access to in preparing their lessons)-той²⁴ байгааг дурдсан байна.

Хичээлийн судалгааг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхээр зорьж байгаа манай улсын хувьд дээрх буруу төсөөллөөс аль болох зайлсхийхэд багш нараас эхлээд бодлого боловсруулагчид хүртэлх бүх түвшиндээ анхаарах хэрэгтэй юм. Хичээлийн судалгааны ялгаатай байдлыг тогтоох загвар /Загвар 2./-ыг хэд хэдэн сургууль хамруулсан орон нутаг, бүсийн хэмжээнд ижил мэргэжлийн багш нарын хамтлаг хэрэгжүүлэх нь зохимжтой юм. Мэдээж хичээлийн судалгаанд дэвшүүлсэн зорилгоосоо хамааран харьцуулан судлах зүйл нь өөр өөр байх бүрэн боломжтой. Жишээлбэл, нэг ижил дидактик шийдэл бүхий төлөвлөлттэй хичээлийг нэг багш өөр өөр ангид, хэд хэдэн багш өөр өөр сургуульд гэх мэтээр зааж, сурагчдын хариу үйлдлийн ялгаатай байдлыг харьцуулан судалж болно. Загвар 1-д багш ажлын байран дээр хэрэгжүүлэх боломжтой “туршилт судалгаа”-ны шинж давамгайлдаг бол 2 дахь загвар нь хамрах хүрээ харьцангуй өргөн бөгөөд “харьцуулсан судалгаа”-ны элементүүд нэлээд байдаг учраас багш бэлтгэдэг их, дээд сургуулийн профессор багш нарын оролцоо чухлаар шаардагдана. Гэхдээ энэ нь ерөнхий боловсролын сургуулийн багш нар ийм загвар бүхий менежментээр хичээлийн судалгаа хийж болохгүй гэсэн үг биш юм шүү.



Загвар 2. Ялгаатай байдлыг тогтоох

Орчин үед хичээлийн судалгаа, суралцахуйн судалгаа нь боловсрол судлалын салбарт бие даасан судалгааны талбар болон хүч түрэн хөгжиж байна. Тиймээс олон улсад энэ чиглэлээр хийгдэж байгаа судалгаанаас санаа авч өөрийн орны нөхцөлд буулган хэрэглэж болно.

2.5.3. Тодорхой чадвар төлөвшүүлэх багшлах аргазүйг судлах хичээлийн судалгааны менежментийн загвар

Сургуульд суурилсан, тасралтгүй хийгдэх хичээлийн судалгаанд сургуулийн удирдлага тэргүүлэх үүрэгтэй бөгөөд манлайлан оролцох шаардлагатайг хичээлийн судалгааны олон өгүүллээс олж уншиж болно. Тодорхой чадвар төлөвшүүлэх багшлах арга зүйг судлах хичээлийн судалгааны менежментийн загварыг хэрэгжүүлэхэд сургуулийн багш нарын хамтын ажиллагаа, сургуулийн удирдлагын манлайлал маш чухал болно. Тухайн сургуулийн удирдлага хичээлийн судалгааг зүгээр л нэг багшийн заах аргыг сайжруулах зүйл гэж ойлголтгүй, сургуулийн эрхэм зорилго, сурган хүмүүжүүлэх зорилтыг нарийвчлан түүнд хүрэхэд гүйцэтгэх хичээлийн судалгааны үүрэг (сэдэв)-ийг тогтооход манлайлан, сургууль доторх эрдэм шинжилгээний зохион байгуулалттай үйл ажиллагааг дэмжин, хичээлийн судалгааны бодит таатай


²³ Такугей их сургууль, Проф Такахата, Судалгаат хичээлийн төрөл

²⁴ John Elliott, Lesson Study in Transnational space, International Journal for Lesson and Learning Studies, Volume 1, Issue 2

орчныг сургуулийн ердийн өдөр тутмын орчин болтол төлөвшүүлэх үүрэг хүлээнэ²⁵.

Энэхүү хичээлийн судалгааны менежментийг нэгэн А сургуулийн жишээгээр тайлбарлая.

1. А сургуулийн эрхэм зорилгод мэдээллийн зуунд ажиллаж амьдрах ирээдүйн иргэд болсон сурагчдадаа мэдээлэл боловсруулах чадвар эзэмшүүлэхээр тусгасан байна. Тиймээс хэлэлцүүлгийн дүнд байгалийн ухааны багш нарын баг “мэдээлэл боловсруулах чадварыг дэмжсэн багшлах арга зүй”-г хөгжүүлэх хичээлийн судалгааг хэрэгжүүлэх зорилго товлосон байна.
2. Хичээлийн судалгааны зохион байгуулалтын уулзалтаар ажиглагчдын багийг томилж, ажиглах зүйл, аргачлалаа тогтсон байна.
3. Эхний судалгаат хичээлээр ажиглагчид суралцагчдын мэдээлэл боловсруулах чадвар болон багшийн арга зүйг ажиглаж хэлэлцүүлгээр эхний төлөв байдлыг хамтран тодорхойлно. Мэдээж хичээлийн судалгааны багийн гишүүд эхний судалгаат хичээлийн төлөвлөлтөөс хэлэлцүүлэг хүртэлх бүх алхамд бодит үүрэгтэйгээр оролцоно.
4. Тухайн хичээлийн мэргэжлийн багш нар (1-3) хамтран тодорхой цаг (5-10)-ийн хичээлийг явуулна. Ингэхдээ судалгааны зорилгод тусгагдсан “мэдээлэл боловсруулах чадвар”-г хувь нэмэр болох арга зүйг боломжтой бүх хичээл, хичээлийн элементэд төлөвлөн хэрэгжүүлнэ. Боломжтой бол хичээл төлөвлөхөд оролцсон багш хичээлд ажиглалт (эсвэл багшийн өөрийн судалгаат хичээл²⁶) хийж, дараа дараагийн хичээлд ажиглалтын үр дүнг тусган сайжруулах байдлаар явна.
5. Явцын судалгаат хичээлийг цаг хугацаанаас хамааруулан хэдэн ч удаа явуулж болно. Гагцхүү явцын судалгаат хичээлээс өмнө хичээл заах багш түрүүчийн судалгаат хичээлээс хойш хэчнээн цагийн хичээл явуулсан,



Загвар 3. Тодорхой чадвар төлөвшүүлэх багшлах аргачийг судлах

²⁵ Фүкүчи,

²⁶ Фүкүчи,

түүний хэдэн хувь нь зорилгод тодорхойлсон чадвар төлөвшүүлэхэд чиглэсэн, ямар ямар арга зүйг хэрэглэсэн болон сурагчдын чадвар ямархуу байдлаар дээшилсэн талаарх өөрийн бодол, ажиглалт, энэ хичээлийн онцлогийг танилцуулна. Ингээд ажиглагчид судалгаат хичээлээр суралцагчдын мэдээлэл боловсруулах чадвар болон багшийн арга зүйн ахиц дэвшлийг ажиглаж, хамтын хэлэлцүүлгээр явцын төлөв байдлыг тодорхойлж, цаашдын үйл ажиллагаанд тусгах зүйлээ тогтоно.

6. Багшийн өөрийн судалгаат хичээл (4-т өгүүлсэнтэй ижил)

Хичээлийн судалгааны зорилтот хугацаанаас хамаарч “багшийн өөрийн судалгаат хичээл” → “судалгаат хичээл” → “багшийн өөрийн судалгаат хичээл” гэсэн давталтыг хэд хэдэн удаа хийнэ.

7. Төгсгөлийн судалгаат хичээлээр ажиглагчид сурагчдын мэдээлэл боловсруулах чадварын хөгжлийн түвшин, төлөвшлийн хурд, багшийн арга зүйн хөгжил, багш сурагчдын арга зүйдээ эвлэж дадсан байдал гэх мэт зүйлийг ажиглаж хамтын хэлэлцүүлгээр эцсийн төлөв байдлаа тодорхойлно.


8. Хичээлийн судалгааны үр дүнг дүгнэх уулзалтаар хичээлийн судалгааны энэхүү нэг удаагийн циклийн үр дүнг дүгнэж, зорилгыг нарийвчлан цааш үргэлжлүүлэх, эсвэл дараагийн шинэ зорилго дэвшүүлэх эсэх талаар шийдвэр гаргана.

Энд санал болгосон загваруудыг янз бүрийн байдлаар хослуулан хэрэгжүүлж болох юм.


2.6. Хичээлийн судалгааны менежментийн загварыг хэрэгжүүлэх зөвлөмж

Хичээлийн судалгаагаар багшлах арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бүхжүүлэхэд сургуулийн удирдлагаас эхлээд бодлого боловсруулагч хүртэлх түвшинд менежментийн манлайлал маш чухал үүрэгтэй юм. Бидний санал болгосон хичээлийн судалгааны менежментийн загварыг хэрэгжүүлэхэд анхаарах зарим нэг зүйлийг дараах хүснэгтэд үзүүлэв.


Загвар	Загвар 1а. Тодорхой арга зүйг сайжруулж хөгжүүлэх
Давуу, сул тал	Тодорхой сэдвийн хүрээнд дидактик шийдэл, арга зүйг боловсронгуй болгоход ижил мэргэжлийн багш нарын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх давуу талтай. Сургуулиудад зарим мэргэжлийн багш цөөн, 1-2 байдаг манай орны нөхцөлд сургуульд суурилсан байдлаар хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй. Хэт туйлширвал “идеал” загвар боловсруулах гэсэн өрөөсгөл ойлголтод хүргэнэ.
Сургуулийн удирдлага	Ижил мэргэжлийн багш нарын хамтарсан “судлагдахуунд суурилсан” хичээлийн судалгааг хэрэгжүүлэхэд багшдаа оролцох боломж олгоход анхаарах
БСГ-ын мэргэжилтэн	Тухайн орон нутгийн нэг мэргэжлийн багш нарын хамтын ажиллагаанд БСГ-ын мэргэжилтэн чухал үүрэгтэй бөгөөд орон нутгийн хэмжээнд хичээлийн судалгааны сэдэв зорилгыг оновчтой тодорхойлох, сургуульд суурилсан хичээлийн судалгаатай залгамж холбоотой байхад анхаарах
Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийг түшиц сургуульгүйгээр төсөөлөх аргагүй юм. Түшиц сургуулиудынхаа хүрээнд энэ менежментийн загвараар хичээлийн судалгааг хийж үр дүнг багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, судалгаандаа хэрэглэх нь зүйтэй.




Загвар	Загвар 1б. Туршлага судлах, тодорхой арга зүйг уламжлан хэрэглэх, сайжруулах
Давуу, сул тал	Туршлага солилцох, дэлгэрүүлэх, төрөл бүрийн сургалтын зориулалтаар хэрэгжүүлэхэд тохиромжтой Түгээн дэлгэрүүлсэн туршлага, арга зүйн эргэх холбоог хангахад менежерээс нэлээд хүч, анхаарал шаардана.
Сургуулийн удирдлага	Мэргэжлээс үл хамааран хичээлийн судалгаагаар түгээн дэлгэрүүлэх, ажлын байран дээрээ мэргэжил дээшлүүлэх зэрэгт энэ загварыг сургуулийн түвшинд хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлж болно.
БСГ-ын мэргэжилтэн	Манай аймаг, бүсүүд “бүсийн төв”-үүдээ түшиглэсэн менежментээр аливаа түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг явуулдаг. Тиймээс бүсийн төвийг түшиглэсэн хичээлийн судалгааны тодорхой үед энэ менежментийн загварыг давталттайгаар хэрэгжүүлж болох юм.




Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч	Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг олон янзын хэлбэрээр явуулж болох нь тодорхой. Хичээлийн судалгааны тухайд Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйчид түшиц (загвар) сургууль дээрх хичээлийн судалгааг мэргэжил дээшлүүлэх сургалтын практик туршилт болгон хэрэглэх нь хичээлийн судалгааны менежментийн 16 загварын хэрэглээний нэг хэлбэр болох болов уу.
--	--



Загвар	Загвар 1в. Өмнө хийгдсэн хичээлийн судалгааны дүнг хэрэглэх
Давуу, сул тал	Цаг хугацаа, орон зайн хягаарлалтаас үл хамааран хичээлийн судалгаагаар сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, сургалтын зорилгоор хэрэгжүүлэх боломжтой. Шаардлага хангасан хэмжээнд дэлгэрэнгүй, ойлгомжтой, зохистой тайлан боловсруулахад нэмэлт чадвар, материаллаг нөөц шаардлагатай.
Сургуулийн удирдлага	Сургуулийн хэмжээнд хичээлийн судалгааны тайлангийн ижил төсөөтэй загвартай байвал ойлголцлын ач холбогдолтойгоос гадна тухайн сургуульд багшлахаар шинээр ирсэн багш нарт мэдээллийн үнэт эх үүсвэр болгон хэрэглүүлэх боломжтой.
БСГ-ын мэргэжилтэн	Анхны жилдээ ажиллаж байгаа шинэ багшийг ажлын байранд нь дасгах сургалтыг БСГ хариуцдаг. Энэ чиг үүргийн хүрээнд залуу багшид зориулсан сургалтын хэрэглэгдэхүүн болгон хичээлийн судалгааны тайланг хэрэглэх боломжтой. Мөн сургууль, багшийн сайн туршлагыг бага зардлаар, богино хугацаанд, өргөн хүрээнд түгээх нэгэн боломж байх болов уу.
Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч	Зайны сургалтын материал болгон хэрэглэхээр тооцож бодит хичээлийн судалгааны тайланг тодорхой, тодорхой тохиолдлын онцлогийг товойлгон гаргасан байдлаар бэлтгэж мэдээллийн сан бэлтгэх нь зүйтэй юм.



Загвар	Загвар 2. Ялгаатай байдлыг тогтоох
Давуу, сул тал	Сурагчийн суралцахуй, багшийн багшлахуйг олон талт, ялгаатай байдлын хувьд ойлгох, илрүүлэх, боловсролын судалгааны түвшинд баримт бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой. Хичээлийн судалгааны үр дүнг боловсруулахад багийн гишүүдээс “судлаач”-ийн түвшний зарим нэмэлт мэдлэг, чадварыг шаардах нь багш нарт хүндрэлтэй байж болно.
Сургуулийн удирдлага	Сургуулийнхаа сурагчдын болон багшийн хөгжил, чадварыг, сургалтынхаа чанарыг бусад сургуультай харьцуулан харах өргөн боломжийг олгох учраас ийм загварын менежменттэй хичээлийн судалгааг дэмжих нь зүйтэй.
БСГ-ын мэргэжилтэн	Сургуулиуд дээр зохион байгуулагдаж байгаа хичээлийн судалгааны үр дүнг нэгтгэн аймаг, дүүргийн хэмжээнд гаргасан дүгнэлтээ багш, сургуулиудад мэдээлэх нь хичээлийн судалгааны чанарыг дээшлүүлэх чухал алхам болно.
Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч	Судалгаа арга зүйн байгууллага болохын хувьд өөрийн салбарын тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлохын тулд зорьсон хичээлийн судалгааг энэ загварын менежментээр хэрэгжүүлж олсон үр дүнгээ багш нарын мэргэжил дээшлүүлэх ажлын бодлого тодорхойлоход хэрэглэх боломжтой юм.



Загвар	Загвар 3. Тодорхой чадварыг төлөвшүүлэх багшлах аргазүйг судлах
Давуу, сул тал	Сургуульд болон судлагдахуунд суурилсан хичээлийн судалгааны аль алинд хэрэглэх боломжтой, бөгөөд хичээлийн судалгааны тасралтгүй байх шаардлагыг илүү хангадаг.
Сургуулийн удирдлага	ЗАН-ийн хэд хэдэн хичээлийн судалгааны хүрээнд тодорхой анги (жишээ нь, 9-р ангийн хими, физик, математик, биологи)-д явуулснаар багшлахуйн арга зүйн хөгжил сурагчийн хөгжилд хэрхэн нөлөөлж байгааг тогтолцоонд нь харах, багш нарыгаа хөгжүүлэх, хичээлийн залгамж холбоог агуулгын төдийгүй арга зүй, хэрэглэгдэхүүний түвшинд хангах боломж олгоно.
БСГ-ын мэргэжилтэн	
Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч	Мэргэжлийн байгууллага болохын хувьд өөрийн салбарын тулгамдсан асуудлыг тодорхойлон түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлохын тулд зорьсон хичээлийн судалгааг энэ загварын менежментээр хэрэгжүүлж олсон үр дүнгээ багш нарын мэргэжил дээшлүүлэх ажлын бодлого тодорхойлоход хэрэглэх боломжтой юм.

III. БАГШЛАХУЙН АРГА ЗҮЙН ХӨГЖЛИЙГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЕНЕЖМЕНТ

Дэлхийг бүхэлд нь хамарсан улам бүр хурдтай, эрчтэй явагдаж буй өөрчлөлт шинэчлэл нь Монголын нийгэм, боловсролын тогтолцооны шинэчлэлд тусгалаа олж, улам бүр гүнзгийрэх хандлагатай болсоор байна.

Аливаа улс орны хийгээд хүн төрөлхтний тогтвортой хөгжлийн шавхагдашгүй эх сурвалж нь хүний хүчин зүйлийн нөөц болж, түүний чадамж бүтээмжээс хөгжлийн чанар, үр ашиг үлэмж хамаардаг болсон өнөө үед улс орнууд хүн төвтэй хөгжлийн бодлого баримтлан боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, хүн амынхаа боловсролыг чанаржуулахад хүч анхаарлаа хандуулж, бүхий л боломжоо дайчлан ажиллах болжээ.

Монгол улс ч хөгжлийн энэ нийтлэг хандлагаас гажаагүй. Харин ч энэ нийтлэг хүчин чармайлтад нэгдэхдээ 1992 онд Монгол улсын сонгосон нийгмийн хөгжлийн шинэ эрхэм зорилгодоо нийцүүлэн боловсролын тогтолцоог бүхэлд нь шинэчлэн төлөвшүүлэх үйл явц үргэлжилсээр байгаа бөгөөд бид энэхүү хариуцлагатай бөгөөд сонирхолтой, бас ээдрээтэй цаг үеийг туулж яваа билээ.

Боловсролын тогтолцооны шинэчлэлийн суурь өөрчлөлтийн нэг нь *сургалтын технологийн буюу багшлахуйн арга зүйн шинэчлэл* билээ. Энэхүү шинэчлэл нь боловсролын хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, салбарын өмнө тулгарсан асуудлыг шийдвэрлэх хэрэгцээг тус тус хангахад чиглэж байсан. Багшлах арга зүйг шинэчлэх онол, арга зүйн болон хөгжлийн бодлого, стратегийн шийдлүүд хийх нь нэг хэрэг, харин тэдгээрийн үзэл санаа, агуулгыг түгээн дэлгэрүүлж таниулах, хэрэгжүүлэх нь өөр хэрэг юм.

Иймээс энэ бүлэгт эхлээд энэхүү гарын авлагын нэгдүгээр бүлэгт танилцуулсан орчин үеийн багшийн ур чадварт тавигдах шинэ шаардлагыг хангасан байхаар сургалтын арга зүйг шинэчлэх талаар Монгол Улсын төрөөс баримталсан стратегийн болон менежментийн шийдлүүдийг боловсролын шинэчлэлийн тодорхой үе шатуудад ямар арга замаар хэрхэн таниулж, арга зүйн шинэчлэлийг ямар менежментээр хэрхэн түгээн дэлгэрүүлж ирсэн талаар өгүүлэх болно. Дараа нь Япон улстай хамтран хэрэгжүүлсэн төслийн менежментийг танилцуулж, багшлах арга зүйн хөгжилд хичээлийн судалгааны оруулсан хувь нэмэр, ач холбогдол, цаашид авах сургамжийн талаар төсөлд хамрагдсан загвар аймаг, дүүрэг, сургууль, багш гарын үнэлгээ дүгнэлтийг танилцуулна. Эцэст нь багшлах арга зүйн хөгжлийг цаашид хэрхэн үргэлжлүүлэн түгээн дэлгэрүүлэх менежментийн талаар товч өгүүлнэ.

3.1. Багшлах арга зүйн шинэчлэлийг түгээн дэлгэрүүлсэн менежмент

Өнөөг хүртэл сургалтын шинэ арга зүйг түгээн дэлгэрүүлэх менежмент нь институцэд биш, төсөл, хөтөлбөрийн менежментэд суурилсан, үйл ажиллагааны үндсэн хэлбэрт нь мэргэжил дээшлүүлэх сургалт давамгайлж байсан гэж үзэж болно. 2012 онд Монгол Улсын Засгийн газраас институцэд суурилсан багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бий болгон төлөвшүүлэх зорилт дэвшүүлсэн өнөө үед сургалтын шинэ арга зүйг түгээн дэлгэрүүлж ирсэн туршлага, сургамж нь цаашид багшлах арга зүйн шинэчлэлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог сайжруулахад чухал ач холбогдолтой.

Иймээс гарын авлагын энэ бүлгийн эхний хэсэгт боловсролын шинэчлэлийн хэрэгцээг шалгуур болгон шинэчлэлийн 4 үе шатыг ялгаж, тус бүрд нь хэрэгжүүлсэн томоохон хөтөлбөр, төслүүдээр сургалтын шинэ арга зүйг түгээн дэлгэрүүлсэн менежмент (хэдий хэрийн санхүүжилтээр хэн, хэзээ, хэнд, хэдэн үе шатаар ямар агуулгыг ямар арга хэлбэрээр, яаж)-ийг товч танилцуулаад дараа нь тэдгээр түгээн дэлгэрүүлэх менежментийн загваруудыг нэгтгэн үзүүлэхийг зорьлоо. Сургуулийн багш, мэргэжлийн албан хаагчид, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг эрхэлж буй байгууллагууд тухайн хөтөлбөр, төслийн зорилго, хамрах хүрээ, зорилтод бүлэг, санхүүгийн хэмжээ зэргээс хамааруулан тэдгээр загвараас тохиромжтойг сонгох, хослуулах, шинэчилсэн хувилбарыг бүтээж хэрэглэх боломжтой юм.

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас 1990 оноос хойших 10 гаруй жилд үндэсний стандарт, киррижюлим сургалтын төлөвлөгөөг шинэчлэх хүрээнд дараах чиглэлээр холбогдох шийдвэрүүдийг гаргаж, хэрэгжилтийг зохицуулсан. Үүнд:

1. Багшлах арга зүйн онол, арга зүйн үндсүүд, сургалтын менежментийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, хэрэгжүүлэх үеийн арга зүй (1990-2001)

- Сургалтын агуулгыг нээлттэй болгох
- Агуулгын стандарт боловсруулж мөрдөх
- Нийгмийн ухаан, гадаад хэлний сургалтын агуулгыг шинэчлэх
- Сургалтын бүтээлч аргуудыг сургалтад нэвтрүүлэх
- Сурах бичгийн хангалтын шинэ тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх
- Сургуулиудыг байгалийн ухааны хичээлийн лаборатори, компьютерийн кабинеттэй болгох
- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үнэлгээний шинэ тогтолцоонд шилжих зэрэг болно.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхтэй уялдан 1990-2001 оны хооронд багшлах арга зүйн онол, арга зүйн үндсийг шинжлэн судлах, арга зүйг шинэчлэх агуулга ба стратегийг тодорхойлох, сургалтын менежментийг шинэчлэх, улмаар тэдгээрийн үзэл санаа, арга зүйг нийт багш нарт түгээн дэлгэрүүлж, хэрэгжүүлэх ажлын үржил шимтэй хөрсийг бүрдүүлж, цаашдын тогтвортой хөгжлийн үндэс суурийг тавих эргэлтийн шинжтэй үйл явц эхэлсэн билээ.

Бага, дунд боловсролын төвшинд 1992 оноос ДАНИДА, 1994 оноос ЮНИСЕФ, 1996 оноос АХБ-ны дэмжлэгээр эхэлсэн Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөрүүд болон 1998 оноос эхэлсэн МННХ-ийн Монголын боловсролын шинэчлэлийг дэмжих хөтөлбөрүүд, 1996 оноос эхэлсэн НҮБ-ын ХАС-аас хэрэгжүүлсэн өсвөр үеийнхний нөхөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөр, 1998 оноос эхэлсэн ШХА, ГХАН, АС-ийн тогтвортой хөгжлийн боловсрол, байгаль орчны боловсролын хөтөлбөрүүд түүнчлэн гадаад дотоодын бусад байгууллагаас хэрэгжүүлсэн олон төсөл, хөтөлбөр нь дээрх шийдвэрийг хэрэгжүүлэхэд тухайлбал, сургуулийг хөгжүүлэх, сургалтын чанар, үр өгөөжийг сайжруулах, сургалтын арга зүйг шинэчлэхэд бодитой дэмжлэг үзүүлж, манай орны боловсролын шинэчлэлд сургуульд суурилсан өөрчлөлтийн үзэл санаа, арга зүйг хэлбэржүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулжээ.

ДАНИДА-гийн төслүүд

Боловсролын удирдлагын төвлөрлийг сааруулж, сургуульд суурилсан боловсролын менежмент бий болгох шинэчлэлийн зорилтын хүрээнд хөдөөгийн болон алс зайдуу орших бага, дунд сургуулийн багш нарт мэргэжлийн туслалцаа үзүүлэх хэрэгтэй болсон. Данида нь 1990 оноос Монголд боловсролын хөтөлбөр, төслүүдийг санхүүжүүлэхэд оролцож, техникийн туслалцаа үзүүлж эхэлсэн анхны гадаад улсын түншлэгч байгууллагуудын нэг юм. Данидагийн төслүүд нь орон нутаг, сургуулийн түвшинд багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжих болон сургалтын арга зүйн шинэчлэлд шавь төвтэй сургалтын үзэл санааг анх удаа оруулахад томоохон хувь нэмэр оруулсан. Данида нь 1995-1997 онд суралцагчийн сурлагын амжилтын үнэлгээний чиглэлээр төсөл хэрэгжүүлж, 1997-1998 оны хичээлийн жилээс ЕБС-ийн суралцагчдын үнэлгээ шинэ тогтолцоонд шилжснээр төслийн үр дүн нь амжилттай институтчилэгдсэн юм. Суралцагчдын үнэлгээний шинэ аргыг хэрэглэхэд багш нарт тодорхой хүндрэлүүд учирч, түүнийг даван туулахад нь туслах мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааны шинэ чиглэл, агуулга ийнхүү бий болсон билээ.

МННХ-ийн төслүүд

Соросын сангийн санхүүжилтээр МННХ-ээс 1998 оноос эхлэн “Сургууль 2001”, “Нийгмийн ухаан-Эрх зүйн боловсрол”, “Англи хэл”, “Шүүмжлэлт сэтгэлгээ ба унших бичих чадвар”, “Мэтгэлцэн”, “Алхам алхмаар” зэрэг төслөөс бүрдсэн томоохон хөтөлбөр хэрэгжүүлсэн билээ. Эдгээр төсөл нь сургуульд суурилсан шинэчлэлийн үзэл санааг (i) сургуулийн үйл ажиллагаанд бодит үйл хэрэг болгох (шинэчлэлийн дороос дэмжих нээлттэй сургуулийн сүлжээ), (ii) боловсролын агуулгыг шинэчлэх (нийгмийн ухаан, эрх зүй, англи хэлний хичээлийн агуулга арга зүйн өөрчлөлт), (iii) багш, суралцагчдад шинэ цогц чадамж, хандлага эзэмшүүлэх (шүүмжлэлт сэтгэлгээ, мэтгэлцэх соёл), (iv) тогтвортой хөгжлийг хангах (үндсэн үйл ажиллагааг институтчилэх), (v) шинэчлэлийн үзэл санааг үндэсний түвшинд түгээх (сургууль, бүс, үндэсний түвшний мэдээллийн төвүүд, вэбсайт, сонин)-д чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Мөн МННХ-ээс “Сургууль 2001” төслийн үр дүнг 2001 оны намар үндэсний хэмжээнд зохион байгуулсан “Чанартай боловсрол-Хөгжлийн баталгаа” сэдэвт багш нарын эрдэм шинжилгээний бага хурлаар хэлэлцсэн.

Тус эрдэм шинжилгээний бага хурлаар хөгжүүлэх сургалт болон суралцахуй, багшлахуйн орчин үеийн шинэ парадигмын хүрээнд сургалтын технологитой холбоотой үндсэн ухагдахуун, зүй тогтлын талаар мэдээлэл солилцон ойлголтын зөрөөгөө багасгах, сургалтын технологийн шинэчлэлийн явц, сургалтын бүтээлч аргуудыг эзэмшин сургалтын практикт хэрэгжүүлж буй байдлыг хэлэлцэн

туршлага судлах, сургалтын технологийн асуудлаар оролцогчдын дунд мэтгэлцээн явуулж, мэтгэлцээний арга зүйтэй танилцах, сургалтын бүтээлч аргуудыг хэрэглэсэн видео хичээлүүдэд анализ хийж хэлэлцэн бие биеэсээ суралцах зэрэг олон хэлбэрийн үйл ажиллагаанаас бүрдсэн арга хэмжээ болсон. Сургалтын технологийн шинэчлэлийг цаашид гүнзгийрүүлэх чиглэлийг тодорхойлох боломжийг тус тус олгосон.

Эрдэм шинжилгээний хурлын хүрээнд зохион байгуулсан илтгэл тавих, видео хичээлийн хэлэлцүүлэг хийх, дугуй ширээний ярилцлага, мэтгэлцээн явуулах, үзэсгэлэн гаргах зэрэг мэдээлэл солилцох сонирхолтой олон арга хэмжээнд уг төсөлд хамрагдсан 72 нээлттэй сургуулийн төлөөлөл болон бусад сургууль, байгууллагын 200 орчим багш, удирдлагууд оролцон туршлагаа харилцан хуваалцаж, олон шинэ зүйлийг олж мэдэн цаашдын үйл ажиллагааныхаа чиглэлийг тодруулсан юм. Иймэрхүү үндэсний хэмжээний форум, зөвлөгөөн чуулган, эрдэм шинжилгээний хурал нь шинэ үзэл санааг түгээн дэлгэрүүлэх хүчирхэг арга хэрэгслийн нэг болохыг боловсролын салбарынханд мэдрүүлсэн.

Энэ хугацаанд НҮБ-ын ЮНЕСКО-ийн суралцагчдын сурлагын амжилтын хяналт-шинжилгээ, албан бус боловсролын төслүүд, ЮНИСЕФ-ийн сонгогдсон орон нутаг ба сургууль дахь сургууль завсардсан хүүхдүүдэд зориулсан албан бус боловсрол, бага ангийн багш нарын мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрүүд, НҮБ-ын ХАС-тай хамтран хэрэгжүүлсэн ерөнхий боловсролын сургуульд эрүүл мэндийн хичээл болон нөхөн үржихүйн боловсролын төсөлт хичээлийг тус тус институтчилэх хөтөлбөрүүд хэрэгжсэн юм. Эдгээр хөтөлбөрийн хүрээнд багш нар үнэлгээний даалгавар боловсруулж, сурагчдаа үнэлэх, амьдрах ухаанд суралцах, асуудал шийдвэрлэх зэрэг шинэ арга зүйтэй танилцан сургалтадаа хэрэглэж эхэлсэн.

НҮБ-ын ХАС-тай хамтран хэрэгжүүлсэн “Өсвөр үеийнхний нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол” хөтөлбөрийн хүрээнд 10 өдрийн 80 цагийн модульт сургалтыг 22 бүсэд зохион байгуулж, 2000-2004 оны хооронд Улаанбаатараас 116, аймгаас 591, нийт 707 багш нөхөн үржихүйн эрүүл мэнд болон эрүүл мэндийн сургалтын чиглэлээр мэргэшин бэлтгэгдснээр нийт 700 сургуулийн эрүүл мэндийн боловсролын зөвлөх багш бэлтгэх ажил өндөрлөж, эрүүл мэндийн хичээлийг тогтворжуулах нэг нөхцөл хангагдсан. Мөн Дэлхийн “Global fund” ба Монгол Улсын Засгийн газартай хамтран хэрэгжүүлж буй “ХДХВ ба ДОХ-оос сэргийлэх” хөтөлбөрийн “Сургуулийн боловсрол” дэд төслийн хүрээнд эрүүл мэндийн олон багш бэлгийн боловсрол сургалтын арга зүйд суралцсан.

1997-1998 оны хичээлийн жилээс эхлэн “Сургуулийн шинэчлэлийг дэмжих” гэсэн стратегийг яамнаас хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ стратеги нь боловсролын шинэ тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлэхэд чиглэж, сургуулийн гүйцэтгэх үүргийг тодотгон сургууль дээрх боловсролын бүхий л талыг хамарсан цогц шинжтэй өөрчлөлтийг дэмжих зорилготой байв.

Энэ цаг үетэй давхцан 1998 оноос АХБ-аас санхүүжилттэй БСХХ-үүд хэрэгжиж болсон. Эдгээр хөтөлбөрийн хүрээнд БСШУЯ-аас багшлахуйн арга зүйн шинэчлэлийн чиглэлээр хэрэгжсэн, хэрэгжиж байгаа хөтөлбөр, төслүүдийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, сургалтын технологийн шинэчлэлийн онол арга зүйн үндэслэлийг нэгэн зэрэг бцх сургууль, багш нарт таниулан, сургалтын тогтолцооны шинэчлэлийн агуулга, мөн чанарыг ойлгуулж ухамсарлуулах, шинэчлэлийг сургууль, багш нар үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх менежмент арга замыг хамтран хэлэлцэж сонгох зорилготой агуулга арга зүйн нэгдмэл холбоо бүхий дараах 6 цуврал сургалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулсан. Үүнд:

1. “Сургалтын технологийн шинэчлэл” (Бүх ЕБС-ийн хичээлийн эрхлэгч, аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын төвийн арга зүйч, зөвлөх багш нарт зориулсан)
2. “Хичээл хоорондын холбоо-багш нарын хамтын ажиллагаа” (Бүх ЕБС-ийн ЗАН-ийн ахлагч, Боловсрол, соёлын төвийн арга зүйч, зөвлөх багш нарт зориулсан)
3. “Сургалтын арга зүй” (Бүх ЕБС-ийн хичээлийн эрхлэгч, ЗАН-ийн ахлагч, аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын төвийн арга зүйч, зөвлөх багш нарт зориулсан)
4. “Хичээлийн технологийн шинэчлэл” (8 төрлийн хичээлийн мэргэжлийн багш нарт зориулсан)
5. “Сургалтын менежмент” (Бүх ЕБС-ийн хичээлийн эрхлэгчид зориулсан)

НҮБ-ын
төрөлжсөн
байгууллагуу-
дын төслүүд

ГЯ, АХБ-ийн
төслүүд

6. “Сургуулийн менежмент”: Сургалтыг технологийн менежмент дэд модуль (Бүх ЕБС-ийн захирлуудад зориулсан)

Цуврал сургалт нь сургуулийн захирал, хичээлийн эрхлэгч, ЗАН-ийн ахлагч, туршлагатай багш нарын бүрэлдэхүүнтэй сургуулийн сургагч бэлтгэх бүх сургалтад багш нарыг бүрэн хамруулж, тэдэнд *кирриkjолим тогтолцооны шинэчлэлийн ерөнхий баримжаа* өгөх, шинэчлэлийг гардан хэрэгжүүлэгч багш нарын оролцоо, санаачилгыг идэвхжүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаагаа үр ашигтай, чанартай болгох тэдний эрмэлзэл, хандлагыг дэмжих зорилготой байсан.

1998 онд батлагдсан боловсролын агуулгын шинэ стандартыг бүтээлчээр хэрэгжүүлэх, сургалтын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрөө багш нар өөрсдөө боловсруулах шинэ үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх, үнэлгээний шинэ тогтолцоонд шилжих зэрэг сургуулийн багш, удирдлагуудын өмнө тулгамдчихаад байсан олон зорилтыг хугацаа алдалгүй аль болох эрдэл багатай, аль болох чанартай, үр ашигтайгаар хэрэгжүүлж, цаашид арга зүйгээ тасралтгүй хөгжүүлж байх нөхцөлийг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага тулгараад байв. Энэ хэрэгцээг хангахад кирриkjолим хөгжлийн чиг хандлага, энэ талаар төрөөс баримтлах бодлого, шийдлийн үндэслэл, хэрэгжүүлэх арга замыг шүүн хэлэлцэж, хамтран ажиллах арга зүй бүхий “хийж суралцах” (workshop) дадлага ажил голлосон дээрх цуврал сургалт чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Хөгжлийн төлөө түншлэгч олон улсын байгууллагуудын техникийн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжсэн хөтөлбөрүүд хийгээд Гэгээрлийн Яамнаас зохион байгуулсан цуврал сургалтын үр дүнд багш нар хичээлдээ *сургалтын бүтээлч аргуудыг* өргөнөөр туршиж, багагүй амжилтад хүрсэн билээ. Сургалтын бүтээлч аргууд нь боловсрол судлалын шинэ парадигм (шинэ үзэл санаа, онол)-д тулгуурлан боловсруулсан аргууд тул тэдгээрийн онол арга зүйн үндсийг мэдэхгүйгээр энэ аргуудын бүтээлч чанарыг бүрэн илрүүлж, үр өгөөжийг нь бүрэн хүртэхэд учир дутагдалтай байсан. Энэ хугацаанд багш нарт зориулсан бараг бүх сургалтад эдгээр аргын зориулалт, хэрэглээний талаар голлон анхаарсан бөгөөд харин тэдгээрийн мөн чанар, онол арга зүйн үндсийг тэр бүр тодруулж байгаагүй юм.

Иймээс 2001 онд ЕБС-ийн хичээлийн эрхлэгч нарт зориулан БСШУЯ-аас АХБ-ны санхүүжилтээр зохион байгуулсан “*Сургалтын менежмент*” сэдэвт сургалтыг МУИС-ийн дэргэдэх МДССТ хариуцан явуулж, мэргэжил дээшлүүлэх сургалтын агуулгад анх удаа суралцахуйн болон багшлахуйн орчин үеийн онол, арга зүйн гүн ухаан, арга судлал, сэтгэл судлал, социологи, антропологи болон ардын сурган хүмүүжүүлэх өв уламжлалын үндсийн талаар цогц мэдээлэл боловсруулан оруулж, сургалтын арга зүйн хөгжлийн шинэ хандлагын үүднээс сургалтын менежментийг хэрхэн шинэчлэн хэрэгжүүлэх асуудлыг хөндсөн юм.

Эхний 4 цуврал сургалтын материалуудыг багш нэг бүрд, сүүлийн хоёр сургалтын материалыг сургуулийн сургагч багш нарт хүрэлцэхээр төлбөргүйгээр хүргэж судлуулахын зэрэгцээ бэлтгэгдсэн сургагч багш нар нийт багшид зориулан тодорхой төлөвлөгөөний дагуу сургуулийн сургалтуудыг зохион байгуулсан.

Дээр дурдсан сургалт болон хурлын материалууд, ялангуяа, “Сургалтын менежмент” сургалтад зориулсан гарын авлагыг Монголд үндэсний кирриkjолимийг шинэчлэх онол, арга зүйн үндсийг орчин үеийн олон салбар ухааны зааг дээрээс ул суурьтай хөндсөн, багш нараас сургуулийн болон хичээлийн кирриkjолимийг шинэчлэх, сургах арга барилаа дээшлүүлэхэд онол, арга зүй, итгэл үнэмшлийн шинэ баримжаа болсон анхны бүтээл байсан тул сургалтын эдгээр материалыг олж судлах нь багш нарт тэр тусмаа ЕБС-ийн багш нарын 40 орчим хувийг эзлээд байгаа 5 хүртэл жил ажиллаж байгаа өнөөгийн залуу багш нарт ашиг тусаа өгнө гэдэгт итгэлтэй байна.

Ийнхүү АХБ-ны дэмжлэгтэйгээр хэрэгжсэн “Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд 1999 онд ЕБС-ийн хичээлийн эрхлэгч, ЗАН-ийн ахлагч, захирал нарт зориулан сургалтын технологийн шинэчлэлийн зангилаа асуудлаар зохион байгуулсан “Сургалтын технологийн шинэчлэл”, “Хичээл хоорондын холбоо, багш нарын хамтын ажиллагаа”, “Сургалтын арга зүй” гэсэн эхний гурван цуврал сургалтаар сургалтын технологийг шинэчлэх чиг хандлага, шийдлийн үндэслэл, хэрэгжүүлэх арга замын талаарх ерөнхий агуулгыг тэдэнд танилцуулаад дараа нь тэдгээр сургалтын үзэл санаа, агуулга, арга зүйн ерөнхий асуудлуудыг тодорхой хичээлийн түвшинд буулган нарийвчилж, дунд сургуулийн монгол хэл, математик, физик, хими, газар зүй,

дүрслэх урлаг-технологи, хөгжим болон бага ангийн хичээлийн технологийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой тус бүр хоёр шаттай 8 төрлийн 5-10 хоногийн хугацаатай, 130 гаруй бүсийн сургалтыг мэргэжлийн багш нарт зориулан зохион байгуулсан. Энэхүү мэргэжлийн багш нарт зориулсан сургалтад ЕБС бүрээс 7-10 багш оролцож, улмаар сургууль бүр дээр сургалтын технологийн шинэчлэлийг хариуцан бусад багш нартаа туслах *сургуулийн сургагч багш* нар бэлтгэгдэж байсан бөгөөд аймаг, дүүргүүдэд зөвхөн дээрх сургалтуудаас гадна эрх зүй, эрүүл мэнд, экологи зэрэг хичээлийн төвлөрсөн сургалтуудад давхар хамрагдсан орон нутгийн түвшний 500 орчим сургагч багш бэлтгэгдсэн юм.

2000-2001 онд хичээлийн эрхлэгчдэд зориулсан “Сургалтын технологи”, захирлуудад зориулсан “Сургуулийн менежмент” сургалтыг “дүүжин” буюу “pendulum” загвар ашиглан хоёр үе шаттай явуулсан. Эдгээр сургалтын үр дүнд сургуулиуд анх удаа тус тусын сургалтын үйл явцдаа үнэлгээ, дүгнэлт өгч, сургалтаа хөгжүүлэх стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх бүтэц, хүний нөөц бүрдүүлэх, тухайн нэг ангийн сонгож авсан хичээл дээр хичээл хоорондын холбоог хангасан киррикулимийг шинэ арга зүйгээр боловсруулан турших ажлыг сургуулийнхаа бүх багштайгаа хамтран ажлын байрны талбарт хийх 30 өдрийн дадлага хийж, үр дүнгээ эргэн ирж танилцуулан үндэсний зөвлөхүүдээс зөвлөгөө авч сайжруулан сертификатын ажил хамгаалсан юм. Сертификатын ажил нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байсан. Үүнд:

- Сургалтын орчны судалгааны дүн
- Хөгжүүлэх сургалтын стратегийн төлөвлөгөө, эрхэм зорилгын хамт
- Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө
- Заах аргын нэгдэл байгуулах, ажиллуулах төлөвлөгөө
- Багш нараа хөгжүүлэх төлөвлөгөө
- Тухайн нэг ангийн хичээл хоорондын холбоог тогтоох боломжийг тодорхойлсон судалгааны дүн
- Сонгож авсан сэдвийн сургалтын хөтөлбөр
- Боловсруулсан сургалтын хөтөлбөрөө хэрэгжүүлэх арга замын тухай санал

Энэ хоёр сургалтын шууд үр дүн болж, сургалтын технологийн менежментийг орон нутагт манлайлах чадвартай 90 сургуулийн удирдлагын баг бэлтгэгдсэн бөгөөд дам үр дүн болж Монголын бүх сургуулиуд сургалтын технологи, багшлах арга зүйгээ шинэчлэх дунд *хугацааны төлөвлөгөөтэй* болж, анх удаа сургууль бүр хөгжлийн “*Эрхэм зорилго*”-той болсон юм.

1999-2001 онд Гэгээрлийн яамнаас зохион байгуулсан дээрх 6 сургалтаар нийт 40-168 цаг буюу 5-21 өдрийн сургалтын 6 модуль боловсруулан нийт 80 хэвлэлийн хуудас бүхий 76800 ширхэг сургалтын материал хэвлүүлэн сургууль, багш нарт түгээсэн. Эдгээр сургалтыг үндэсний, бүсийн, сургуулийн гэсэн 3 шаттай “каскад” загвараар зохион байгуулсан ба үндэсний түвшний төвлөрсөн 17 сургалтад 718, бүсийн 162 сургалтад 9055 хүн тус тус хамрагдсан бөгөөд нийт 179 удаагийн сургалтад 9773 багш, удирдах ажилтан хамрагдсан байна. Бүх сургалтад нийт 500 орчим сая төгрөг зарцуулсан бөгөөд энэ зардлыг АХБ-ны БСХХ-өөс бүрэн санхүүжүүлсэн юм. (Хавсралт 1).

Эдгээр цуврал сургалт дараах онцлох үр дүнд хүргэснийг тэмдэглэх нь зүйд нийцнэ. Үүнд:

- Сургалтын арга зүйг гадны ямар нэг зөвлөхийг оролцоо, дэмжлэггүйгээр зөвхөн дотоодын сургагч багш, зөвлөхүүд боловсруулж, гурван жилийн турш цуврал сургалт зохион байгуулах замаар үндэсний сургагчдыг бэлтгэж, стандарт, киррикулимийг шинэчлэх хүний нөөцийг бүрдүүлсэн.
- Албан болон албан бус бүтцийг хоршин, сонирхогчдын нээлттэй оролцоог хангаж, хувь нэмрээ оруулах боломжийг нээлттэй байлгаснаар сургалтуудын шимтэй, системтэй агуулга, арга зүй боловсорсон.
- Шинэ арга зүйг сургууль, багш нэг бүрд хүргэн үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх нийлүүлэлтэд суурилсан анхны (1990 оноос хойших хугацаанд) загварыг туршин бүтээсэн.
- Монгол улсад сургалтын технологи, багшлах арга зүйг шинэчлэх онол, арга зүйн асуудал үндэсний хэмжээнд өргөн далайцтай хэлэлцэгдэж, тэдгээрийн сонголт, суурь шийдлүүд хийгдсэн.

Эдгээр сургалтын агуулга, арга зүй нь өмнөх үеийн сургалтаас зарчмын

ялгаатай байв. Харилцан уялдаа бүхий дээрх цуврал сургалтын агуулга, арга зүй нь өнөө үеийн бодит нийгэм түүхэн нөхцөлийн шинэ шаардлагын дагуу боловсрол судлалын, тэр дотроо, сургалтын технологийн ХӨГЖЛИЙН асуудлыг судлах, хэлэлцэх, турших боломж олгож байсанд оршино. Түүнчлэн цуврал сургалтын дээр дурдсан шууд үр дүнгээс гадна цаашдын шинэчлэлийн үйлсэд зайлшгүй бөгөөд маш чухал нөлөө үзүүлсэн үр дүн бол бидний өмнө нь ойлгож, хэрэглэж байсан *ихэнх ухагдахуун шинэ агуулгаар баяжиж байгааг, мөн олон ухагдахуун шинээр үүсэж байгааг, цаашид ч энэ үйл явц тасралтгүй үргэлжлэхийг* ухаарч ойлгосон, сэтгэлгээ чөлөөлөгдсөн явдал байв. Энэ нь сургалт зохион байгуулж байгаа сургагч багш болон оролцогч багш нарын хэн хэнд нь маш чухал байсан. Сургалтын арга зүйг хөгжүүлэхдээ боловсролын тогтолцооны бүх түвшинд бүтээлчээр хамтран ажиллаж, тухайн асуудлыг олон талаас нь нээлттэй хэлэлцсэнээр асуудлыг гүнзгий танин мэдэж, ойлголтын зөрөө ч багасдагийг, тэр хэмжээгээр нэгдсэн нэг байр сууринд хүрч, сургалтын технологийн шинэчлэлийг бодит үр дүнд хүргэхэд “дуугарвал дуу нэг, дугтарвал хүч нэг” болдгийг сургалтад оролцсон бүх хүн ухаарч эхэлсэн үе байсан юм.

Дүгнэн тэмдэглэхэд, эдгээр сургалтын шууд болон дам, нөлөөт үр дүнг ерөнхий боловсролын сургуулийн нийт багш, удирдах ажилтны боловсрол болон сургалтын талаарх ойлголт, хандлагыг *бүхэлд нь хөгжлийн шинэ чиг баримжаанд хандуулан өөрчилсөн*, тэдэнд *шинэчлэлийг хэрэгжүүлэх урам зориг өгсөн* боловсролын тасралтгүй хөгжлийг хангахад шийдвэрлэх ач холбогдолтой, түүхэнд тэмдэглэхүйц үйл явдлын нэг хэмээн үзэх үндэслэлтэй.

Боловсролын стандартыг боловсронгуй болгон хөгжүүлж байх хөгжлийн ерөнхий шаардлага болон Засгийн газрын 2000 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн боловсролын агуулгыг сайжруулах зорилтын хүрээнд 1998 онд батлагдан мөрдөгдөж байсан “Бага, дунд боловсролын агуулгын стандарт”-ыг шинэчлэн сайжруулах 150 орчим хүний бүрэлдэхүүнтэй Үндэсний багийг БСШУ-ны Сайдын 2001 оны 15 дугаар тушаалаар байгуулж, уг ажлыг шинжлэх ухааны төсөл хэлбэрээр хэрэгжүүлсэн юм.

2. Боловсролын шинэ стандарт, кирриkyюлимийн онол, арга зүйг таниулах, тэдгээрийг хэрэгжүүлэх үеийн арга зүй (2002-2006)

Эрдэм шинжилгээний судалгааны төрөлд хамаарах энэ төслийг бага, дунд боловсролын удирдлага, зохион байгуулалтын бүх түвшний хийгээд ажлын байрны чиг үүргийнхээ дагуу боловсролын стандарттай шууд холбоотой ажилтан, албан тушаалтан, мөн шинэ санаа, мэдээллээр хангах идэвхжүүлэгчдийн төлөөлөл бүхий матрицын бүтэцтэй Үндэсний баг “үйл ажиллагааныхаа явцад суралцах” (action-learning project) түншлэлийн хэлбэрээр хэрэгжүүлсэн юм.

Үндэсний баг нь бага, дунд боловсролын агуулгын бодлого, шинэчлэлийн стратегийн үзэл санаа, стандартыг хөгжүүлэх үзэл баримтлал, арга зүй, бүтэц, дизайн, нэр томъёоны хувилбарыг боловсруулан хэлэлцүүлэх, үйл явцыг чиглүүлэх, дэд хэсгүүдэд дэмжин туслах үүрэгтэй *төв баг*, боловсролын стандартыг агуулгын чиглэл, хичээл бүрээр боловсруулах үүрэгтэй ажлын 16 дэд хэсэгтэйгээр ажилласан.

БСШУ-ны сайдын 2002 оны 202 тоот тушаалаар “Бага, дунд боловсролын кирриkyюлим хөгжил, стандартыг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал”-ыг баталж, 2002-2003 оны хичээлийн шинэ жилийн намрын багш нарын бага хурлаар уг үзэл баримтлалын үзэл санааг тайлбарлан таниулах, түгээн дэлгэрүүлэх ажиллагаа эхэлсэн билээ.

2001 оны намраас 2003 оны хавар хүртлэх хугацаанд БСШУЯ-аас хэрэгжүүлсэн “Бага, дунд боловсролын стандарт” төслийн хүрээнд дээрх асуудлыг шийдвэрлэсэн юм. Энэ хугацаанд 100 гаруй хүний хүч хөдөлмөрөөр бүтээгдсэн дараах 21 бүтээгдэхүүнийг зохих журмын дагуу редакци, экспертийн дүгнэлт гаргуулж, Сайдын зөвлөлийн 2003 оны 5 дугаар сарын 09 ба 22-ны өдрийн хуралдаанаар бүтээгдэхүүн тус бүрийг хэлэлцүүлэн захиалагч талд хүлээлгэж өгсөн. Үүнд:

- Бага, дунд боловсролын стандарт, кирриkyюлимийг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал
- Бага, дунд боловсролын агуулгын стандартад өгсөн үнэлгээ (1998 оны)
- Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын 4 түвшний стандарт
- Агуулын 15 чиглэлийн стандарт

Төслийн бүтээгдэхүүнийг захиалагч талд хүлээлгэн өгсөн болон уг стандартыг турших бэлтгэлийг хангах тухай БСШУ-ны Сайдын 164 дүгээр тушаал

гаргуулан холбогдох байгууллага, хүмүүст нь хүргүүлж, Монголын үндэсний MN телевизийн “Боловсрол өнөөдөр ба маргааш” нэвтрүүлгээр шинэ стандартын тухай 50 минутын шууд нэвтрүүлгийг бэлтгэж хүргэснээр цогц чадамжид суурилсан боловсролын стандарт, түүнийг хэрэгжүүлэх шинэ арга зүйн зарчмуудтай бүх сургууль, багш нар танилцаж эхэлсэн.

Бага, дунд боловсролын стандартыг цаашид турших, таниулах, хэрэгжүүлэх талаар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болно. Үүнд:

Шинэ стандартыг сурталчлах чиглэлээр:

- Боловсролын удирдах ажилтан, багш, сурагч, эцэг эх, олон нийт зэрэг зорилтот бүлэг бүрд зориулан Бага, дунд боловсролын стандартын үзэл санааг тусгасан мэдээлэл, сурталчилгааны материал бэлтгэх
- Шинэ стандартыг хэрэглэгчдэд ойлгуулах сургалт сурталчилгааны ажлыг олон сувгаар тодорхой үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх

Шинэ стандартыг туршиход бэлтгэх чиглэлээр:

- Стандартыг нийт сургууль, багш нарт хүрэлцэхээр хэвлэж, түгээх
- Боловсролын стандартыг турших ажлын агуулга, арга зүйг боловсруулах
- Бага, дунд боловсролын стандартыг боловсруулсан багийн төлөөлөлтэйгээр турших ажлын менежмент багийг зохион байгуулж, ажиллуулах

Туршилтад бэлтгэх болон турших үйл явцад тогтмол хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх замаар стандартыг боловсронгуй болгох нөхцөлийг хангах

Шинэ стандартыг хэрэглэх нөхцөлийг бүрдүцлэх чиглэлээр:

- ЕБС-ийн суралцах хугацааг 10-11 жилд шилжүүлэх стандартад нийцсэн үндэсний киррикулим, сургалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах;
- Стандартад нийцүүлсэн сурах бичигт тавих шаардлагыг шинэчлэх;
- Стандартыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан боловсролын удирдах ажилтан, сургалтын менежер, мэргэжлийн багш нарт зориулсан гарын авлага, зөвлөмжийг боловсруулан хүргэх;
- Стандартыг хэрэгжүүлэхэд шаардлагатай материаллаг орчныг бүрдүүлэх;
- Багш нарын мэргэжил дээшлүүлэх тогтолцоог шинээр бүрдүүлэх, шинэ стандартыг хэрэгжүүлэх тодорхой бодлого, чиглэл бүхий график, төлөвлөгөө боловсруулан төвлөрсөн, бүсчилсэн, зайны зэрэг сургалтын олон арга, хэлбэрийг ашиглан орон нутгийн, сургуулийн, хичээлийн киррикулимийг боловсруулан хэрэгжүүлэхэд нь сургууль багш нарт туслах;
- Стандартыг хэрэгжүүлэх чадвартай багш бэлтгэхийн тулд багш бэлтгэх сургуулиудын багш боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн өөрчилж, боловсронгуй болгох.

Цогц чадамжид суурилсан боловсролын шинэ стандартыг боловсруулах багийнханд зориулсан дараах сургалтыг зохион байгуулсан ба үүний үр дүнд тэдний ойлголтын зөрөө багасаж, стандарт, киррикулим хөгжлийн үндсэн нэр томъёог цэгцэлж, чанарын харьцангуй өндөр түвшинд багууд бүтээгдэхүүнээ боловсруулах боломж бүрдсэн юм.

- “Төслийн менежмент” (2002 оны 3 сар)
- “Стандарт боловсруулах аргачлал” (2002 оны 4 сар)
- “Стандарт боловсруулах ажлын явцын үнэлгээ” (2002 оны 5 сар)
- 16 дэд хэсгийн салбар сургалтууд (2002 оны 5 сар)
- “Стандартын редакци” (2002 оны 10 сар)
- “Стандартын экспертиз” (2002 оны 11 сар)
- “Стандартыг таниулах, хэрэгжүүлэх арга зүй”(үндэсний болон орон нутгийн сургагч бэлтгэх сургалт, 2003 оны 8 сар)
- Аймаг, нийслэлийн багш нарын бага хурал, сургуулийн сургагч бэлтгэх сургалтууд (нийт сургууль, багш нарт зориулсан 22 бүсийн сургалт, 2003 оны 8 сар)

Цаашид стандартыг шинэчлэн боловсронгуй болгож байх онол, арга зүйн хувьд мэргэшсэн хүний нөөц бүрэлдэн, чадавхажсан төдийгүй стандартыг хэрэгжүүлэхэд багш нарт туслах үндэсний сургагч багш нар давхар бэлтгэгдсэн ач холбогдолтой байв.

Шинэ стандарт хэрэгжүүлэх арга зүйг таниулах, түгээн дэлгэрүүлэхийн тулд боловсролын хөгжлийн чиг хандлагыг танилцуулах, стандартын үзэл баримтлал, агуулга, бүтэц дизайныг ойлгох, стандартын код ба хэлд тайлагдахад нь дэмжлэг

болгож дараах материалууд боловсруулан сургууль нэг бүрд хүрэхээр хэвлэж түгээсэн байна. Үүнд:

- Боловсролын түвшний 4 стандарт
 - Агуулгын 15 чиглэлийн стандарт
 - Стандартын ерөнхий товч танилцуулгын хуудас, зурагт хуудас
 - Стандарт бүрийн товч танилцуулгын хуудас
 - Стандартын ерөнхий зөвлөмж
 - Математик, монгол хэл, физик, хими, түүх нийгмийн ухааны стандартын зөвлөмжүүд
 - Сургалтад болон багш нар хэрэглэх 20 тулгуур дохио бүхий слайдын багц
- Дээрх материалуудыг боловсруулах, хэвлэх, сурталчлах, орон нутгийн сургагч бэлтгэхэд нийт 43,8 сая төгрөг зарцуулсан бөгөөд энэ зардлыг БСШУЯ-ны харьяа Шинжлэх ухаан технологийн сан болон МНХ, АХБ-БСХХ, НҮБ-ын Хүүхдийн сангаас тус тус санхүүжүүлсэн ажээ.

Дашрамд тэмдэглэхэд, маш богино хугацаанд маш бага хөлсөөр боловсролд эрэмбэ ахисан чанарын өөрчлөлт гаргаж, цаашдын хөгжил дэвшилд хөтөлж чадахуйц орчин үеийн шинжлэх ухааны үндэстэй, амьдрал, практикт хэрэгжүүлэх боломжтой стандарт ба кирриkyолим шинэчлэлийн шийдлийг гадны зөвлөхийн оролцоогүйгээр боловсруулж, хэлбэржүүлэхэд үнэтэй хувь нэмрээ оруулсан манай салбарын шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагч, эрдэмтэн судлаач, багш сурган хүмүүжүүлэгчдийн эх оронч сэтгэл, шинжлэх ухаанч хандлага, арга барил, мэргэжлийн ур чадвар боловсролын түүхэнд тод бичигдэн үлдэх учиртай.

Шинэ стандартыг 2004 онд нийслэлийн болон аймгийн төвийн, сумын сургуулиудад туршин сайжруулж, 2004 оны Стандартчилал Хэмжил Зүйн Үндэсний Төвийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталж, 2004-2005 оны хичээлийн жилээс улс даяар мөрдөх шийдвэр гарсан байна.

Цогц чадамжид суурилсан боловсролын стандартыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхийн тулд БСШУЯ-аас 2009 он хүртэл хичээлийн шинэ жилийн зорилтод жил бүр тодорхой зорилтуудыг дэвшүүлэн, хэрэгжилтэд нь үнэлгээ өгсөөр ирсэн. Энэ он жилүүдэд стандартыг судалж, түүний шаардлага хангасан сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүйд багш нар суралцах ажил сургууль, орон нутгийн түвшинд өрнөж байв. Энэ хугацаанд сургууль, орон нутгийн сургалтууд олноор зохион байгуулагдаж байсан. Энэ нь багш “цаастай ажилладаг” гэсэн шүүмжлэлийг дагуулж байсан боловч сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүйд суралцахгүйгээр багшлах арга зүйгээ хөгжүүлэх боломжгүй нь тодорхой тул энэ шүүмжлэлийг тойрч бус туулж гарах ёстойг хөгжлийн үе шат гэж үзэх нь зүйтэй. Мөн багшлах арга зүйгээ оновчтой сонгож, сургалтын хөтөлбөр боловсруулахад нь үе шаттай бодит дэмжлэг үзүүлэх менежмент үндэсний болон орон нутгийн түвшинд сул байсныг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Түүнчлэн, стандартын хэрэгжилтийг үнэлэх хөндлөнгийн тогтолцоо үгүй болж, суралцагчдын сурлагын амжилтыг үнэлэх журмын шинэчлэл удаарширсан зэрэг нь эрчимтэй эхэлсэн үйл явцыг хурд, үр өгөөжийг сулруулахад нөлөөлснийг ч бас дурдах шаардлагатай.

БСШУЯ-аас баталсан шилжилтийн графикийн дагуу Бага, дунд боловсролын стандартад нийцүүлэн сургалтын үндэсний хөтөлбөрийг боловсруулан баталж, сурах бичгүүдийг бэлтгэн түгээж, багш нарыг сургалтад хамруулах үндсэн дээр ерөнхий боловсролын сургуулийн ангиудыг дараах байдлаар 12 жилийн сургалтад шилжүүлж байгаа билээ.

Хүснэгт 3.1. ЕБС-ийн сургалтыг 12 жилд шилжүүлэх төлөвлөгөө

Хичээлийн жил	12 жилийн сургалтад шилжсэн анги
2007-2008	1
2008-2009	2, шилжилтийн 7
2009-2010	3,8
2010-2011	4, 9
2011-2012	5, 10
2012-2013	6,11
2013-2014	7,12

3. ЕБС-ийн сургалтын хугацааг 11, 12 жилд шилжүүлэх, үндэсний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үеийн арга зүй (2007-2012)

Нэг дүгээр ангийн багш нарын сургалт

Улсын хэмжээнд 7 ба 6 настай хүүхдийг сургуульд элсүүлэх замаар ЕБС-ийн сургалтыг 2008 онд багтаан 10 жилийн тогтолцооноос 11 жилд, 2008-2015 онд багтаан 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх зорилт боловсролын

салбарынхны өмнө хүндхэн сорилтыг авчирсан. Юуны өмнө ЕБС-ийн бага ангийн багш нарт энэ насны хүүхдийн онцлогийг судлан мэдэж, түүнд тохирсон сургалтын арга зүйд суралцах тулгамдсан хэрэгцээ бий болсон.

Иймээс Боловсролын мастер төлөвлөгөөний нэг томоохон зорилт болох дээрх шилжилтийг амжилттай хэрэгжүүлж, бага насны хүүхэд сургах арга зүйд багш нарыг сургахад Дэлхийн Банкны Каталик сангаас санхүүжүүлсэн “Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл” хөтөлбөрийн “Бага боловсролын чанарыг дээшлүүлэх” төсөл чухал үүрэг гүйцэтгэсэн.

БСШУ-ны Сайдын 2007 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан ЕБС-ийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх графикийн дагуу ойрын жилүүдэд бага ангид шаардагдах багшийн хэрэгцээ, өнөөгийн төлөв байдлыг үнэлж үзэхэд 2008-2015 онд бага ангийн багш нэг их дутагдахгүй болох нь харагдсан бөгөөд шилжилтийн үеийн багшийн талаар баримтлах бодлогыг нь бага ангийн багш нарыг 6 ба 7 настай хүүхдийг сургах арга зүйд сургахад чиглүүлэх шаардлагатай болсон. Энэ бодлогыг хэрэгжүүлэхээр дараах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Тухайлбал,

Зургаан настай хүүхдийг сургууль, нийгмийн орчинд дасгаж, сурах арга барил эзэмшүүлэх, тэдний бие бялдар, оюун ухаан, сэтгэл нийгэмшлийн хөгжлийг багшлах үйлээр дэмжин тэтгэх арга зүйд бага ангийн бүх багшаа сургах зорилгоор харилцан уялдаатай хэд хэдэн модуль бүхий нэгдсэн агуулгатай цуврал сургалтыг гурван жил дараалан зохион байгуулсан. Эдгээр сургалтад нийт 339 сургагч багш, 4832 нэгдүгээр ангид хичээл заах багш, 532 бага ангийн сургалтын менежер, 589 дотуур байрны багш, 624 нийгмийн ажилтан, нийт 6916 хүн хамрагдсан²⁷ байна. Жил бүрийн сургалтад хичээл заах багш нараас гадна сургууль дээр 6 настай хүүхэдтэй ажиллах сургалтын менежер, нийгмийн ажилтан, дотуур байрны багш зэрэг мэргэжлийн бусад албан тушаалтанд зориулсан хэд хэдэн сургалтыг тусгай агуулга, гарын авлага бүхий бие даасан сургалтын хөтөлбөрөөр зохион байгуулсан байна.

2008 оны сургалтын агуулга нь үндэсний хөтөлбөрийн агуулга, арга зүйн онцлогийг таниулах, 2009 оны сургалт хичээл бүрээр нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх арга зүйн онцлогийг таниулахад илүү анхаарч байсан бол 2010 оны сургалт нэгж хичээлийн чадвараар хэмжээсжүүлж, сурагчдын эзэмшсэн мэдлэг чадвар, төлөвшилийг стандарт бус үнэлгээгээр үнэлэх арга зүйг зөвлөхөд түлхүү анхаарсан онцлогтой.

Зургаан настай хүүхдийг сургуульд сургах бэлтгэлийг хангах хүрээнд 2008-2010 онд зохион байгуулсан гурван удаагийн сургалтад зориулан “Зургаан настай хүүхдийн сурах, сургах арга зүй” (2008), “Зургаан настай суралцагч” (2009), “Сурлагын амжилтын үнэлгээ” (2010) гэсэн нийт 57 хэвлэлийн хуудас бүхий багшид зориулсан гарын авлага бэлтгэн, 15000 ширхэг хэвлэж, хичээл заах багш, сургалтын менежер, БСГ-ын арга зүйч, багш бэлтгэдэг их дээд сургуулийн багш, оюутанд хуваарилж түгээсэн болно.

Зургаан настныг сургуульд сургах бэлтгэлийг хангах зорилгоор гурван жил дараалан зохион байгуулсан сургалтад нийт 750 сая төгрөг зарцуулсан бөгөөд нэг хүнд дундажаар 108 мянган төгрөг зарцуулагджээ.

2011-2012 онд 1 дүгээр ангид хичээл заах багш нар сургалтын агуулгыг өмнөх жилүүдийн сургалтын 5 өдрийн агуулгыг гурван 3 өдөрт багтаан интеграцчилсан ажээ. Сургалтыг Боловсролын хүрээлэн хариуцаж, өмнөх жилүүдийн сургалтад хамрагдсан багш нарыг төвлөрсөн сургалтаар орон нутгийн сургагч багшаар бэлтгэж, 27 бүсэд сургалт зохион байгуулжээ. Сургалтад нийт 1703 багш хамрагдсан бөгөөд сургалтын зардалд 78,9 сая төгрөг зарцуулж, АХБ-ны “Санхүүгийн хямралын үед нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд боловсролын үйлчилгээ хүргэх” төслөөс санхүүжүүлсэн байна.

2012-2013 онд 1 дүгээр ангид өмнөх жилүүдэд сургагч багшаар ажилласан хүний нөөцөө ашиглан бүх аймаг, нийслэлийн 6 дүүрэгт орон нутгийн БСГ, боловсролын хэлтэс зохион байгуулжээ. Сургалтад нийт 1761 багш хамрагдсан бөгөөд энэ сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, нийт 84 орчим сая төгрөг зарцуулсан байна.

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн *READ* төсөл нь ЕБС-ийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх, ялангуяа бага боловсролын чанарыг дээшлүүлэхэд бага ангийн багш нарт шинэ арга зүйг эзэмшүүлэх, сурагчдыг сургалтын хэрэглэгдэхүүн, номоор хангах, сурагчдын бүтээлч чадварыг хөгжүүлэх, эцэг

ДБ-ны READ
төсөл

²⁷ БСШУЯ-ны 2008, 2009, 2010 оны үйл ажиллагааны тайлан

эх, олон нийтийн оролцоог хангах, гэгээрүүлэх, дижитал уншлагын орчин бүрдүүлж, арга зүйг нэвтрүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой цогц үйл ажиллагааг агуулсан байв.

Төслийн хүрээнд Улаанбаатар хот, аймгийн төвөөс бусад бүх сум, багийн 383 сургуулийн бага ангийн 3870 бүлэгт ангийн номын сан нийлүүлсэн бөгөөд ангийн номын санд зориулан 600000 ширхэг ном хэвлэн анги бүлгээр багцлан сургуулиудад хүргүүлсэн байна. Ангийн номын санг ашиглах арга зүйд сургах багш нарт зориулсан “Сурагчдад бүтээлчээр унших, сонсох, бичих чадвар эзэмшүүлэх арга зүй”-н цуврал сургалтыг олон улсын тендерт шалгарсан Монголын БХАН хариуцан зохион байгуулжээ.

2007 оны 3 дугаар сараас 2008 оны 10 сарын хооронд сургагч багш нарыг бэлтгэх туршилт (Архангай, Булган, Төв, Сүхбаатар, Завхан аймаг)-ын болон түгээн дэлгэрүүлэх сүлжээний I шат (Дорноговь, Өмнөговь, Хэнтий, Увс, Ховд, Хөвсгөл, Өмнөговь аймаг)-ны сургалтыг дуусгаж, II шат (Баян-Өлгий, Говь-Алтай, Өвөрхангай, Баянхонгор, Дундговь, Сэлэнгэ, Дорнод, Дархан-Уул)-ны сургалтыг зохион байгуулсан юм. Туршилтын сургалтаар 5 аймгийн 159 сургуулийн 1384 ментор багш бэлтгэгдэж, сүлжээний сургалтын I, II шатны сургалтад нийт 160 сургуулийн 2053 бага ангийн багш хамрагдсан байна. Эдгээр сургалтад Дэлхийн банкнаас нийт 257.9 сая төгрөг зарцуулжээ.

Бага ангийн багш нарын суурь чадварыг дэмжих сургалтууд

“Бага боловсролын чанарыг дээшлүүлэх” төслийн хүрээнд хөдөөгийн сургуулийн бүх ЗАН-д нийлүүлсэн зөөврийн компьютер, LCD проектор, телевизор, дэлгэц зэргээс бүрдсэн тоног төхөөрөмжийг сургалтад хэрэглэх чадвартай болгох, математикийн заах аргыг сайжруулах зорилгоор бие даан суралцах хоёр гарын авлага боловсруулан нийт 2260 хувийг хэвлэж сургууль, багш нарт түгээсэн байна. Бие даан суралцах гарын авлагыг нийт багш нараар ашиглуулахын тулд математикийн арга зүйн чиглэлээр бага ангийн нийт 1100 багш, мэдээлэл харилцааны технологи ашиглах зорилгоор 1100, нийт 2200 багшийг 5 хоногийн сургалтад хамруулж, нийт 190540 ам доллар зарцуулжээ. Дээрх тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт болон сургалтын үр дүнд багш бие дааж суралцах гарын авлага ашиглан мэдээлэл харилцааны шинэ технологид суралцах, түүнийгээ сургалтдаа хэрэглэхэд нь бодит дэмжлэг үзүүлсэн цогц арга хэмжээ болсон юм. Энэ үйл ажиллагаанд 250 орчим сая төгрөг зарцуулжээ.

МХТ-ийн анхан шатны сургалтад 2008 онд ЕБС-ийн бүх бага ангийн багш нарыг хамруулж, бие даан суралцах гарын авлагаар хангасан бол 2009 онд тэдэнд зориулсан МХТ-ийн ахисан түвшний боловсрол олгох сургалтыг “Үр дүнд түргэн хүрэх түншлэлийн санаачилга” төслийн хүрээнд дотоодод зарласан зөвлөх үйлчилгээний тендерээс “Интек” ХХК шалгарч үндэсний хэмжээнд дөрвөн шаттайгаар зохион байгуулжээ.

1-р шат: Үндэсний сургагч багш бэлтгэх сургалт (21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн БСГ-ын мэдээлэл зүй, бага ангийн 61 мэргэжилтэн Улаанбаатарт)

2-р шат: Аймаг, дүүргийн сургагч багш бэлтгэх бүсчилсэн сургалт (10 бүсэд зохион байгуулж, аймаг, нийслэлийн дүүрэг тус бүрээс 6, нийт 182 хүн)

3-р шат: Сургуулийн сургагч багш бэлтгэх сургалт (21 аймгийн төв, нийслэл хотын 8 дүүрэгт зохион байгуулж, сургалтад 594 сургуулиас тус бүр 3 багш буюу нийт 1872 багш)

4-р шат: Бага ангийн бүх багш нарыг хамарсан сургалт (нийт 594 сургуулийн бүх бага ангийн багш нар)

Энэхүү сургалтын зардалд 199,471,4 ам.доллар зарцуулж, ДБ-ны Каталик сангаас санхүүжүүлсэн байна.

Шилжилт хийгдэж буй ангийн багш нарын сургалт

ЕБС-ийн тогтолцоог 12 жилд үе шаттайгаар шилжүүлэх нь нарийн нийлмэл үйл явц бөгөөд бага ангийн багш нараас гадна бүх мэргэжлийн нийт багшийн арга зүйн хөгжилд анхаарал хандуулах зайлшгүй хэрэгцээ бий болгосон. 2007-2008 оны хичээлийн жилээс эхлэн жил бүр 2 ангийн бүх хичээлийн сургалтын үндэсний хөтөлбөр, тэдгээрийг хэрэгжүүлэх зөвлөмжийн хамт боловсруулан сургууль бүрд хүргэж байна.

Үндэсний хөтөлбөрүүдэд бүтэц, дизайны үндсэн бүрэлдэхүүн бүрд тухайн бүлгээр эзэмших мэдлэг, чадварыг суралцагчдад эзэмшүүлэх ерөнхий арга зүйн хамт тодорхойлж, нарийвчилсан тусгай аргуудыг зөвлөмжилсөн. Ийнхүү цогц чадамжид суурилсан боловсролын стандартад тодорхойлсон сургалтын арга зүйн үндсэн зарчмууд нь анги болгоны хичээл бүрийн үндэсний хөтөлбөрийн

бүлэг тус бүрийн арга зүйгээр биежин хэлбэржиж, зөвлөмжид өгөгдсөн онол арга зүйн зөвлөгөө, бүтээлч шинэ аргууд багшийн өөрийнх нь хур туршлагаар баяжин амилах боломж бүрдүүлсээр байгаа билээ.

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах хүрээнд жил бүрийн намар аймаг, нийслэлийн БСГ-ын мэргэжилтэн болон орон нутгийн сургагч багш нарыг бэлтгэж, шилжилт хийж буй ангид хичээл заах бүх багшийг хамруулсан орон нутгийн сургалтыг зохион байгуулж ирсэн. Өөрөөр хэлбэл, бүх сургуулийн багш бүр (томоохон цогцолбор сургуулиудаас бусад) жил бүр зааж буй хичээлээрээ орон нутгийн түвшинд шилжилтийн сургалтад хамрагдаж байна.

Англи хэлний сургалтын чанарыг сайжруулах, нийт багшийн англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх, сургалтын орчныг бүрдүүлэхэд зориулж 2008 онд улсын төсвөөс 1.6 тэрбум төгрөг зарцуулж, багш нарын англи хэлний боловсролын чанарыг дээшлүүлэх доор дурдсан 4 цогц арга хэмжээ бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. Уг хөтөлбөрийг зөвлөх үйлчилгээний олон улсын тендерт ялсан Монголын “Golden bridge” гадаад хэлний сургалтын компани гүйцэтгэжээ.

- Англи хэлний сургалтыг эрчимжүүлэх төсөл хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх
- Англи хэлний сургалтын материал, хэрэглэгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх
- Англи хэлний багш нарын мэргэшлийг дээшлүүлэхэд олон улсын жишиг, шаардлагад нийцсэн, дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлэх
- Багш нарын мэдлэг чадварыг системтэйгээр дээшлүүлэх, мэргэжлийн ур чадварыг нь олон улсын жишигт нийцсэн сертификатаар хэмжээсжүүлэх

Англи хэлний сургалтыг сайжруулах 7 төсөл орон даяар хэрэгжсэн байна. Энэ арга хэмжээний хүрээнд 3000 багш интернетээр мэргэжлээ дээшлүүлж, 2100 багш орчин үеийн сургалтын материалтай болж, 360 багш олон улсын сертификат авчээ.

Монгол Улс сургалтын үндэсний хөтөлбөр боловсруулахдаа ТХБ-ын үзэл санаа, агуулга, арга зүйд суурилсан байх стратеги баримталдаг бөгөөд энэ стратегийг хэрэгжүүлэхэд ШХА-ийн “Цөлжилтийг сааруулах нь” хөтөлбөр томоохон хувь нэмэр оруулсан бөгөөд 2007-2009 онд үндэсний хөтөлбөр боловсруулагчдад зориулсан олон цуврал сургалт явуулж, хэд хэдэн гарын авлагууд боловсруулан багш нарт түгээсэн ажээ.

Энэ ажиллагааг дэмжиж тогтвортой хөгжлийн үзэл санаа, агуулга, арга зүйд суурилсан үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх багш нарт ТХБ-ын ач холбогдолыг ойлгуулах, түүнийг эзэмшин, сургалтын арга зүйг бүтээлчээр хэрэглэхэд нь зориулж ГХАН нь “Байгаль орчны мэдээлэл сурталчилгаа” ТББ-тай хамтран “Багш нарын тогтвортой хөгжлийн боловсрол”-ыг дээшлүүлэх “Тогтвортой хөгжлийн боловсрол”, “Систем сэтгэлгээний арга зүй”, “Золиосгүй ёс суртахууны зарчмууд”, “Удирдлагын түвшин хоорондын үйл ажиллагааны менежмент” гэсэн дөрвөн модуль бүхий сургалтын хөтөлбөр боловсруулан туршиж, хэвлэн түгээсэн явдал нь багш нарт жижиглэсэн “ээлжит” бус, дидактик нэгжийг томсгосон “нэгж” хичээлд суурилсан сургалтын төлөвлөлт хийх, хөтөлбөр боловсруулах, арга зүйгээ шинэчлэх онол, арга зүйн үндсийг тодруулж өгсөн чухал ач холбогдолтой дэмжлэг болсон юм.

ТХБ болон байгаль орчны боловсролыг дэмжиж, цаг уурын өөрчлөлт, байгаль хамгаалах үйл ажиллагаанд багш, суралцагчдыг татан оролцуулах зорилготой төсөл хөтөлбөрийг олон улсын болон хөгжилтэй орны Засгийн газрын хөгжлийг дэмжигч байгууллагууд БСШУЯ-тай хамтран хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал, ШХА-ын дэмжлэгтэй “Экосургууль”, ДБХС-ын дэмжлэгтэй “Ногоон сургууль”, Азийн сангийн дэмжлэгтэй “Голын ус болон хөрсний чанарын үнэлгээ” гэсэн төслүүд нь тус тусын загвар аймгийн сургуулийн багш сурагчдад орон нутгийнхаа байгаль орчны тулгамдсан асуудлыг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэйгээ хамтран шийдвэрлэхэд манлайлан оролцох мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсаар байна. Эдгээр төслийн хүрээнд анги танхимд эзэмшсэн мэдлэгээ асуудал шийдвэрлэх үйл ажиллагаандаа хэрэглэж сургах арга зүйг багш нарт зөвлөдөг юм. Эдгээр төслийн хүрээнд боловсрогдсон арга зүйн чиглэлийн 10 гаруй номыг багцлан бүх сургуульд түгээсэн нь ТХБ болон БОБ-ын чиглэлээр багш нар арга зүйгээ шинэчлэн сайжруулах тэгш боломж бүрдүүлсэн байна.

Англи хэлний багш нарын сургалт

Багш нарын тогтвортой хөгжлийн болон байгаль орчны боловсролыг дээшлүүлэх сургалтууд

Мэргэжил
дээшлүүлэх
үндсэн сургалт

Үндсэн сургалтыг эхлүүлэхийн тулд юуны өмнө 2010-2012 оны хэрэгцээний судалгааг аймаг, нийслэлээс авч дуусган ойрын гурван жилийн сургалтын төлөвлөлт, зураглал хийх, сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалтыг зохион байгуулах бэлтгэл ажил хангасан байна. Журамд зааснаар эхний жилдээ болон таван жил ажилласан багш нарт зориулсан үндсэн сургалтыг эхлүүлэх стратеги баримталсан. Энэ стратеги нь 2009-2010 оны хичээлийн жилийн байдлаар сургуульд ажиллаж байгаа нийт багшийн гуравны нэг гаруй нь эхний 5, 6 жил ажилласан багш нар эзэлж байсан тул тэдэнд цогц чадамжид суурилсан боловсролын стандарт, ТХБ-ын үзэл санаа, агуулга, арга зүйд суурилсан үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн талын мэдлэг сул, туршлага багатай байгааг харгалзан тэд ажлын байрандаа хөгжихөд зайлшгүй шаардлагатай суурь дэвсгэрийг тавих бодлогын тусгал байсан юм.

“Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-ын холбогдох заалтын дагуу эхний удаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд таван жил ажилласан багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын 2010 онд хөтөлбөрийг агуулгын 8 чиглэлээр шалгаруулан сайжруулж, “Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ”-ний дагуу Боловсролын хүрээлэн хариуцан гүйцэтгэсэн байна. Улаанбаатар, Ховд, Завхан гэсэн 3 бүсэд зохион байгуулсан 7 хоногийн хугацаатай эдгээр сургалтад нийт 847 багш хамрагдаж, улсын төсвөөс 202,0 сая төгрөг зарцуулсан байна.

2011 оны үндсэн сургалтыг сургалтын хөтөлбөрийг сайжруулж, 2010 оны менежментээр зохион байгуулсан бөгөөд нийт 9 удаагийн 41 сургалтад цэцэрлэгийн 205, ерөнхий боловсролын сургуулийн 1242, нийт 1447 багш хамрагдаж, улсын төсвөөс 320.5 сая төгрөг зарцуулжээ. Харин 2012 онд ямар ч үндсэн сургалт зохион байгуулагдаагүйг тэмдэглэх нь зүйтэй.

ЕБС-д таван жил ажилласан багш нарын үндсэн сургалтыг хоёр жил дараалан зохион байгуулах явцад, багш бүр ажиллах хугацаандаа 3-аас доошгүй удаа улсын төсвийн зардлаар мэргэжил дээшлүүлж байх үндсэн сургалтын менежмент тухайлбал, оролцогчдын судалгааны прогноз гаргах, зардал төсвөө төлөвлөн батлуулах, сургалтын хөтөлбөр боловсруулах, сургагч багш бэлтгэх, сургалт зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргах зэрэг цогц үйл ажиллагааны менежментийн суурь тавигдсан нь боловсролын түүхэнд тэмдэглэгдэн үлдэх үйл явдлын нэг юм.

Цаашид мэргэжил дээшлүүлэх институтчилэгдсэн тогтолцоог улам бэхжүүлэх нь багшлах арга зүйн хөгжлийн тулгамдсан асуудал болоод байна. Багш нарын мэргэжил дээшлүүлэх институт нь зөвхөн эхний 5 жилийн сургалтын тасралтгүй, тогтвортой байдлыг хангах төдийгүй, 10, 15 жил ажилласан багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг эхлүүлэн үндсэн сургалтыг зохион байгуулах шинэ менежмент боловсруулан эдгээр сургалтын нийц, чанар, үр өгөөж, үр ашгийг эрс нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хангахад ихээхэн үүрэг гүйцэтгэх учиртай.

Мэргэжил
дээшлүүлэх
төрөлжсөн
сургалт

“Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-д заасан сургууль, багш нарын тусгай хэрэгцээнд буюу тэдний эрэлтэд суурилсан кредит олгох төрөлжсөн сургалтууд 2008-2012 онд тасралтгүй зохион байгуулагдаж байна.

Энэ төрлийн мэргэжил дээшлүүлэх сургалт нь үйлчлүүлэгчийн тусгай хэрэгцээнд баримжаалсан, үйлчлэгч талуудыг сонирхол, оролцоонд тулгуурласан үйлчилгээний зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн нээлттэй байх зарчим, чанарын төлөөх шударга өрсөлдөөний зарчмыг тус тус боловсролын үйлчилгээнд нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлэх зориулалттай байна. Сургалтын чанар, үр өгөөжийн баталгааг хангах үндсэн нөхцөлийн нэг болгон кредит олгох төрөлжсөн сургалтын хөтөлбөрт БСШУЯ-аас томилогдсон экспертийн баг магадлан шинжилгээ хийж, түүнд үндэслэн БСШУ-ны сайдын зөвшөөрлөөр сургалт явуулах эрхийг нээж, сертификатын олголтод бүх нийтгээрээ хяналт тавих боломж олгон нийтэд мэдээлэгддэг байна. (Хүснэгт 3.2.)

Хүснэгт 3.2. Кредиттэй төрөлжсөн сургалтын хөтөлбөрт магадлан шинжилгээ хийсэн дүн

Он	Хөтөлбөр ирүүлсэн байгууллагын тоо	Ирүүлсэн хөтөлбөрийн тоо	Зөвшөөрөгдсөн хөтөлбөрийн тоо	Сайдын тушаалын огноо, дугаар
2009	25	175	83	2009 оны 179
2010	32	177	86	2010 оны 244
2011	30	211	66	2011 оны 262
2012	45	180	106	2012 оны 320

Энэ төрлийн сургалтын зардал нь төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, сургуулийн үйл ажиллагааны орлого болон оролцогчдын сургалтын төлбөрөөс тус тус бүрддэг байна.

Боловсролын чанарыг олон улсын жишигт хүргэж, хүлээн зөвшөөрүүлэх зорилтын хүрээнд 2009 оноос эхлэн БСШУЯ-аас Олон улсын Кембрижийн стандарт, хөтөлбөрийг Монголын нөхцөлд тохируулан хэрэгжүүлэх боломж нөхцөлийг туршин тогтоох ажил эхэлж, 2011 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр “Монгол Улсын Засгийн газар болон Кембрижийн их сургуулийн Олон улсын шалгалтын төвийн хооронд бага, дунд боловсролын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх талаар хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулагдсан байна.

Энэхүү олон улсын хөтөлбөр нь дараах хэд хэдэн онцлог, давуу талтай байна.

- *Зарчим:* Тусгай арга зүйгээр боловсруулсан чанартай хөтөлбөрийг хэрэгжүүлж, нарийвчлан боловсруулагдсан үнэлгээгээр дамжуулан суралцагчдыг бэрхшээлийг даван туулах, урамшин хөгжих боломжоор хангах зарчмыг хэрэгжүүлдэг.
- *Уян хатан байдал:* Тухайн суралцагч өөрийн ирээдүйн хэрэгцээнд үндэслэн олон хувилбараас сонгох уян хатан сонголттой.
- *Үе шат:* Бага анги (CIPP, 5-11 нас), дунд анги (CLSP, IGCSE, 11-14 нас ба 14-16 нас), ахлах анги (AS Level, A-Levels, 16-19 нас) гэсэн ерөнхий боловсролын боловсролын түвшнийг хамарсан дөрвөн шатлалтай ба суралцагч аль ч шатны хөтөлбөрийг сонгон хичээллэх боломжтой байдаг.
- *Чанар:* Төгсөгчдийг нь дэлхийн тэргүүлэх их дээд сургуулиуд шууд элсүүлдэг тул энэхүү хөтөлбөрийн чанар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөний баталгаа болдог.
- *Бэлтгэгдэх байдал:* Энэхүү хөтөлбөрөөр хичээллэснээр суралцагч дээд боловсрол, мэргэжил эзэмшихэд бэлтгэгдээд зогсохгүй амьдралд тохиолдох аливаа асуудлыг шийдвэрлэх, ойлгох, шинжлэх, сэтгэн бодох чадвартай болж амьдралд бэлтгэгддэг.

Олон улсын Кембрижийн хөтөлбөрийг шууд хэрэгжүүлдэг, хос хэлний сургалттай гурван сургууль Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж байна. Мөн математик, байгалийн ухаан (физик, хими, биологи), англи хэлний хичээлийн хөтөлбөрийг олон улсад нийцүүлэн боловсруулах мэргэжлийн баг байгуулан ажиллуулж байна. Энэ баг 1-10 дугаар ангид үзэх дээрх хичээлийн хөтөлбөрийг 2011-2012 онд боловсруулж батлуулсан байна. Боловсруулсан хөтөлбөрийг туршин хэрэгжүүлэх зорилгоор аймгийн төвд тус бүр 1, Улаанбаатар хотод 10, нийт 31 үндэсний хэмжээний лаборатори сургуулийг сонгон ажиллуулж байна. Эдгээр сургуульд хөтөлбөрийг сорих анхны туршилтыг 2012 оны 4-6 дугаар сард, явуулсан бол 2012-2013 оны хичээлийн жилийн туршид хөтөлбөрийн туршилт хийгдэх бөгөөд тэдгээрт 2529 багш оролцож байна. Эдгээр сургууль нь олон улсын Кембрижийн хөтөлбөрт нийцүүлэн боловсруулсан хөтөлбөрийг турших, тухайн бүс нутагт шинэ хөтөлбөрийн арга зүйг түгээн дэлгэрүүлэх, багшийн мэргэжил дээшлүүлэх төвийн үүрэг бүхий, боловсролын шинэчлэлийг манлайлан хэрэгжүүлэх түшиц сургууль юм.

Түшиц сургуулиуд боловсролын бүх шатны байгууллага, хүмүүсийг (i) бага, дунд боловсролын шинэчлэлийн бодлого, түүний хэрэгжилт, (ii) шинэчилсэн сургалтын хөтөлбөр, (iii) шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий арга зүй, (iv) шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэргэжлийн арга зүйд сургах үүрэгтэй.

4.Кембрижийн сургалтын хөтөлбөрийг судлах, турших үеийн арга зүй (2010-2017)

3.2. Багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх менежментийн загварууд

Багш нарын арга зүйг шинэчлэх менежментийн загварууд


Боловсролын зэрэгцсэн, цогц шинэчлэлийн гол гол стратегийг шалгуур болгон үечилж, багшлах үйлийн арга зүйн шинэчлэлийг танилцуулсан тус гарын авлагын энэхүү бүлгийн эхний хэсэгт ДАНИДА, ЮНИСЕФ, МННХ, АХБ, ШХА, ГХАН, АС-ийн санхүүжилтээр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд багш нарын арга зүйн шинэчлэлийг түгээн дэлгэрүүлэх менежмент олон төрөл хэлбэртэй байсныг товч дурьдан танилцууллаа. Тэдгээрийг харьцуулан авч судалснаар Монголын багш нарын багшлах арга зүйн шинэчлэл ямар менежменттэй байсныг тодруулж, туршлага сургамжийг ялгах танин мэдэхүйн төдийгүй, цаашид багшлахуйн арга зүйг хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоонд хэрхэн ашиглаж болохыг тогтоох практик ач холбогдолтой.

Багшлахуйн арга зүйн шинэчлэлийг түгээн дэлгэрүүлэх менежментэд ямар ямар загвар хэрэглэгдсэнийг тоймлон танилцуулж байна (Хүснэгт 3.4). Цаашид хичээлийн судалгааны арга зүйд суурилсан багшлах арга зүйн шинэчлэлийг түгээн дэлгэрүүлэхдээ өнгөрсөн хугацаанд хуримтлуулсан менежментийн туршлага, түүнд хэрэглэсэн загваруудыг оновчтой хослуулан хэрэглэх боломжтой (Зураг 3.4). Учир нь эдгээр загвар нь Монгол Улсын ЕБС-ийн зураглал буюу байршил, хэмжээ, бүтэц, хэв шинж болон засаг захиргааны нэгжийн удирдлагын бүтцэд нийцэж туршигдсан юм.


Хүснэгт 3.3. Зарим төслийн хүрээнд багшлах арга зүйн шинэчлэлийг түгээн дэлгэрүүлсэн менежмент

Санхүүжүүлэгч	Зохион байгуулагч	Төслийн нэр	Сургалтын шатлал			Сургалтын хамрах хүрээ	Зорилго бүлэг	Сургагч багш	Сургалтын хугацаа	Сургалтын үндсэн хэлбэр	Түгээн дэлгэрүүлэхдээ хэрэглэсэн загвар
			Үндэсний төвлөрсөн	Бүс, орон нутгийн	Сургуулийн						
МННХ	Төслийн багууд	Сургууль-2001				Сонгогдсон загвар аймаг, сургууль	БСТ болон сургуулийн бүх удирдлага, багш	Гадаадын зөвлөхүүд, орон нутгийн сургагчид	5 өдөр	Хийж, суралцах буюу "Workshop"	"Цасан бөмбөлөг" (Snowball)
АХБ	ГЯ	6 сургалт				Бүх аймаг, дүүргийн БСТ, сургуулиуд	Бүх арга зүйч, бүх сургуулийн нийт багш	Зөвхөн дотоодын зөвлөхүүд, сургагчид	5-аас 21 (55) өдөр	Хийж, суралцах буюу "Workshop" Сертификатын ажил	"Дараалан цуварсан" (Cascade), "Дүүжин" (Pendulum)
ДБ	ГЯ БХАН	Бага боловсрол, Хөдөөгийн боловсрол				Бүх аймаг, дүүргийн БСТ, сургуулиуд	Бага ангийн бүх арга зүйч, бүх сургуулийн бага ангийн багш	Дотоодын зөвлөхүүд, сургагчид, зарим тохиолдолд Гадаадын зөвлөхүүд	3-5 өдөр	Хийж, суралцах буюу "Workshop" ангийн номын сан байгуулах, ашиглах, интернэт, вейбсайт ашиглах	"Зөвлөх чиглүүлэх бүтцээр" (Mentor based)


Цасан бөмбөлөг (Snowball) загвар



Дүүжин (Pendulum) загвар



Дараалан цуварсан (cascade) загвар А



Дараалан цуварсан (cascade) загвар Б



3.3. Хичээлийн судалгаанд суурилсан арга зүйг хөгжүүлэх төслийн менежмент

Хөгжлийн шаардлагаар урган гарсан багшлах шинэ арга зүйг ямар менежментээр хэрхэн түгээн дэлгэрүүлж, ямар үр дүнд хүрсэн болон багшлах арга зүйн хөгжлийг дэмжихэд Монгол Улсад хэрэгжсэн боловсролын олон төсөл хөтөлбөрүүд ямар хувь нэмэр оруулсан талаар дээр тодорхой дурдлаа.

Энд тусгайлан авч үзэх ёстой төслийн нэг нь БСШУЯ, Японы ЖАЙКА байгууллагатай хамтран Японы Засгийн газрын буцалтгүй тусламжийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн 2007-2009 онд “Суралцагчдын суралцахуйг дэмжсэн арга зүйн хөгжил”, 2010-2012 онд “Багшлах шинэ арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” гэсэн нэртэй, хоёр шаттай төсөл юм. Энэ төсөл нь “Хичээлийн судалгаа” хэмээх сургалтын арга зүйн хөгжлийн асуудлаар Японд төдийгүй олон улсад анхаарал татаж байгаа шинэлэг үзэл санааг түгээн дэлгэрүүлж, хэрэгжүүлэхэд чиглэсэн юм.

Монгол Улсын ЕБС 2005-2006 оны хичээлийн жилээс эхлэн цогц чадамжид суурилсан боловсролын шинэ стандартыг мөрдөж, 2007-2008 оны хичээлийн жилээс 12 жилийн сургалтад шилжин сургалтын үндэсний шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн билээ. Боловсролын эдгээр шинэ зорилтыг *бодит цйл хэрэг болгоход* суралцагчдын суралцах арга, багшийн багшлах арга зүйд томоохон өөрчлөлт хийж, олон төсөл хөтөлбөрийн хүрээнд танилцаж, эзэмшсэн идэвхтэй сургалтын аргуудаа анги танхимд явагдах хичээлдээ бүтээлчээр хэрэглэх, багш, сурагчдын хэн хэнд нь бодит үр өгөөжөө өгч, сургалтын технологид дэвшил гаргаж чадахаар багшлах үйлийн шинэ менежмент бий болгох шаардлага гарсан юм. Оюуны үйлдвэрлэл болох сургуулийн анги танхим дахь суралцах болон багшлах үйлийн арга зүйн шинэчлэлийг дэмжих шинэ менежментийг бүтээх зорилгоор Монгол Улсын БСШУЯ нь Японы ЖАЙКА байгууллагатай хамтран дээр дурдсан хоёр шаттай 6 жилийн төслийг хэрэгжүүлээд дуусч байна.

Нэг талаас, Япондоо олон жилийн өв түүхтэй, өнөөдөр Японд төдийгүй олон улсад багшийг ажлын байранд нь тасралтгүй хөгжүүлэх шилдэг арга механизм болон хурдацтай хөгжиж байгаа “Хичээлийн судалгаа”-нд суурилсан багшлах үйлийн хөгжлийн чимхлүүр, нягт нямбай менежмент нөгөө талаас, Монгол Улсад мөрдөж буй эрх зүйн актуудаар баталгаажсан багшийн ажлын шинэ агуулга, бүтэц, нэгж, ажлын байрны тодорхойлолт, ажлын төлөвлөлт, үнэлгээ, дүгнэлт, цалин хөлс урамшууллын тогтолцооны харилцан зохицолдоо нийцэл нь дээрх төслийн хүрээнд багшлах үйлийн *нэгдсэн шинэ арга зүйг* боловсруулан хөгжүүлэх таатай боломжийг олгож байгаа юм.

Төслийн эхний шат

Эхний төсөлд МУИС, МУБИС-ийн сургалт, судалгааны дөрвөн төвийн 70 орчим судлаач (профессор, доктор, магиструуд) тодорхой сэдвийн ээлжит болон нэгж хичээлийн жишээн дээр хичээлийн судалгаа хийх арга зүйг боловсруулж, Токиогийн Гакугэй багшийн их сургуулийн 10 гаруй профессор багш нар зөвлөн тусалж, Улаанбаатар Дорнод, Сэлэнгэ аймгийн 9 сургуулийн багш хамтран туршиж сайжруулсан (Хавсралт).

Төсөл хэрэгжих гурван жилийн хугацаанд Япон Улсаас зөвлөхөөр ажилласан Гакугей их сургуулийн 5 профессор багш, төслийн менежер, зохицуулагч нийт 7 хүнд талархлын батламж, төслийн загвар 9 сургуулийн 123 туршигч багш нарт тэдний оролцоо, хувь нэмрээс хамааруулж, 3-8 кредит цагаар хэмжигдэх чадвар эзэмшсэнийг гэрчлэх батламж олгожээ.

Төсөл хэрэгжих гурван жилийн хугацаанд арга зүйн чиглэлээр багш нарт зориулсан нийт 400 хэвлэлийн хуудас бүхий 27 зөвлөмж ном, 8 VCD-ийг бэлтгэн гаргаж, хот, хөдөөгийн бүх сургууль, багш нар эдгээр арга зүйн зөвлөмжийг судлан хичээлдээ туршихад зориулан 32400 ширхэг хэвлэж, Монголын бүх сургуульд төдийгүй холбогдох байгууллагуудад хүргүүлсэн билээ. Зөвлөмж боловсруулахад 330,4 сая төгрөг улсын төсвөөс зарцуулжээ.

Төслийн явцад багш нар хамтран сургалтын хөтөлбөр боловсруулж хичээлдээ бэлтгэх, хичээлд ажиглалт хийх, ажиглалтынхаа үр дүнг хэлэлцэж, сургалтын хөтөлбөрөө боловсронгуй болгон сайжруулах, хичээлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шинэ арга зүй, менежментэд суралцсан явдал төслийн үр дүнг тодорхойлох чанарын чухал үзүүлэлт юм.

2008 оны 5 дугаар сард улсын төсвийн эх үүсвэргүй алдагдлыг нөхөхөд зориулж АХБ, Япон Улсын Засгийн газраас олгож буй зээлийн хэлэлцээрийн “Нийгмийн салбарыг дэмжих хөтөлбөр”-т боловсролын салбарт дээрх төслийн үр дүнтэй

холбогдуулан дараах гурван нөхцөл тавигдсан байна. Үүнд:

- Төслийн үр дүнгийн нэг болох багшид зориулсан арга зүйн 27 зөвлөмжийг мэргэжлийн бүх багшид хүрэлцэхээр дахин хэвлэж түгээх
 - Сургалтын шинэ арга зүйг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулсан байх
 - Багшийн ажлын үнэлгээний шинэ тогтолцоо бий болгож, баталгаажуулах
- Төслийн үр дүнг түгээн дэлгэрүүлэх зорилтын хүрээнд тавигдсан дээрх нөхцөлийг Монголын засгийн газар амжилттай хэрэгжүүлсэн юм. Төслийн үр дүнг нийтийн хүртээл болгох, хичээлийн судалгааны менежментийг сургалтын технологийг шинэчлэх шинэ горим болгон бэлтгэж, “хичээлийн шинэ соёл” болгон төлөвшүүлэх, багшийн тогтвортой хөгжлийн хангах үндсэн арга хэрэгсэл болгон хөгжүүлэхэд БСШУЯ-аас онцгой анхаарал тавьсан ажээ. Тухайлбал,
- Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгийн санхүүжилтээр ерөнхий боловсролын сургуулийн болон багш бэлтгэдэг сургуулийн багш нарт зориулсан 8 төрлийн хичээл, “Хичээлд мониторинг хийх зөвлөмж”, “Зөвлөмж боловсруулах гарын авлага” зэрэг 27 нэр төрлийн 387 хэвлэлийн хуудас бүхий 96130 ширхэг номыг дахин хэвлэж, аймгийн Боловсрол соёлын газар, дүүргийн Боловсролын хэлтсээр дамжуулан бүх сургууль, мэргэжлийн бүх багшид хүргэх ажлыг зохион байгуулсан бөгөөд бүх зөвлөмжийг VCD болгон бэлтгэж, 2009-2010 оны хичээлийн жил эхлэхээс өмнө төрийн болон төрийн бус өмчийн нийт сургуульд хүргүүлж, зөвлөмжүүдийг яамны болон холбогдох бусад вебсайтуудад байршуулсан. Энэхүү үйл ажиллагаанд Япон Улсын Засгийн газраас Монгол Улсад олгосон төслийн бус буцалтгүй тусламжийн эх үүсвэрийн хөрөнгөөс 156,6 сая төгрөгийг зарцуулжээ.
 - БСШУ-ны сайдын 2009 оны 555 дугаар тушаалаар “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах болон бусад мэргэжлийн ажилтны ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр 2009-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” батлан гаргаж хэрэгжүүлсэн байна.
 - БСШУ-ны сайдын 2007 оны 416 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг төлөвлөж, үнэлэх түр аргачлал”-д үнэлгээ өгөх үндсэн дээр түр аргачлалыг Сайдын 2009 оны 561-тоот тушаалаар нийтээр мөрдөх чиглэл болгон баталж, нийтээр мөрдүүлж байна.
 - Суралцагчдын суралцахуйг дэмжсэн шинэ арга зүй бүтээхийн тулд төслийн хүрээнд Монголын нийт 16 судлаач 2006, 2007 онд хоёр удаа Япон улсад тус бүр 6 долоо хоногоор мэргэжил дээшлүүлэн суралцахуйг дэмжсэн арга зүйн судалгаа хийж, туршлага судалсан болно. Мөн Токиогийн Гакугэйнбагшийн их сургуулийн профессорууд жилд 3-4 удаа 7-14 хоногийн хугацаагаар Монголд ирж, зөвлөмж боловсруулж, туршилт явуулахад зөвлөгөө өгч ажилласан байна.


Төслийн эхний шатны зорилго нь их сургуулийн судлаачдын боловсруулсан хичээлийн судалгааны арга зүйн төлөвлөлтийг загвар сургуулиудад туршиж сайжруулах замаар мэдлэг бүтээлгэх шинэ арга зүй бүтээхэд оршиж байсан тул уг төсөл Зураг 3.5-д үзүүлсэн менежментээр хэрэгжжээ.

БСШУЯ нь ЖАЙКА-тай хамтран дээрх төслийн үргэлжлэл болгож, “Багшийн хөгжлийн арга зүйг түгээн дэлгэрцүлэх тогтолцоог бэхжүүлэх” нэртэй хоёр дахь шатны төсөл 2010 оноос хэрэгжиж эхэлсэн ба энэ төсөлд Завхан, Булган аймаг, нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нийт 14 сургууль (Хавсралт) загвар аймаг, сургуулиар сонгогдож “Хичээлийн судалгаа” хийх замаар багшлах арга зүйгээ хөгжүүлэх менежментийг өөрийн аймаг, дүүргийн төдийгүй загвар бус аймгийн сургуулиудад түгээн дэлгэрүүлэх ажиллагааг хэрэгжүүлж байна.

Хоёр дахь шатны төслийн гол зорилго нь их, дээд болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарын хамтран боловсруулсан олон шинэ арга зүйг ажиллаж байгаа багш нарт болон багшийн мэргэжлээр суралцаж байгаа оюутанд эзэмшүүлэх сургалтын шинэ модулуудыг боловсруулж, үндэсний хэмжээнд зохион байгуулах сургалтаар багш, менежерүүдийн ерөнхий болон тусгай дидактикийн мэдлэгийг гүнзгийрүүлэн тэдний арга зүйн ур чадварт нь бодитой дэмжлэг үзүүлж, Монголын боловсролын шинэчлэлийн цаашдын тогтвортой хөгжлийн нэгэн баталгааг хангахад оршиж байв.

Төслийн хоёр дахь шатанд сургалтын модуль-хөтөлбөр боловсруулах, үндэсний хэмжээнд явуулах сургалтуудын график төлөвлөгөө, дизайныг боловсруулах,


Төслийн хоёр дахь шат



Зураг 3.2. Төслийн нэг дэх шатны менежмент

сургалтын зардлыг тооцох, эх үүсвэрийг тодорхойлох, санхүүжүүлэх, сургагч багш бэлтгэх, төсөлд оролцогчдоос Япон, Индонез улсад зочилж туршлага судлах, Японы мэргэжилтнүүдийг Монголд урьж, туршлага солилцох, зөвлөгөө авах, төлөвлөгдсөн сургалтууд зохион байгуулах, орон нутагт явагдах сургалтуудад дэмжлэг үзүүлэх, төсөлд болон хичээлийн судалгаанд хяналт-шинжилгээ хийх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлжээ.

Төслийн хоёр дахь шат нь хичээлийн судалгаанд суурилсан багшлах арга зүйн шинэчлэлийг түгээн дэлгэрүүлэх зорилгоосоо хамаарч дараах менежментээр хэрэгжсэн (Зураг 3.6.).



Зураг 3.3. Төслийн 2 дахь шатны менежмент

Хоёр дахь шатны төслөөс дараах шууд үр дүн хүлээгдэж байна. Үүнд:

- Шинээр боловсруулсан болон боловсруулах 20 гаруй арга зүйг багш нарт эзэмшүүлэх зорилгоор тодорхой зорилтод бүлгүүдэд зориулагдсан үндэсний хэмжээнд зохион байгуулагдах сургалтад хэрэглэгдэх сургалтын дараах 12 бүтээгдэхүүн бүхий модулийн систем боловсрогдоно. Үүнд:
 - Хичээлийн судалгааны үндсэн модуль: (онол, арга зүйн ерөнхий асуудлууд)
 - Судлагдахууны баримжаатай сургалтын модулиуд: (Математик -бага, математик-дунд, хүн орчин, төсөлт ажил, хүн байгаль, мэдээлэл зүй, хими, физик)

- Менежментийн баримжаатай сургалтын модулиуд: (Удирдлагын менежмент, хичээлийн судалгааны хяналт-шинжилгээ)
- Оюутанд зориулсан 2 кредитийн сургалтын хөтөлбөр (Хичээлийн судалгаа)
- Гарын авлага (Багшлах арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцооны менежмент)
- Сургалтын модуль боловсруулах, сургалт зохион байгуулах явцад шинэ шинэ арга зүйг боловсруулсан их, дээд, дунд сургуулийн багш нар болон бусад багш нараас бүрдсэн үндэсний, орон нутгийн, сургуулийн түвшний сургагч багш нар бэлтгэгдэнэ.
- Ажлын байрандаа мэргэжил дээшлүүлэх сургалтын шинэ менежмент бий болно.
- Дийлэнх сургуульд хичээлийн судалгаа (Jyugyo Kenkyu), сургалтын хэрэглэгдэхүүний судалгаа (Keizo Kenkyu) хийх шинэ арга зүй нэвтэрнэ.
- Дийлэнх багш нар холбогдох модулийн сургалтад хамрагдсан байна.
- Сургуулийн сурагчид суралцах шинэ арга зүйд суралцана.

Хоёр дахь шатны төслийн 3 жилийн хугацаанд төслийн санхүүжилтээр хичээлийн судалгааны арга зүй, менежментийг газар дээр нь судлах зорилгоор тус бүр 14 хоногийн хугацаатай 4 удаагийн сургалтад нийт 71 багш, ажилтан мөн 14 хоногийн хугацаагаар Япон болон Индонез улсад 10 хүн тус тус туршлага судлах аялал-сургалтад хамрагдсан байна. Түүнчлэн ЖАЙКА-ийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар нь Сангийн яам, БСПУЯ-тай хамтран төслийн үндэсний багаас хүмүүсийг сонгон шалгаруулж, Японы Хирошима, Саппора хотод болсон сургалтад 6 хүнийг 21-45 хоногийн гүнзгийрүүлсэн сургалтад, загвар сургуулиудаас 15 залуу багшийг 14 хоногийн “Залуучуудын хөтөлбөрт” тус тус хамруулжээ. Гадаад улс орон дахь эдгээр сургалт нь уг төслийг амжилттай хэрэгжүүлэх, улмаар багшлах арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх хүний нөөцийг чадавхжуулахад чухал ач холбогдолтой арга хэмжээ болж, хичээлийн судалгааг Монголын хөрсөнд нутагшуулахад бодитой дэмжлэг болсон байна. Дашрамд тэмдэглэхэд Сингапур улсад зохион байгуулагдсан Хичээлийн судалгааны олон улсын нийгэмлэгийн 2012 оны олон улсын хурал²⁸-д анх удаа Монгол улсаас илтгэл тавьж оролцсон нь энэхүү төслийн дам үр дүнгийн нэгэн үзүүлэлт юм.

Япон улсад мэргэжил дээшлүүлсэн хүмүүс тухайн сургалтаас нэгдүгээрт, чухам юуг сурч мэдэж, хоёрдугаарт, цаашид хичээлийн судалгааг Монголд хөгжүүлэхэд үндэсний, орон нутгийн, сургуулийн түвшинд анхаарах шаардлагатай талаар тэдний санал бодлыг нэгтгэн танилцуулж байна. Энэ нь удирдлага, зохион байгуулалтын аль ч түвшинд хичээлийн судалгааг чанартай хийж, Монголд сургалтын менежментийн шинэ соёлыг бүтээхэд үнэ цэнэтэй мэдээлэл болно гэж үзэж байна.

Хичээлийн судалгааны чиглэлээр Япончуудаас суралцсан зүйл, Монголын боловсролд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Төслийн бүх шатанд нийт 14-42 хоногийн хугацаатай 6 удаагийн сургалтад хамрагдсан Монголын боловсролын холбогдох байгууллага, загвар сургуулийн 87 багш, ажилтан хичээлийн судалгааны арга зүй, менежмент чиглэлээр” аяны богц” арвинтай буцаж ирээд сурч мэдсэнээ өөрийн байгууллагадаа төдийгүй үндэсний, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхэд манлайлан оролцож байна.

Япон улсад мэргэжил дээшлүүлсэн хүмүүс тухайн сургалтаас нэгдүгээрт, чухам юуг сурч мэдсэн, хоёрдугаарт, цаашид хичээлийн судалгааг Монголд хөгжүүлэхэд юуг анхаарах шаардлагатайг үндэсний, орон нутгийн, сургуулийн гэсэн гурван түвшинд ялгаж, тэдний гаргасан санал бодлыг нэгтгэн танилцуулж байна. Энэ нь удирдлага, зохион байгуулалтын аль ч түвшинд хичээлийн судалгааг чанартай хийж, Монголд сургалтын менежментийн шинэ соёлыг бүтээхэд үнэ цэнэтэй мэдээлэл болно гэж найдаж байна.

Япон дахь сургалтын явцад сурч мэдсэн зүйл

Сургалтад оролцогчид хичээлийн судалгааны арга зүй ба менежментийн талаар юуг сурч мэдсэн болон Японы боловсролын байгууллага, сургуулиас суралцаж болох бусад зүйлс юу байгаа талаар тоймлон өгүүлье.

²⁸ Жил бүр олон улсын хурал зохион байгуулагддаг

Хичээлийн судалгааны арга зүй болон менежментийн чиглэлээр

- Хичээлийн судалгааны хүрээнд үндэсний түвшинд арга зүйн дараах чиглэлийн асуудалд анхаарал төвлөрүүлж байна. Үүнд:
 - Сурагчийн алдааны шинжилгээ, өмнөх төсөөллийн оношилгооны арга зүйг боловсруулан хэрэглэх
 - Хичээл дээр хүүхдэд эргэцүүлэн тунгааж бодох, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдыг сонсох цаг боломж олгохуйцаар хичээлийг төлөвлөх
 - Байгалийн ухааны хичээл дээр гарын дорх материалыг ашиглан сургалтын хэрэглэгдэхүүн хийж ашиглах
 - Хичээлийн судалгааны сэдвийг оновчтой, зөв сонгох
- Япон улсад багш нар судалгааны ажил хийхийг хуульчилсан байдаг тул энэхүү албан чиг үүргийн хүрээнд багш нар хичээлийн судалгааг тогтмол хийж, судалгааны болон багшлах арга зүйгээ тасралтгүй хөгжүүлэх шаардлагатай болсон байна.
- Сургууль бүр сурагч, эцэг эх, багш нарын саналыг тусгасан сургуулийн маш тодорхой зорилго, зорилттой ажилладаг. Өнөөдөр хичээлийн судалгаа нь энэ зорилго, зорилтоо хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл нэг болон хөгжиж байна.
- Сургуулиуд хичээлийн судалгааны гурваас доошгүй жилийн төлөвлөгөөтэй ажилладаг.
- Тухайн багшаас гаргасан саналыг хамтлаг, сургууль, орон нутаг болон үндэсний түвшинд хүртэл өргөжүүлэн хөгжлийн бодлогодоо тусгадаг.
- Батлуулсан төлөвлөгөөний дагуу үндэсний, орон нутгийн, бүс, сургуулийн түвшинд хичээлийн судалгааны өдөрлөг явуулж, хэлэлцүүлэг хийдэг.
- ЕБС-ийн багш болон их дээд сургуулийн профессорууд хамтран анги танхмын түвшинд хийсэн судалгаанд тулгуурлан боловсролын бодлого, стандартдаа өөрчлөлт оруулдаг.
- Үндэсний хэмжээнд хичээлийн судалгаа хийх зохицуулалт үйлчилдэг.
- Багш нарыг 5 жил тутамд шилжүүлэн ажиллуулдаг.
- Сургуулиудад багш нарын хичээлийн судалгааг хийх эрх зүй, сэтгэл зүй, арга зүйн болон материаллаг орчин нөхцөл бүрдүүлж чадсан байна.
- Багш бүр хичээлийн судалгаанд оролцдог ба түүнийг багшийн арга зүйгээ дээшлүүлэх үндсэн арга зам гэдгийг багш нар нь мэдэрч, хүлээн зөвшөөрч, бүтээлчээр ажиллах хандлага бий болсон байна.
- Мэргэжил дээшлүүлэх сургалтын үндэсний тогтолцоотой.
- Сургалтын хөтөлбөрүүд нь зорилтод бүлэг (багш, ажилтан) бүрийн эрхлэх ажлын чиг үүрэг, ажлын туршлага, тусгай хэрэгцээ, боловсролын шинэчлэлийн бодлогыг таниулах зэрэг төрөлжсөн агуулга, арга зүйтэй. Сургалтууд нь тодорхой хугацааны (3, 5, 10 жил гэх мэт) давтамжтай.
- Боловсролын стандартын 10 жил тутмын өөрчлөлтөд харгалзан сурах бичиг нь сайжирч байдаг журамтай. Тухайн сурах бичгээр хичээллэх арга зүйг зөвлөмжилсөн багшийн номтой байдаг нь багшийн арга зүйн хөгжилд том дэмжлэг болдог.
- Үндэсний хэмжээнд судалгаат хичээлийн мониторинг хийж хэвшсэн.
- Хичээлийн судалгаа, түүний хяналт-шинжилгээг зөвхөн боловсролын явцын үр дүн болох багшийн арга зүйн хөгжилд төдийгүй, улмаар гаралтын үр дүн болох суралцагчдын чадварыг хөгжүүлэх, сурлагын амжилтыг дээшлүүлэхэд чиглүүлдэг болж байна.

Мэргэжилтэн, эрдэмтэн, профессор, сургуулийн удирдлага багш нар, сургагч багшийн нарын хамтын ажиллагаа, харилцан нөлөөлөл буюу манлайлалын механизмын ажиллагаа төлөвшсөн.

Хичээлийн судалгааг сайн хийж байгаа багш нар үндэсний хэмжээнд үнэлэгдэж, багш нар нь тэдний арга туршлагаас нь суралцаж боломжыг бүрдүүлсэн байна.

Ажиглагдсан бусад зүйл, хэрэгжүүлж болох санаа

- Үндэсний түүх соёлыг хичээлүүдийн агуулгад маш сайн тусгаж байна.
- Боловсролын газар нь сургалт, судалгаа, мэдээлэл гэсэн үндсэн гурван үйл ажиллагааг маш цэгцтэй явуулдаг бөгөөд мэргэжилтнүүд зөвхөн эдгээр үндсэн чиг үүргийг гүйцэтгэж байна. Гэтэл манай улсад БСГ-ын мэргэжилтнүүд төрийн захиргааны ажил давхар хийж, багш нартайгаа

хамт судалгаа хийх, туршилт явуулах, бүтээл туурвих боломж багатай байдаг. Тэдний төрийн албан хаагчийн ангиллыг өөрчилж, орон тоог нэмж байж, хичээлийн судалгаа Монголын хөрсөнд баттай ургаж төлжиж боломж бүрдэхээр санагдсан.

- Сургуульд багшилж, туршлага хуримтлуулсан, багшлах арга зүй сайтай хүмүүс сургуулийн захирлаар ажилладаг бөгөөд тэд багшийн мэргэжил дээшлүүлэлт, хичээлийн судалгааны менежментийг шууд хариуцаж, хичээлийн судалгааны үе шат бүрд биечлэн оролцдог.
- Ажилдаа дур сонирхолтой, хүүхдэд чин сэтгэлээсээ ханддаг байх чанарыг багшид тавигдах гол шаардлага гэж үздэг.
- Японы боловсролын эрхэм зорилго нь суралцагч бүрд чанартай боловсрол эзэмших, өөрийгөө нээн хөгжүүлэх тэгш боломжийг бүрдүүлэхэд оршдог тул цөөн хүүхэдтэй сургуульд ч мэргэжлийн бүх багш ажиллаж, суралцах таатай орчин бүрдсэн байна.
- Хүүхдийн хүмүүжилд шууд нөлөөлөхөөр хичээлийн арга зүй нь боловсрогдсон байна.

Хичээлийн судалгааны арга зүй болон менежментийн чиглэлээр

- Орон нутаг, мужийн боловсролын байгууллагын бодлого төлөвлөлт уялдаа холбоо сайн хангагдсан байдаг.
- Сургуулиуд намар, хаврын аялал зохион байгуулж, хүрээлэн буй байгаль, нийгмийн орчны талаар сурагчдын бодол саналыг тэмдэглүүлэх зэргээр хүүхдийг иргэншүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тогтмолжуулсан байна.
- Тухайн орон нутгийн онцлогт тулгуурлан орон нутгаараа бахархах сэтгэлгээг суралцагчдад төлөвшүүлдэг.
- Хүрээлэн буй орчин, байгаль орчны боловсролын сургалт (цагаан будаа ургац хураалт, сургуулийн дотоод ажил, эрүүл орчин)-д орон нутаг, иргэдийн хэрэгцээ, онцлогийг тусгаж, аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллагууд, иргэд, эцэг эхээс дэмжлэг авдаг. Тэднийг үндэсний болон олон улсын боловсролын хөгжлийн чиг хандлагатай танилцуулдаг.
- Орон нутгийн түвшинд мэргэжил, арга зүйн асуудлаар олон арга хэмжээ зохион байгуулдаг нь багш нар арга зүйн туршлагаа сурталчлах, солилцох болон орон нутаг, сургууль, багш нар шинэ хэрэгцээ, зорилтоо тодорхойлох боломж бүрдүүлдэг.
- Орон нутаг нь сургууль, эцэг эх, албан байгууллага, муж тухайн орон нутгийн иргэдэд хийсэн ажлын тайлангаа тавьж, сонин, хэвлэмэл хуудас зэрэг ухуулга, сурталчилгааны материал боловсруулан түгээж, үйл ажиллагаагаа сурталчилж, нийгэмтэйгээ эргэх холбоотой ажилладаг.
- Сорил туршилт ихтэй хичээлийн судалгаа илүү хийгддэг байгалийн ухааны хичээлүүд суралцагчдыг танин мэдэхүйн болон амьдрал ахуйн асуудлыг шийдвэрлэж сурахад түлхүү нөлөөлдөг.
- Сургуулиудад багшийн багшлах, хүүхдийн суралцах материаллаг орчин бүрдсэн.
- Хичээлийн судалгаагаар орон нутгийн түвшинд багш нарын хамтын ажиллагаа нь уламжлал болон тогтмолжсон байна. Багш нар хичээлд сууж, хэлэлцүүлэгт оролцож, багаар ажиллахын зэрэгцээ хяналт шинжилгээ үнэлгээг багш бүр сайн хийж, зөвлөн тусалж, тайлан бичин хамгаалж арга зүйн ахиц, дэвшлээ хянан шинжилж сурсан.
- Хичээлийн судалгааг сайн хийж байгаа багш нар орон нутгийн хэмжээнд үнэлэгдэж, түүний арга, туршлагаас бусад багш нар нь суралцдаг.

Орон нутгийн
түвшинд

Ажиглагдсан бусад зүйл, хэрэгжүүлж болох санаа

- Сургуулиас зохион байгуулдаг аялал, бусад үйл ажиллагаанд эцэг эхчүүд оролцож, сургууль багш нартай нягт хамтран ажилладаг.
- Өөрийн орон нутаг, сургуулийн онцлог тохирсон хичээлийн судалгааг хэрэгжүүлдэг.

Хичээлийн судалгааны арга зүй болон менежментийн чиглэлээр

- Сургуулиуд үйл ажиллагааны бодлого нь оновчтой, зорилго, зорилт нь ойлгомжтой, тэдгээрт хүрэх жилийн болон дунд хугацааны төлөвлөгөө тодорхой болсон. Хичээлийн судалгааны төрлөөс хамаарч сургуулийн менежмент ялгаатай байна
- Хичээлийн судалгаа нь багш бүрийн заавал хийх, хөгжих ажил болсон. Багш бүр сургуулийнхаа төлөвлөгөөнд нийцсэн жилийн ажлын төлөвлөгөөтэй

Сургуулийн
түвшинд

ажилладаг. Хичээлийн жилийн туршид багш бүр 1-2 судалгаат бэлтгэн хичээл заадаг.

- Цэцэрлэг, бага, дунд, ахлах, их дээд сургуулийн залгамж холбоо сайн
- Хичээлийн төлөвлөлт ба сэдэлжүүлүүлэлт, самбар төлөвлөлт ба ашиглалтын өвөрмөц арга зүйтэй.
- Багш нар үндсэн ажилдаа сэтгэлээсээ жигд ажилладаг хандлагатай болж, хамт олон сэтгэл зүрхнээсээ ажилладаг соёлыг сургуулийн хэмжээнд бүрдүүлж чадсан байна.
- Сургуульд багш сурагчдын нээлттэй, тэгш харилцаа төлөвшсөн байдаг.
- Хичээлийн судалгааны бэлтгэл ажилд илүү ач холбогдол өгдөг.
- Хичээлийн хэлэлцүүлэг их өгөөжтэй болдог.
- Багш, суралцагчийн хэн хэнд нь удирдах ажил хийх, өөрийгөө илэрхийлэх, бусдыг манлайлах бололцоог бүрдүүлсэн байна.
- Сургуулийн орчныг цогцоор бүрдүүлсэн ажээ.
- Сургуулийн удирдлага багш нар хамтран ажиллаж хэвшсэн.
- Сургууль багш нарын хичээлийн судалгаа ба мониторинг тогтмолжсон, “Нэг эгнээгээр явж сурах, урагшлах” уриатай.
- Сургуулийн мониторингийн багт сургуулийн удирдлагууд хариуцлагатай ажиллан явцын хяналт-шинжилгээнд оролцдог тул тэд өөрсдөө багшийн өөрчлөлт, ахицийг сайн мэддэг.
- Багш, сурагчдыг тэр бүр дүгнэдэггүй, явцын үнэлгээг албан бичгээр тайлагнадаг.
- Сургууль, багш нарын үнэлгээнд эцэг эх оролцдог.

Ажиглагдсан бусад зүйл, хэрэгжүүлж болох санаа

- Бага ангийн сурагчид нь өөрсдөө ангиа цэвэрлэдэг.
- Багш ангиа 1-2 жил дааж ажилладаг. Ангийн багш бол дагуул багш биш.
- Хүүхдүүд эрүүл ногоон орчинд сурч хүмүүжиж байна.
- Хүүхдийг бие даалган хамт олонд төлөвшүүлж, авьяасыг хөгжүүлдэг.
- Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн орчин, сургалт гайхалтай.
- Сурагчдын хувцаслалт жигд.
- Сургууль бүр өөрийн онцлогт нийцүүлэн боловсролын шатлал, анги болгоноор нарийвчилсан тусгай зорилттой ажилладаг.
- Зочилсон сургуулийн нийт суралцагчдын 80-92 хувь ямар нэгэн дугуйланд хамрагддаг бөгөөд багш нарын баг дугуйлан удирддаг. Ямар ч илүү цагийн хөлс, нэмэгдэл авдаггүй бөгөөд тэд суралцагчдаа хөгжүүлэх зорилгоор энэ ажлыг үндсэн үүрэгт ажлын нэг хэмээн үздэг.
- Номтой нөхөрлөх аян зохиох, сургуулийн ном унших цагтай байх зэрэг суралцахууд үр өгөөжтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх менежменттэй нь төлөвлөн хэрэгжүүлдэг.
- Сургуулийн музейн тухайн сургуулийн түүх, үнэт зүйлсийг таниулах зориулалттай.

Япон улсад сургалтад оролцсон болон Монголд хичээлийн судалгааг туршин хэрэгжүүлж байгаа загвар болон загвар бус аймаг, сургуулиудаас хичээлийн судалгааны менежментийг хэрхэн нэвтрүүлж, багш нар хичээлийн судалгааны арга зүйд хэрхэн суралцаж байгаа талаар үнэлгээ хийж, тэдний хүчин чармайлтыг үр дүнтэй болгоход үндэсний хийгээд орон нутгийн боловсролын байгууллага, сургуулийн захиргаанаас цаашид ямар зорилттой ажиллах нь зүйтэй талаар дараах саналыг дэвшүүлж байна.

Сургалтаар мэдсэн зүйлээ тцгээн дэлгэрцлэхээр хэрэгжүүлсэн ажил, цаашидын зорилт, санал болгох зүйл

Хичээлийн судалгааны арга зүй болон менежментийн чиглэлээр

- Багш нар хичээлийн судалгааг хийснээр ажлын байрандаа мэргэжил дээшлүүлэх боломж бүрдэж байна. Хичээлийн судалгааг хийх замаар багш нарын хамтын ажиллагаа, багаар ажиллах чадвар сайжирч байгаа нь илт ажиглагдаж байна.
- Улсын хэмжээнд хичээлийн судалгааны үе шат, ажилбарууд багшийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актуудад хангалттай түвшинд туссан ч тэдгээрийг хэрэгжүүлэх удирдлагын бүх түвшний менежментийн учир дутагдал, хоцрогдол, хичээлийн судалгааны талаарх ойлголтын зөрөө

зэргээс хамаарч багшийн арга зүйн хөгжлийг тасралтгүй хангах арга хэрэгсэл болгон эзэмших, хэрэглэх үйл явц жигдэрч, улмаар суралцахуйд бодит үр өгөөжөө өгч чадахгүй байна.

Цаашид:

- Хичээлийн судалгааг тодорхой бодлого, төлөвлөгөөний дагуу тогтмол хийдэг болох
- Суралцагчдын хүмүүжил, төлөвшилд хичээлийн арга зүй шууд нөлөөлөхийн зэрэгцээ орон нутаг, эцэг эхтэй хамтран хэрэгжүүлдэг хичээлээс гадуурх бие даасан үйл ажиллагааны хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг тогтолцоог нэвтрүүлэх
- Орон нутаг, бүсийн багш нар өөрсдийн сурагчдын хэрэгцээ, онцлогт нийцсэн зорилго, уриа, төлөвлөгөөтэй ажилладаг болох.
- Багшийн цалин хөлс, урамшууллыг хичээлийн судалгааны хэрэгжилттэй холбох бүрэн боломжтой. Энэ талаар сургуулийн удирдлагын менежментийн ур чадварыг дээшлүүлэх сургалтын тусгай модуль боловсруулж, үндэсний түвшинд бүх захирал, сургалтын менежерийг хамруулах, зөвлөмж боловсруулан хэрэглүүлэх
- Эхний ээлжинд бүх багшид төслийн хүрээнд хэвлэгдсэн сургалтын модулиудтай танилцуулаад, орон нутаг болон загвар сургуулийн багш нар тэдэнд зориулсан сургалт явуулж, дараа нь хичээлийн судалгаанд биечлэн оролцуулах замаар хичээлийн судалгааны талаарх ойлголтын зөрөөг багасгаж, бүтээлчээр хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх
- Засгийн газар, БШУЯ-аас бага, дунд боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг сайжруулаад тэдгээрийг тогтвортой мөрдүүлэх
- Багшийн мэргэжил дээшлүүлэх институт нь багш нарыг тодорхой жилийн давтамжтайгаар (1, 5, 10, 15 жил гэх мэт) мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад хамруулах үйл ажиллагааг чанартай, үр өгөөжтэй хэрэгжүүлэх. Энэхүү сургалтын хөтөлбөрт хичээлийн судалгааны арга зүйн гүнзгийрүүлсэн, шинэчилсэн агуулгатай модуль боловсруулан оруулж байх нь хичээлийн судалгааны шинэ төлөв, хандлага сургууль багш нарт тасралтгүй түгэн дэлгэрч байх гол нөхцөлийн нэг болох ач холбогдолтой.
- Үндэсний түвшинд судалгаат хичээл явуулж, сурагчдын чадварыг хөгжүүлж байгаа багш нарын туршлагыг үнэлэх, технологийн сандаа бүртгэх, тэдгээр багш нарыг алдаршуулах, урамшуулж байх
- Хичээлийн судалгаа, судалгаат хичээлд мониторинг хийх аргачлалаа боловсронгуй болгож байх, Орон нутгийн болон сургуулийн удирдах ажилтны манлайллыг өндөржүүлэх, идэвхжүүлэх
- Хичээлийн судалгааны мониторингийг эхний ээлжинд багшийн арга зүйд гарч буй өөрчлөлтийг сурагчдын чадварт гарч буй өөрчлөлтийг үндэслэн үнэлэх гэх мэтээр багш-суралцагчийн эзэмшихүйн зүй тогтолд нийцүүлэх стратеги баримтлах. Эс бөгөөс шинээр сонссон, ярьсан болгоноо эзэмшсэнд эндүүрч, сурагчид хөгжлөө гэх хийрхэлд хүрч болзошгүйг анхаарах
- Багш бэлтгэдэг их, дээд сургуулийн сургалтын төлөвлөгөөнд хичээлийн судалгааны арга зүйн хичээл оруулж, багшлах дадлага хийх үед нь туршуулан эзэмшүүлэх
- Хичээлийн судалгааг сургалтын үндсэн үйл ажиллагааны салшгүй хэсэг болгон түүнтэй холбогдон гарах зардлыг сургуулийн болон Боловсролын газрын төсөвт тусгадаг болох

Ажиглагдсан бусад зүйл, хэрэгжүүлж болох санаа

- Цөөхөн бус нийт сурагчдаа хөгжүүлж байгаа багш, сургуулийг багаар нь манлай сургуулиар нь шалгаруулж дэмждэг байх
- Багш нарын мэргэжил дээшлүүлэх тогтолцооны үйлчилгээний хүртээмж, нийц, чанар, үр ашиг, үр өгөөж, тогтвортой байдлыг хангах бодлого баримтлах
- Туршилт хийсэн багш нар гарын доорх материал ашигласан бүтээсэн сорил, туршилтууд болон хичээлийн сайжруулсан хөтөлбөрийг бусад багш нарт түгээх арга механизмыг ажиллуулах

Хичээлийн судалгааны арга зүй болон менежментийн чиглэлээр

- Аймаг, нийслэлийн Боловсролын газар, Боловсролын хэлтсийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, тэдгээрт хичээлийн судалгааны орон нутгийн менежментийг төвлөрүүлэх нь хичээлийн судалгааг илүү хүртээмжтэй,

Орон нутгийн
түвшинд

өгөөжтэй явуулах боломж олгоно. Энэ нь манай улс дахь сургуулийн бүтэц, хэв шинж, байршлийн онцлогтой холбоотой.

- Нийслэлийн Боловсролын Газар, Боловсролын хэлтсүүд хоорондоо уялдаатай, тодорхой бодлого төлөвлөлттэй ажиллах
- Тойргийн сумдын сургуулиудын хооронд багш солилцох үйл ажиллагаа зохион байгуулж эхэлсэн.
- Бүсийн түвшинд сургууль дундын ЗАН-ийг байгуулж, 8судлагдахуунаас бусадхичээлийн багш нар хичээлийн судалгааг хамтран явуулж, туршлага солилцож байна.
- Хичээлийн судалгааг экосургууль, эрүүл мэндийг дэмжигч сургууль зэрэг сургуулийн хөгжлийн бусад хөдөлгөөны үйл ажиллагаатай уялдуулах. Тухайлбал, экосургууль хөдөлгөөнд хамрагдсан Чандмань-Эрдэнэ цогцолбор сургууль байгалийн ухааны хичээлийн туршилтын талбайтай болсон бол Завханмандал суманд хогийн менежментийг хэрэгжүүлсэн.
- Аймгийн загвар сургуулиуд төвийн болон тойргийн сумдын сургуулиудын багш, удирдлагуудад сургалт явуулж, туршлагаасаа хуваалцаж, хамтран хичээлийн судалгаа явуулж байна.
- Загвар аймгийн загвар сургуулиуд хамтарч загвар бус сургуулийн багш нарыг хичээлийн судалгаанд татан оролцуулж, зөвлөн туслаж ажиллаж байна.
- Загвар аймаг, дүүргийн бүх сургуулиуд багш бүрийг хамруулсан хичээлийн судалгаа болон мониторингийн багийг байгуулан ажиллаж байна.

Цаашид:

- Аймгийн түвшинд судалгаат хичээлийг явуулж, туршин сайжруулахыг зорьж байна. Энэ нь орон нутгийн бүх багшид ач холбогдолтой.
- Бүсийн сургалтаар сургуульд суурилсан хичээлийн судалгааг хэрэгжүүлэх төлөвлөгөөг сургууль тус бүрээр байдлаар төлөвлөгөө гаргуулж нэгдсэн зохицуулалтаар хангах
- Орон нутгийн түвшинд сум, дүүргийн багш нараа хичээлийн судалгаанд бүрэн хамруулах менежментийг бий болгож, загвар сургуулиудын түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг чанаржуулахад дэмжлэг үзүүлэх.
- Аймгаас сургуулиудын хичээлийн судалгаанд хяналт шинжилгээ хийх ажлыг сургуулиудад зөвлөн туслах ажлын салшгүй хэсэг болгон зохион байгуулдаг болох.
- Жил бүр, бүс болон сургууль бүрээр хичээлийн судалгаа хийсэн тайланг хэлэлцэн туршлагаа дүгнэж, сургамжаа ялган тодорхойлж байх
- Хичээлийн судалгааны үр дүнд бүтээгдсэн сайн хичээлүүдийн сантай болж, бусад багшид түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах
- Хичээлийн судалгаа, судалгаат хичээлийн хүрээнд хийсэн ажлаа вэбсайт, радио, телевиз, плакат, сургалт, хурлаар эцэг эх, иргэдэд мэдээллэх
- Боловсролын газраас аймаг, дүүрэг, нийслэлийн түвшинд хичээлийн судалгаатай холбоотой бага, хурал, форум зэргийг зохион байгуулж, тэдгээрийн үр дүнг багшийн ур чадварын болон мэргэжлийн зэргийн өсөлтийг тооцох арга механизмтай холбож өгөх
- Сургууль багш нар хичээлийн судалгааг чанартай хийх хэрэгцээ, сонирхолыг төрүүлэхүйц манлайллын хөшүүргүүдийг орон нутгийн түвшинд бий болгох хэрэгтэй.

Ажиглагдсан бусад зүйл, хэрэгжүүлж болох санаа

- Орон нутаг, сургуулийнхаа хэрэгцээнд тохирсон сургуульд суурилсан хичээлийн судалгааны сэдвийг сонгох нь илүү өгөөжтэй.
- Багш нарт сургалт зохион байгуулах, шинэ арга зүйг түгээн дэлгэрүүлэх ажлын менежмент ба багш нарын арга зүйд өөрчлөлт гарч байна.
- Хичээлээс гадуурх арга хэмжээ явуулах, сургалтын орчин бүрдүүлэх зэрэг олон төрлийн үйл ажиллагаанд эцэг эхийг татан оролцуулж байна.
- Эхлээд аймгийн хэмжээнд бүх багш холбогдож туршлагаа хуваалцдаг мэйл хаягтай болж улмаар schoolnet сүлжээтэй болох нь зүйтэй.

Хичээлийн судалгааны арга зүй болон менежментийн чиглэлээр

- Сургуулийнхаа стратеги төлөвлөгөөнийхөө зорилго, зорилтыг оновчлон, илүү тодорхой, ойлгомжтой болгож байна.
- Хичээлийн судалгаа хийх сургуулийн төлөвлөгөөтэй ажиллаж байна.

- Багш бүрийг хичээлийн судалгаа, судалгаат хичээлд оролцох, хичээл заах төлөвлөгөөтэй болгож, түүнийгээ хэрэгжүүлэх боломжоор хангахад анхааран ажиллаж, “Нэг эгнээгээр явж сурах”-ыг хичээж байна.
- Загвар сургуулийн багш нар хичээлийн судалгаа хийж, хоорондоо туршлагаа байнга солилцон ярилцдаг болсон.
- Бүх багш нар хичээлийн судалгааг төлөвлөгөөний дагуу хийж туршлага хуримтлуулан хамтран ажиллаж байна.
- Багш нарын дундаас 8 судлагдахуунаар санаа нийлсэн багш нар сонирхлын бүлэг байгуулан хичээлийн судалгаа хийж байна.
- Японд явсан багш нарыг баг болгон бүс, тойргийн сургуулиудад зочлуулан хичээл заалгаж, бүтээлийн үзэсгэлэн гаргасан.
- Хичээлийн судалгаа, судалгаат хичээлийг дүүргийн бүсийн 7 сургууль, бусад аймгийн зарим сургуулийн багш нарт түгээн дэлгэрүүлж байна.
- Нийслэлийн сургуулиудын сургалтын менежерүүдэд хичээлийн судалгааны тухай сургалт зохион байгуулсан.
- Сургуулийн захирлын тушаалаар хичээлийн судалгаанд оролцсон багш нарт болон баг хамтлагт хийсэн ажлын чанараас хамааруулан холбогдох хууль тогтоомжийн дагуу ур чадварын нэмэгдэл болон улирлын мөнгөн урамшууллыг ялгаатай хувь хэмжээтэйгээр олгох, бусад шагнал, урамшуулалд хамруулах, багш нарт сургалтын цаас, техник хэрэгсэл, самбарыг нь томсгох зэрэг манлайллын арга хэрэгслийг ашиглаж байна.
- Багш нарт бие биеийнхээ хичээлд ажиглалт хийж, хамтран ажиллах боломж олгосон хичээлийн хуваарийн зохицуулалт хийгийг хичээж байна.
- ЗАН-ийн үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах
- Сургуулийн мониторингийн баг ажиллуулж байна.
- Сургуулийн удирдлага, сургагч багш нарын мэдлэг чадварыг улам сайжруулж, хамтын ажиллагааг хэвшүүлэх үйл ажиллагааг хийж байна.
- Сургууль дээр зохион байгуулагдаж байгаа хичээлийн судалгаанд сургуулийн захирал, менежер, ЗАН-ийн ахлагч хөндлөнгийн ажиглалт хийж, хэлэлцүүлэгт оролцож, мониторинг хийдэг.
- Судалгаат хичээл бүрээр сайжруулсан хөтөлбөрийн эмхтгэлтэй болж, байгалийн ухаан, бага ангийн ЗАН манлайлан оролцож байна. Сурагчдад ч чадварын тодорхой ахиц гарч байна.
- Сургуулийн удирдлага, багш, эцэг эх, сурагчид хамтран ажиллаж байна.
- 2012-2013 оны хичээлийн жилээс тэнхимийн эрхлэгч нарыг нэг жилийн хугацаатай ажиллуулж, багш нарт удирдах ажил хийх боломж олгосон.
- Сурагчдыг 7-10 хоногт ээлжлэн ангийн дарга болгож, хүүхэд бүрийг удирдан зохион байгуулах ажилд оролцуулснаар тэд бусдад нээлттэй, өөртөө итгэлтэй болж эхэлсэн.
- Бага, дунд ангид хичээл эхлэхийн өмнө ном уншуулах ажил хэвшиж байна.
- Сургуулиа хүүхэд бүр бүтээлч байх орчин, хүүхдийн ертөнц болгон өөрчилж, тэдний авьяасыг хөгжүүлэх шинэ аргачлалыг туршиж байна.
- Багш нар хичээлийн судалгааг мониторинг болон судалгаат хичээлийн үед төдийгүй, ямар ч үед түүнийг өөрийнхөө арга зүйн ур чадварыг хөгжүүлэх арга хэмээн үзэж, чин сэтгэлээсээ сайн хийх хандлагатай болсон.
- Хүүхдийн авьяасыг хөгжүүлэх чиглэлээр төрөл бүрийн дугуйлангууд хичээллүүлж эхэлсэн.



Зураг 3.4. Сургууль дээрх судалгаат хичээл

Ажиглагдсан бусад зүйл, хэрэгжүүлж болох санаа

- Цөөн хүүхэдтэй сумын сургуулиуд эхний ээлжинд сургуульд суурилсан хичээлийн судалгааг хэрэгжүүлэх замаар хичээлийн судалгааны арга зүйг эзэмшээд, дараа нь сургууль дундын буюу бүсийн сургуулиудын багш нартай хамтран судлагдахуунд суурилсан хичээлийн судалгааг нэвтрүүлэх

- Сургуулиуд хоорондоо багш солилцон ажиллах боломжтой
- Самбар төлөвлөлт, ашиглалтад сайжруулж, өнгийн шохойгоор хангаж, хэрэглүүлж хэвшүүлэх
- Хүүхдийн дэвтэр, тэмдэглэлд онцгой анхаарал хандуулах
- Сурагчдын чадварыг бага ангиас нь илрүүлж алхам алхмаар хөгжүүлэх
- Багш, ажилтны сэтгэл зүйн, үйлийн бүтээлч уур амьсгал бүрдүүлэх
- Хэл, нийгмийн ухаан, хүмүүнлэгийн хичээлд хичээлийн судалгааг нэвтрүүлэх
- Сургуульд суурилсан хичээлийн судалгааг төлөвлөхдөө сурагчдын хөгжил төлөвшлийг судалж, ямар зан үйл, чадвар төлөвшүүлэх шаардлагатайг тогтоон цаашдынхаа зорилгод тусгадаг болох
- Ахуй амьдралд хэрэгтэй, зайлшгүй мэдэх зүйлийг багаас нь зааж, бүх нийтэд хэвшүүлэх нь хүүхдийн хүмүүжиж төлөвшихөд маш чухал юм.

Орон нутгийн
түвшинд гарсан
өөрчлөлтөөс

Төслийн үр дүнд боловсролын менежмент, сургалтын технологид гарч буй зарим өөрчлөлт

Орон нутаг, сургуулийн түвшний байгууллагуудын үйл ажиллагаа, холбогдох албан тушаалтнуудын чиг үүрэгт төслийн хэрэгжилттэй холбоотойгоор гарсан дараах өөрчлөлт гарч байна.

Аймаг, сумын ЗДТГ

- *Засаг даргын хөтөлбөр:* Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт багшийн арга зүйн хөгжлийг дэмжих талаар тусгайлсан зорилгууд дэвшүүлж ажилладаг болсон. Мөн аймаг, нийслэлийн ИТХ-аар багшийн хүрэлцээ, хангамж, тэдний хөгжлийг дэмжихэд чиглэсэн бие даасан бүлэг бүхий орон нутгийн боловсролын хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх болсон.
- *Урамшуулал:* Санаачилгатай, үр бүтээлтэй ажилласан сургууль, багш нарыг шалгаруулах шалгуур үзүүлэлтэд хичээлийн судалгааг үндсэн шалгуураар оруулж, хичээлийн судалгааг чанартай зохион байгуулах багш, сургуулийг урамшуулан шагнадаг болсон.

Боловсролын газар

- Бодлого, төлөвлөлт: Үндэсний хэмжээнд мөрддөг цогц журмуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа төвлөрүүлдэг болсон. Багшийн үйл ажиллагаатай холбоотой эдгээр эрх зүйн баримт бичгүүдэд хичээлийн судалгааг сургуулийн түвшинд сургалтын үндсэн үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх, түүний үр дүнг үнэлэн урамшуулах арга механизмыг нарийн, тодорхой зааж өгсөн байгаа нь хичээлийн судалгаа бол ямар нэг төсөл хөтөлбөр гэсэн ойлголтоор хэрэгжих бус ерөөсөө багшийн үүрэгт ажил, сургалтын үйл ажиллагаагаа үр дүнтэй сайн зохион байгуулах үндсэн арга зам гэж үзэж, хичээлийн судалгааны менежментэд хандах хэрэгтэй.
- Багш удирдах ажилтны мэргэжил ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр орон нутгийн стратеги, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжүүлж байна. Хичээлийн судалгааны түшиц сургуулиуд, сургагч багш нарыг баталгаажуулан тэдэнд урамшуулал олгох, өөрийн болон бусад сургуулийн багш нартай ажиллах цаг, орчны боломжоор хангах арга хэмжээг авч эхэлсэн. Сургуулиуд судалгаат хичээл зохион байгуулах хугацаа болон мөрдөж хэвших ажлын удирдлага зохион байгуулалтаар хангаж байна.
- Судалгаа: Багш нарт өгөх арга зүйн, зөвлөгөө барьцтай, системтэй, төлөвлөгөө, чиглэлтэй болж, мэргэжлийн туслалцаа чанаржих эхлэл тавигдсан. Төслийн зорилтот бүлэгт хамрагдаагүй мэргэжилтнүүд хичээлийн судалгаанд оролцож, хичээлийн судалгаа хийж буй багш нарт туслах замаар мэдлэгээ дээшлүүлдэг болсон. Мэргэжил дээшлүүлэх ажлыг хичээлийн судалгаатай холбож, арга зүйн шинэчлэлийг түгээн дэлгэрүүлэх менежементийг тодорхой судалгаанд үндэслэн хийхийг зорьж байна.
- Сургалт: ЕБС-ийн удирдах ажилтан, багш нараас гадна газрын бүх мэргэжилтнүүд сургалтад хамрагддаг болсон. Багш бүрийг мэргэшил, арга зүйн ур чадвараа системтэй дээшлүүлэх тэгш боломжоор хангах, тэдний сонирхлын бүлгийн үйл ажиллагааг дэмжиж ажиллахыг чухалчилж байна.
- *Хяналт-шинжилгээ, үнэлгээ:* Сургууль бүрд зөвлөн туслах, багшийн хөгжилд гарч байгаа ахиц өөрчлөлтийг үнэлэх, төслийн эхний шатанд боловсруулсан хичээл үнэлэх *хуудсыг* ашиглан багш нарын хичээлийг үнэлэх, “Багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэхэд баримтлах чиглэл”-

ийг орон нутгийн хэмжээнд нэг мөр мөрдөн ажиллах, сургуулийн үйл ажиллагааг үнэлэх үнэлэгээ илүү бодитой, цэгцтэй болсон.

- *Бусад арга хэлжээ:* Сургуулийн удирдах ажилтны ажлын урамшууллын үнэлгээнд багш нарын арга зүйн хөгжлийн ахицыг тусгаж, сургууль, багшийн туршлага, үр дүнг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулдаг.

Сургуулиуд ялангуяа, загвар сургуульд дараах өөрчлөлт гарч байна.

Сургуулиуд хичээлийн судалгааг түгээн дэлгэрүүлэх хамтран ажиллах төлөвлөгөө, гэрээтэй ажиллах болсон.

Сургуулийн жилийн болон дунд хугацааны төлөвлөгөөнд хичээлийн судалгаа тусгаж, графикайн дагуу судалгаа хийдэг болсон.

Боловсролын стандартын биелэлтийн үр дүнг нарийвчлан тогтоож, түүнд үндэслэн хичээлийн судалгааны сэдвийг сонгон тухайн жилийнхээ сургалтын менежментээ чиглүүлэх болсон.

Сургууль бүр сургагч багшийн багтай болж, багш бүрийг “Хичээлийн судалгаа”-ны арга зүйд сургаж, бусад сургууль, багш нарт сургалт явуулдаг болсон.

Багш бүр хичээлийн жилд хоёроос доошгүй удаа хичээлийн судалгаанд биечлэн оролцож, үр дүнг тооцдог болсон.

Багшлахуйн арга зүй, ур чадвар, суралцагчдын хөгжил төлөвшилд гарч байгаа ахиц өөрчлөлт, туршлагын эмхтгэлтэй болж, түүнийгээ түгээн дэлгэрүүлэх ажилдаа хэрэглэж байна.

Сургалтын менежер өөрийн ажилдаа илүц нарийвчлалтай ханддаг болсон.

- *Зохион байгуулах* (багш нарт сургалт явуулах, баг байгуулах, хичээлийн явцыг видео камер, зургийн аппарат зэргийг ашиглан баримтжуулах, судалгаат хичээл анги танхимыг сонгон, ажиглагчид хаана зогсох, видео камерыг хаана байрлуулах зэргийг төлөвлөх, сурагчдад ажиглалт хийх хүмүүсийг танилцуулах, хичээлийн хуваарийн зохицуулах)
- *Удирдан чиглүүлэх* (судалгаа хийх заавар, гарын авлага боловсруулж, багш нарт өгөх, хэлэлцүүлэг удирдах, ажиглалт хийх хүмүүст зөвлөх)
- *Хамтран ажиллах* (Хичээлийн судалгааны үе шат бүрд адил ач холбогдол өгч, судалгааны алхам бүрийг нарийн нягт ойлгон, судалгаат хичээлийг зохион байгуулах, менежер өөрөө судалгааны аль нэг багийн гишүүнээр ажиллах, хичээлийн хэлэлцүүлгийг зөвхөн тухайн багшийн хэрэг гэж үзэлгүй өөрөө манлайлан бусдыг идэвхтэй оролцуулах)
- *Зөвлөн туслах* (Хичээлийн хэлэлцүүлэгт оролцсон болон ажиглагч хүн бүрийн дараагийн хичээлийг сайжруулах талаар тэмдэглэсэн санал болонажиглалтын хуудас дээрх оноог нэгтгэн, тоон болон чанарын үнэлгээ хийж, хичээл заасан төдийгүй нийт багшийн арга зүйг сайжруулах чиг хандлагыг тодорхойлон дүгнэлт гаргаж, зөвлөгөө бэлтгэх)
- *Түгээн дэлгэрүүлэх* (Хийсэн судалгаа, гаргасан дүгнэлтдээ үндэслэн өөрийн болон бусад сургуулийн багш нарт түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх)

Төсөл хэрэгжих явцад хичээлийн судалгааны арга зүй, менежментийг хэмжээ, бүтэц, хэв шинжийн хувьд эрс ялгаатай сургуулиудын мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцаа авах боломж нь харилцан адилгүйгээс багш, удирдах ажилтнуудад тодорхой бэрхшээл учирч байна. Эдгээр бэрхшээл, сорилтыг даван туулах арга хэлбэрийг загвар аймаг, сургуулиуд олж, төслийн үйл ажиллагааг тасалдуулаагүй байна. Гэвч цаашид эдгээр бэрхшээл нь багшлах арга зүйн шинэчлэлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцооны менежментийг боловсронгуй болгох, хичээлийн судалгааг Монголын сургалтын менежментэд бүрэн нутагшуулахад үндэсний түвшинд шийдвэрлэх шаардлагатай асуудлын нэг болж байгааг харуулж байна (Хүснэгт 3.3).

Сургуулийн түвшинд гарсан өөрчлөлтөөс

Хүснэгт 3.3 Хичээлийн судалгааны арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх менежментэд тохиолдож буй бэрхшээл, шийдвэрлэх арга зам (үндсэн субъектээр)

Хөнд	Бэрхшээл	Даван туулсан эсвэл, санал болгох арга зам	Түгээн дэлгэрүүлэхэд шинээр санаачилсан ажил
<p>БСГ-ын мэргэжилтэн</p> <ul style="list-style-type: none"> • Мэргэжилтнүүд тус тусын мэргэжлийн хичээлийн судалгаанд оролцон ажиллахад онц бэрхшээл байхгүй. Гэвч өөрийн гэсэн сургалтын техник хэрэгсэл дутмаг учир сургалт явуулах, хичээлийн судалгаа хийхэд сургууль, багш нараас проектор, камер гуйж олох бэрхшээл гарсан. • Загвар сургуулиудын хувьд зарим судлагдахууны сургалтын агуулга нь мониторингийн үр дүнд тулгуурлахгүйбайгаа нь харгадаж байлаа. “Төсөлт ажил”-ын сургалтад сууж буй багш нарын энэ хичээлийн талаарх ойлголт зөрөөтэй, дутмаг, байсан. • Сургуулийн удирдлагууд өөр өөр сургалтад, төвлөрч жигд оролцохгүй байсан. • Загвар бус аймгуудад сургалт зохион байгуулах зардал байхгүй, сургалтын материал, ном, гарын авлагагүй байсан. 	<ul style="list-style-type: none"> • Хичээлийн чанарын үнэлгээ хийхдээ мэргэжилтнүүд хамтран хийж байгаа нь тэдний ойлголтыг нэгтгэж, бие биеэсээ суралцах боломж өгнө. • Мониторинг чанартай хийж, багш нарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэхүйц сургалтын агуулгыг сонгон боловсруулж болохыг харуулж чадсан баг (химли)-аас бусад багууд санаа авсан. • Цаашдаа удирдлагуудад зориулсан сургалтыг хичээлийн судалгааны арга зүй ба түүний менежмент гэсэн хоёр тусгай агуулгаар явуулна. • Загвар бус аймгуудад тусгай хөгөлбөр боловсруулж байж, УИХ-ын гишүүдийн санхүүгийн дэмжлэг авч сургалт хийсэн. Мөн БСГ-аас хялбаршуулсан гарын авлага, зөвлөмж боловсруулан гаргаж, бүх сургуульд хүргэх, БСГ-ын блог хаяг дээр электрон хэлбэрээр байршуулах, сургалтын үед file-аар багш нарт тараах замаар дээрх бэрхшээлийг шийдвэрлэж байна. 	<ul style="list-style-type: none"> • Багш нарын хичээлд чанарын үнэлгээ хийлгэх замаар төслийн багт ороогүй болон шинээр орж ирсэн мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулж байна. • Загвар бус аймаг (Завхан) Японд сургууль төсөгчдийн холбоо байгуулж, сурнаа бусдад түгээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх санаачилга гаргасан. • Загвар бус аймгийнхан (Ховд) багш нарын үр чадварын уралдаанд оролцсон бага, дунд ангийн багш, сургалтын менежерүүдэд сургалт зохион байгуулж, зарим сургууль дээр үзүүлэх “Судалгаат хичээл”-ийг зохион байгуулах, аймгийн төвийн сургуулиудад мэргэжил бүрээр 14 хоногт 1 удаа БСГ-ын мэргэжилтний хамтарсан судалгаат хичээлийг зохион байгуулж эхэлсэн байна. 	
<p>Сургуулийн захирал</p> <ul style="list-style-type: none"> • Аймгийн төвөөс бусад сургуулийн захирлуудын хувьд бүсийн сургалт хийх, сургагч багш нараа оролцуулахад унаа, томилогтын зардлын эх үүсвэр дутагдах, мэргэжлийн цөөн багштай сургуульд сургагчдын хичээлийг тасалдуулахгүйгээр багш нарын хичээлийн цагийг зохицуулахад бэрхшээл учирч байна. 	<ul style="list-style-type: none"> • Бүсийн сургууль болон загвар бус аймгийн сургуулиудад ажиллах унаа, томилогтын зардлыг гал унтраах зарчмаар бусад эх үүсвэрийг хайж замаар зохицуулсан. Цаашдаа зардлын тогтвортой, тодорхой эх үүсвэрийг бий болгох шаардлагатай. • Сургуулийн захирлуудын сэтгэлгээ, хандлагыг өөрчлөх, үр чадварыг нэмэгдүүлэх нь хичээлийн судалгааны хөгжилд чухал ач холбогдолтой. 	<ul style="list-style-type: none"> • Загвар аймгийн зарим сумдын сургуулийн захирлууд бүсийн сургуулиудтай зардал хуваах үндсэн дээр зохицуулалт хийж, сургалтаа зохион байгуулсан байна. Багш нарт ажлын хөлс өгөхийн оронд үр чадварын нэмэгдэл болон улирлын мөнгөн урамшууллыг хичээлийн судалгаанд оруулсан хувь нэмрийг нь тооцон олгох зэргээр асуудлыг шийдвэрлэж байна. 	

<p>Сургуулийн менежер</p>	<ul style="list-style-type: none"> Сургуулийн менежер анхны үедээ хичээлийн судалгааг удирдахдаа тулгамдах, багш нарыг шалгадаг хуучин арга барилсаасаа салж чадахгүй, багш нарыг байр эзлүүлж уралдуулдаг нь хэвээр байсан ч яваандаа энэ арга барил нь өөрчлөгдөж байна. Гэвч зарим сургуульд энэ байдал өөрчлөгдөж чадахгүй байна. Хичээлийн хэлэлцүүлгийн болон мониторингийн үр дүнг нэгтгэн боловсруулахад хугацаа маш их шаардагдаж байна 	<ul style="list-style-type: none"> Менежерүүд хичээлийн судалгааг хөндлөнгөөс ажиглах бус түүний үе шат бүрд болон мониторинг хийхэд биечлэн оролцуулах замаар шийдвэрлэж байна. Цаашдаа тэдний ачаалал хэт их байгааг анхаарч шийдвэрлэх шаардлагагүй. Хичээлийн судалгааны болон мониторинг, ер нь багшийн үнэлгээтэй холбоотой мэдээлэл цуглуулах, боловсруулах, үнэлэх оновчтой арга зүйг сонгож, цахим хэлбэрт шилжүүлэх шаардлагагүй. 	<ul style="list-style-type: none"> ЗАН-ийн бүтэц болон үйл ажиллагааны менежментийг хичээлийн судалгааны шаардлагад нийцүүлэн боловсронгуй болговол сургалтын менежментийн тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэх боломжтой. Сургуульд хүний нөөцийн менежер гэсэн шинэ орон тоо бий болгон, хүний нөөцийн менежментийн чиг үүргийг гүйцэтгүүлж, сургалтын менежерийн чиг үүргийг мэргэжил, арга зүйн ажилд бүрэн чиглүүлэх нь багшийн арга зүйн хөгжлийг хангах зайлшгүй нөхцөл мөн. Бүсийн физикийн багш нарыг оролцуулан "Хүч ба хурдатгал" сэдэвт судалгааг хичээлийг 3 удаа давтан сайжруулсан.
<p>Сургуулийн багш</p>	<ul style="list-style-type: none"> Багш нарын тухайд хичээлийн судалгааны талаарх ойлголтын зөрөөнөөс хамаарч, янз бүрийн түвшинд ажиллаж байна. Ажиллалт судалгаанаас үзэхэд загвар болон загвар бус сургуулийн аль алинд нь мэргэжлээс шалтгаалан багш нарын хичээлийн судалгааны талаарх ойлголт жигд бус, түүнд хандах хандлага харилцан адилгүй байна. 	<ul style="list-style-type: none"> Энэ байдлыг арилахын тулд давтан сургалт хийх буюу хичээлийн судалгаанд суралцсан багш бүр 1-2 багшийг дагалдуулан сургах арга замыг сонгож болох юм. Багш нарын үүсгэл санаачилга, сонирхлоор нь баг болгож, багийн ажлагчаар сургагч багш (мэргэжлийн)-ийг ажиллуулсан Сургуулийн жилийн ажлын төлөвлөгөөнд хичээлийн судалгааг тусгаж, багууд графикийн дагуу судалгааг хичээл заадаг болсон. 	<ul style="list-style-type: none"> Загвар дүүргийн бүсийн сургуулийн багш, залуу болон шинээр ирсэн багш нарт судалгааг хичээлийг 8 мэргэжлийн хичээлээр хэд хэдэн удаа зохион байгуулсан. Загвар бус аймаг (Дархан-Уул) сургуулийн багш нар ирж, сургалтад хамрагдан, хичээлийн судалгаанд оролцсон. Сургуульдаа мэргэжлийн 8 судалгаат хичээл явуулж, бүсийн багш нарыг урьж оролцуулдаг бөгөөд төслийн баг болон мэргэжлийн багийн гишүүд ирж, ажиллалт хэлэлцүүлэгт оролцон багш нарт зөвлөгөө өгдөг.

3.4. Хичээлийн судалгаанд суурилсан багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежмент

Нэгтгэн дүгнэвэл, өнгөрсөн 20 гаруй жилд сургалтын технологи, багшлах арга зүйг шинэчлэх талаар Монгол Улсын төр, хөгжлийн төлөө түншлэгч гадаадын олон байгууллагаас ихээхэн оюуны болон матриаллаг хөрөнгө оруулалт хийж, боловсролын салбарынхан чамлахааргүй хүчин чармайлт гарган ажиллаж ирсэн гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, сургалтын технологи, багшлах арга зүйг шинэчлэх шаардлагатай онол арга зүй, техник санхүү, хууль эрх зүйн олон талт нөөцийг бүрдүүлж, ашиглаж ирсэн байна (Зураг 3.7). Зурагт үзүүлсэн багшлах арга зүйн хөгжлийг дэмжих эдгээр нөөцийн агуулгын талаар энэхүү гарын авлагын өмнөх бүлгүүдэд хангалттай тайлбарлан өгүүлсэн. Иймд энэ хэсэгт тэдгээр нөөцийг ашиглан хичээлийн судалгаанд суурилсан багшлах шинэ арга зүйг багш бүрд үр өгөөжтэй, хүртээмжтэй байхаар түгээн дэлгэрүүлэх тогтолцоог хэрхэн ажиллуулах боломжийн талаар товч өгүүлье.

Хичээлийн судалгааны арга зүй, түүнийг түгээн дэлгэрүүлэх стратегийн өөрчлөлт

Юуны өмнө хичээлийн судалгааны Монгол дахь онцлог, шинэ арга зүйг түгээн дэлгэрүүлэх стратегийн өөрчлөлтийг цаашдын үйл ажиллагаандаа тооцох шаардлага байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Монгол дахь хичээлийн судалгаа нь дараах онцлогтой юм. Үүнд:

- Эрх зүйд суурилсан хичээлийн судалгааны менежмент
- Боловсролын стандарт, киррикилюмийн харилцан хамаарлын талаар хийсэн үндсэн шийдэл
- Сургалтын технологи буюу арга зүйн зарчмын талаар хийсэн шийдэл, багш нараас түүнийг хүлээн зөвшөөрсөн явдал
- Багшийн ажлын байрны тодорхойлолт дахь үндсэн чиг үүрэгт хичээлийн судалгааны үе шатуудын баталгаажсан байдал
- Математик, байгалийн ухаанаас бусад хичээлд хэрэглэх оролдлого
- Тухайн сургуулийн мэргэжлийн багшийн тооноос хамаарахгүйгээр хичээлийн судалгааг хэрэгжүүлж буй байдал
- Сургууль, багш нарын итгэл найдвар, хичээл зүтгэл гэх мэт

Арга зүйн шинэчлэлийг түгээн дэлгэрүүлэх стратегид дараах өөрчлөлт хийвэл зохилтой Үүнд:

1. ЖАЙКА-ийн болон бусад төсөл, хөтөлбөрийн шинэ арга зүйг түгээн дэлгэрүүлэх менежмент нь ихэвчлэн нийлүүлэлтэд суурилдаг байсан бол цаашидзохих бэлтгэлийг хангаж, сургууль, багш нарын эрэлт хэрэгцээнд суурилсан түгээн дэлгэрүүлэлтийн стратегит үе шаттайшилжүүлэх нь зүйтэй.
2. Багш шинэ арга зүйд суралцаж, түүнийгээ бүтээлчээр хэрэглэх нь суралцагчид эзэмшихүйн зүй тогтлын дагуу шинэ мэдлэг бүтээж, түүнийгээ хэрэглэх чадварт суралцахтай агаар нэгэн билээ. Иймд багшийн арга зүйг шинэчлэх менежментийг багшлах үйлд суралцахуйг эзэмшихүйн зүй тогтолд нийцүүлэх шаардлага байна. Өнөөдрийн байдлаар багш нарт зориулсан сургалт эзэмшихүйн зүй тогтлын эхний үе шат болох үйлийн баримжааг ялган таних үе шатаар үндсэндээ хязгаарлагдаж байна. Харин түүнийгээ эзэмших, үнэлж сайжруулах үе шатыг хичээлийн судалгааны менежментээр хэрэгжүүлэх бололцоотой. Одоо хүчин төгөлдөр мөрдөж буй эрх зүйн зохицуулалтаар энэ бололцоо хангагдсан байгаа.

Багшлах арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх менежментийн сайжруулалт

Улмаар хичээлийн судалгааны арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцооны менежментийг багш нарын сонирхол, хэрэгцээнд нийцтэй, үр ашигтай, үр өгөөжтэй, тогтвортой ажилладаг болгон сайжруулахын тулд менежментийн функц бүрээр дараах арга хэмжээг авах шаардлага байна. Үүнд:



Зураг 3.4. Багшлах арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрцүлэх ашиглах нөөцүүд



Хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах чиглэлд хийх

- Багш нарын мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр, түүний хэрэгжилтэд
- Багш нарын мэргэжил дээшлүүлэх журам болон түүний хэрэгжилт
- Мэргэжил дээшлүүлэх зардлын төсөв, зарцуулалт, зориулалт
- Стандарт, кирриkyолим, багшлахуйтай холбоотой хийгдсэн арга зүйн болон эрх зүйн шийдэл, тэдгээрийг баталгаажуулсан шийдвэрүүд
- Багшилж буй хүний нөөцийн нас, хүйс, мэргэжил, туршлага, мэргэжлийн ур чадварын динамик (сургуулийн бүтэц, хэмжээ, байршлаар)
- Багш нарын мэргэжил дээшлүүлэх эрэлт, хэрэгцээ
- Сургуулийн захиргааны болон мэргэжлийн удирдах ажилтны орон тоо, чиг үүрэг, ажлын ачаалал, эрх мэдлийн хуваарилалт
- Сургуулийн өнөөгийн зураглал
- Боловсролын газрын статус, харьяалал, чиг үүрэг, хариуцлага, орон тоо, мэргэжил дээшлүүлэхэд зарцуулж буй зардал
- Арга зүйн чиглэлийн хөтөлбөр, төслүүдийн зохицуулалт, хэрэгжилт г.м.

Бодлого, төлөвлөлтийн чиглэлээр

- Сургуулийн зураглалыг оновчтой болгох
- Мэргэжил дээшлүүлэх байгууллага, албан тушаалтнуудын орон тоо, ажлын чиг үүрэг, хариуцлага, эрх мэдлийн хуваарилалтыг оновчтой болгох

- Стандарт, киррикулим, багшлахуйтай холбоотой арга зүйн болон эрх зүйн шийдэл, шийдвэрийг үгүйсгэхгүйгээр улам сайжруулах арга замыг сонгох
- Хичээлийн судалгааг багшийн арга зүйн хөгжлийн хангах үндсэн арга гэж үзэж, түүнийг дэмжих чиглэлээр сургалтын менежментийг зохион байгуулалтын бүх түвшнийг шинэчлэн зохион байгуулах
- Боловсролын чанарын үнэлгээний шинэ тогтолцоог яаралтай бүрдүүлэх
- Мэргэжил дээшлүүлэх нийлүүлэлтэд суурилсан хандлагаас эрэлтэд суурилсан хандлагад шилжих
- Сургуулийн санаачилга, гишүүнчлэлд тулгуурласан нээлттэй сүлжээг дэмжих үндэсний, орон нутгийн тогтвортой бүтэц, тэдгээрийн чиг үүрэг, хариуцлага, хамтын ажиллагааны арга механизм бүхий тогтолцоо бүрдүүлэх
- Сургуулийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаа тогтвортой явагдахад шаардлагатай төсөв, санхүүгийн эх үүсвэрийг зөвшөөрч баталсан бодлого, шийдвэрийг холбогдох яамдаас хамтран гаргаж хэрэгжүүлэх
- Төрийн байгууллагын хуулиар олгогдсон зарим чиг үүргийг ТББ-д гэрээлэн шилжүүлж, төрийн ачааллыг бууруулахын зэрэгцээ ТББ-ыг чадавхжуулах

Хэрэгжилтийн зохицуулалтын чиглэлээр

- Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын хүрээлэн, багш бэлтгэдэг их, дээд сургууль, аймаг, нийслэлийн Боловсролын газрын бүх мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод хичээлийн судалгааны чиглэлээр өөрчлөлт оруулж, энэ чиглэлээр мэргэшүүлэх, тэдний ажлын уялдаа холбоог сайжруулах
- Боловсролын бүх түвшний байгууллагын мэргэжил дээшлүүлэх төсөв, санхүүгийн эрх мэдлийн хуваарилалт, хяналтыг оновчтой болгох
- Сургалтын хэрэглэгдэхүүн, багшид зориулсан гарын авлага, цахим програмуудад тавигдах шаардлагад хичээлийн судалгааны шаардлагуудыг үндсэн шалгуур болгон оруулах
- Боловсролын газрын чадавхийг нэмэгдүүлэх

Хичээлийн судалгаанд суурилсан багшлах арга зүйн шинэчлэлийг түгээн дэлгэрүүлж, боловсролын чанарыг бодитоор дээшлүүлэхэд энэ чиглэлээр үндсэн чиг үүрэг хүлээсэн төрийн байгууллагуудын хариуцлага, чадавх, шийдвэрлэх үүрэгтэй. Түүнээс гадна төрийн бус институтчилэгдсэн байгууллагуудын оруулах хувь нэмэр ч их ба багшлах шинэ арга зүйг түгээн дэлгэрүүлэх арга хэлбэр нь ч олон хувилбартай байх боломжтой (Хүснэгт 3.4).

Аливаа санал санаачилга, үйл ажиллагааг институтчилэхэд дараах зайлшгүй нөхцөлүүд хангагдсан байх шаардлагатай байдаг. Тухайлбал,

- Үйл ажиллагааны хэрэгцээ зорилго, зорилт нь тухайн үйл ажиллагааг агуулсан тогтолцооныхоо бие даасан бүрэлдэхүүн хэсэг болох нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн байх
- Тодорхой чиг үүрэгтэй, эрх зүйн статустай бие даасан бүтэц, орон тоотой, тогтвортой санхүүжилтийн эх үүсвэртэй байгууллага буюу ажлын байр болон хэлбэржсэн байх
- Тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий удирдлага, зохион байгуулалтын олон түвшинт бүтэц, сүлжээтэй болсон байх
- Хүний нөөцийн чадавхитай болсон байх гэх мэт.

Өнөөдөр багшлах арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг бие даасан тогтолцоо болгон институтчилэх үндсэн нөхцөлүүд хангагдаад байна.

Тухайлбал, багшлах арга зүйн хөгжлийн асуудлаар бодлогын, хяналт-шинжилгээ, үнэлгээний, эрдэм судлалын, мэргэжил арга зүйн, сургалтын ажил эрхлэх чиг үүрэгтэй үндэсний, орон нутгийн түвшинд төрийн статустай байгууллагууд ажиллаж байна. Ялангуяа, 2012 онд шинээр байгуулагдсан БМДИ багшийн хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг хүлээж, энэ үйлсэд чухал хувь нэмэр оруулах учиртай.

Хүснэгт 3.4. Түгээн дэлгэрүүлэх бүтэц, арга хэлбэр

Байгууллагын статус	Зох/бай-ын түвшин	Удирдлага, зохион байгуулалтын бүтэц	Арга хэлбэр
Төрийн институтчлагдсан бүтэц	Үндэсний	<ul style="list-style-type: none"> Улсын их хурал Засгийн газар БШУЯ БМДИ Боловсролын хүрээлэн АББТ Их, дээд сургуулиуд Мэргэжлийн хяналтын байгууллага Олон улсын төрөлжсөн байгууллага 	<ul style="list-style-type: none"> Сургалтууд Гарын авлага, ном Вейбсайт Форум Гадаад, дотоодын туршлага солилцох аялал Төсөл, хөтөлбөр Сонин хэвлэл Ухуулга сурталчилгаа
	Орон нутгийн	<ul style="list-style-type: none"> ЗДТГ Аймаг, нийслэлийн БГ 	
	Сургуулийн	<ul style="list-style-type: none"> Сургуулиуд 	
Төрийн бус институтчлагдсан бүтэц	Бүх түвшний	<ul style="list-style-type: none"> Гадаад дотоодын ТББ-ууд Нийгэмлэг Холбоод Сүлжээнүүд Хувийн компани Хөгжлийн төлөө түншлэгчид 	

Сургуулийн сургалтын менежментэд хичээлийн судалгааг эрх зүйн хувьд институтчилсан энэ боломжийг бүрэн ашиглах нь түгээн дэлгэрүүлэх менежментийн амин сүнс нь гэдгийг хүмүүс ухаарах нь чухал юм.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газартай хамтран ажилладаг олон улсын төрөлжсөн болон гадаад улсын Засгийн газрын болон ТББ-уудтай үр дүнтэй хамтын ажиллагаа явуулж, багшлах шинэ арга зүйг түгээн дэлгэрүүлэх хийгээд сургалтын технологид шинэ менежмент нэвтрүүлэхэд техникийн болон санхүүгийн туслалцаа авч байгууллага болон хүний нөөцийн чадавхийг эрс нэмэгдүүлэх таатай боломжуудыг бүрэн дүүрэн ашиглах шаардлагатай.

Багшлах арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтвортой тогтолцоо төлөвшүүлэхэд харьцангуй хоцрогдож байгаа нэг асуудал бол Монгол улс дахь төрийн бус статустай институтчилэгдсэн бүтцүүдийн бүтээлч оролцоог хангах, тэдэнтэй хамтран ажиллах ажиллагаа сул байгаа явдал юм. Ялангуяа, боловсролын салбар дахь мэргэжлийн холбоод, нийгэмлэгийн ажиллагаа хөгжиж, төлөвшиж чадаагүй байгааг тал талаасаа анхаарах шаардлагатай.

Багшлах арга зүйн шинэчлэлийг түгээн дэлгэрүүлэх чиг үүрэгтэй бүх түвшний аль ч байгууллага үйл ажиллагаагаа Хүснэгт 3.4-д үзүүлсэн арга хэлбэрийг ашиглан явуулах боломжтой. Эдгээр арга хэрэгслээс хичээлийн судалгаагаар цаг хугацааны тодорхой давтамжтайгаар Үндэсний форум, хурал зохион байгуулах, тасралтгүй ажиллах үндэсний веб сайт ажиллуулах явдал нь олон улсад шинэ арга зүйг түгээн дэлгэрүүлэх үр өгөөжтэй арга хэлбэр болж байгааг анхааралдаа авах нь зүйтэй.

IV. ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААГ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ЗАРИМ УЛС ОРНЫ ТҮРШЛАГА

4.1. Япон дахь багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт ба хичээлийн судалгаа

Тус улсад 10815 бага, дунд, ахлах сургуульд 3 558 166 сурагч сурч байна. Ерөнхий боловсрол (бага: 6 жил, бүрэн бус дунд: 3 жил) эзэмшилтийн хувь 99.96, ахлах сургуулийн анги дэвшилтийн хувь 98, ахлах сургууль төгсөгчдөөс их дээд сургууль, коллеж болон оройн дээд сургууль, 2010 оны байдлаар Япон Улсын 22 мянган бага сургуульд 6 993 376 сурагч, мэргэжлийн сургуулиудад дэвшин суралцагчдын хувь 79.7 хувьд тус тус хүрчээ²⁹.

2009 оны “Суралцах чадварын үнэлгээний олон улсын судалгаа (PISA: Programme for International Student Assessment)”-аас үзвэл судалгаанд хамрагдсан 65 улс орон, бүсээс, Япон Улсын суралцагчид нь уншиж ойлгох ерөнхий чадвараар 8, математикт тайлагдсан байдлаар 9, Шинжлэх ухаанд тайлагдсан байдлаар 5 дугаар байрт тус тус оржээ. Мөн 2011онд явагдсан “Олон улсын Математик, Байгалийн ухааны боловсролын чиг хандлагын судалгаа (Trends in International Mathematics and Science Study 2011)”-наас үзэхэд, 4-р ангийн Математикаар 50 орноос 5, 8-р ангийн Математикаар 42 орноос 5, 4-р ангийн Байгалийн ухаанаар 50 орноос 4, 8-р ангийн Байгалийн ухаанаар 42 орноос 4-р байрт тус тус бичигдсэн байна.

Өмнөх жилүүдийн PISA-гийн дүнтэй харьцуулахад Япон хүүхдүүдийн суралцах чадварын үзүүлэлт буурах хандлагатай байгаа боловч тэдний уншиж бичих чадварт үзүүлж буй өрхийн санхүү болон сургалтын орчны ялгаатай байдлын нөлөөлөл бусад оронтой харьцуулахад бага байгаа нь Японы боловсролын тогтолцоо нь хүүхдүүддээ суралцах тэгш боломжийг харьцангуй сайн бүрдүүлжээ хэмээн үзэхээр байна.

Японы боловсролын салбарын үйл ажиллагааны түшиг тулгуур, амжилтын гол хүчин зүйл нь багш нар юм. Өнөөдөр бага сургуульд 419 776, дунд сургуульд 250 899 багш ажиллаж байна. 1872-1947 онд Японд багш бэлтгэх үйл ажиллагаа “Шихан” буюу багшийн сургуульд төвлөрч байжээ. Гэхдээ, 1949 оноос багш бэлтгэх мэргэжлийн их дээд сургуулийн зэрэгцээ 4 жилийн сургалттай ердийн их дээд сургууль төгсөгчдөд багшлах эрх олгох болсноор багшлах эрх авагчдын тоо өссөн боловч багшлах мэдлэг чадварыг хангалттай түвшинд эзэмшээгүй багш нар ч гарах болсон.

Багш болсныхоо дараа ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдэж байгаа өнөө үед Японы багш нарын ур чадварын хөгжилд хичээлийн судалгаа нэн чухал үүрэг гүйцэтгэж байна. Япон улсад хичээлийн судалгаа нь дараах арга хэлбэрээр хэрэгжиж байна.

Бие даасан үйл ажиллагаа болох хичээлийн судалгаа

1950-1960 оны үед ижил хичээл (судлагдахуун) заадаг болон хүсэл сонирхлоороо нэгдсэн багш нар хамтран ажлын бус цагаар бие даасан үйл ажиллагаа явуулах зорилгоор гишүүний хандив цуглуулж, хувийн хэвшлийн боловсролын судалгаа шинжилгээний олон төрлийн байгууллагууд байгуулан ажиллах болжээ. Тухайлбал, сурагчдад Япон хэлний сайн боловсрол олгох судалгаа хийх зорилгоор байгуулагдсан “Боловсрол судлал дахь Япон хэлний ажлын хэсэг”, Токио хотын хэд хэдэн сургуулийн багш нар шинэлэг туршилтын материал боловсруулах, хэлэлцүүлэг зохион байгуулах зорилгоор байгуулагдсан “Байгалийн ухааны боловсролын судалгааны зөвлөгөөн” (хожим нь “Үндэсний хэмжээний шинжлэх ухааны боловсролын судалгааны зөвлөгөөн” болж өргөжсөн), асуудал шийдвэрлэхэд сургах замаар хувь хүний бодгаль шинжийг тодотгох сургалтын зорилготой “Нийгмийн ухаанд тууштай зүтгэгчдийн зөвлөгөөн” зэргийг дурдаж болох юм.

Мөн 1962 онд “Үндэсний хэмжээний хичээлийн судалгааны зөвлөгөөн”, 1964 онд “Японы боловсролын арга зүйн эрдмийн зөвлөл (National Association for the Study of Educational Methods)” зэрэг байгууллагууд үүсгэн байгуулагдаж, боловсролын судалгаа шинжилгээний байгууллагуудын туршлага солилцоо, судалгааны хамтын ажиллагааны өнөөгийн тогтолцоог бий болгоход тодорхой хувь нэмэр оруулах болжээ.

²⁹ Япон Улсын БШУЯ-ны статистикийн тайлан, 2011 оны хэвлэл

Дэлхийн 2-р дайны дараа (1945 он) ардчилсан тогтолцоонд шилжсэн Япон Улсад боловсролын стандартыг тэр чигээр нь хүлээн авах бус, “Юуг яаж заах вэ?” гэдгээ сургуулийн түвшинд сайтар тунгаан төлөвлөж, сургалтын материалыг бие даан боловсруулах, боловсролын стандарт, сурах бичигт шүүмжлэлтэй хандан судлах боломж нэмэгдсэн. Дээрх хувийн хэвшлийн боловсролын судалгаа шинжилгээний байгууллагууд ийм л зорилгын үндсэн дээр байгуулагдсан байна.


Эдгээр байгууллагын бүх гишүүд боловсролыг шинэчлэх хүсэл зорилгоор хичээлийн судалгаа зохион байгуулж, хичээл сургалтын шинэ материал боловсруулах, дэвшилтэт арга зүйгээ хуваалцах зэргээр хамтран ажиллах болсон. Гэхдээ, Япон улсад аливаа шинэчлэлийн гол зарчим болсон уг зүйлийг хэлбэр талаас нь бус, мөн чанараас нь ханддаг “өвсний үндэс” хэмээн арга барил, хандлагын түвшиндэх боловсролыг шинэчлэхэд хувь нэмэр оруулах утга агуулга нь бүдгэрч, эдүгээ хувийн хэвшлийн боловсролын судалгаа шинжилгээний байгууллагууд нь залуу багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд илүүтэй анхаарах болжээ.

Сургуулийн цйл ажиллагаа болох хичээлийн судалгаа

2006 онд шинэчлэгдсэн Боловсролын тухай хуулийн 9-р зүйлд “ЕБС-ийн багш нь хуулиар тогтоосон өөрийн эрхэм үүргийг бат ухамсарлаж, цаг ямагт сургалт судалгаанд шамдан, өөрийн үүрэг хариуцлагаа биелүүлэхэд анхаарч ажиллавал зохино” гэсэн заалт нэмж оруулсан байдаг.

Мөн Боловсролын тусгай ажилтны тухай хуулийн 21-р зүйлд “Боловсролын ажилтан нь өөрийн үүрэг хариуцлагыг биелүүлэхийн тулд цаг ямагт сургалт судалгаанд шамдан ажиллавал зохино” гэжээ. Түүнчлэн, нийгмийн хөгжилтэй уялдан багшид тавих мэргэжлийн ур чадвар, суралцагч болон эцэг эхийн үүрэг хариуцлага улам бүр нэмэгдсээр байна. Багш нараас сургалт судалгааны ажилд улам илүү оролцохыг шаардах болсон гэж болно.

Энэхүү “Тасралтгүй үргэлжлэх судалгаа” болгож, сургууль бүр тодорхой сэдэв сонгон “Сургуульд суурилсан хичээлийн судалгаа”-г зохион байгуулж байна (Хүснэгт 4.1). Сургуульд суурилсан хичээлийн судалгаа хийхийн өмнө, сургуулийнхаа хичээл сургалтын зорилт, сурагчдын төлөв байдалд нийцүүлэн судалгааны сэдвээ тодорхойлдог(Бүдүүвч 4.1). Тухайн сургууль сурагчдаа хэрхэн хөгжүүлэх гэж байгаагаа тодорхойлон, судалгааны таамаглал дэвшүүлж, хичээлүүд дээр туршиж үзэх байдлаар ажиллана. Нэг сэдвээр 2-3 жилийн турш судалгаа хийж, хүүхдүүдэд гарч буй өөрчлөлтийг ажиглах, асуулга судалгаа авах зэргээр үр дүнг тооцдог.



Бүдүүвч 4.1. Сургуульд суурилсан хичээлийн судалгаа хэрэгжүүлэх үе шатууд

Хүснэгт 4.1. Судалгааны сэдвийн жишээ

	Фүчюү 4-р бага сургууль
Хичээл сургалтын зорилт	“Суралцахуйн баясгалан, Сурч мэдэхийн давуу тал, Эелдэг зан чанар”
Судалгааны сэдвээ сонгох	“Харилцааны чадвар эзэмшүүлэн, санаа бодлоо харилцан илэрхийлэх чадвартай хүүхэд” болгон төлөвшүүлье.
Зөв төлөвшсөн хүүхэд ямар байх ёстойг тодорхойлно	1,2-р анги: Бусдыг хүлээцтэй сонсон, хэлэх гэсэн зүйлээ хэлж чаддаг хүүхэд 3,4-р анги: Бусдыг хүлээцтэй сонсон, бодол санаагаа хэлж чаддаг хүүхэд 5,6-р анги: Бусдыг хүлээцтэй сонсон, тунгаан бодож чаддаг хүүхэд
Судалгааны таамаглалаа дэвшүүлнэ	Багш хүүхдийнхээ “Харилцааны чадварыг хөгжүүлэх”-д чиглэсэн ажлаа өдөр бүр давтан хийлгэдэг. Ингэснээр, хүүхдийн харилцааны чадвар (ярих, сонсох) хөгжинө.
Судалгааны агуулга (1,2-р ангийн жишээ)	<ul style="list-style-type: none"> • Саналаа бичихэд хялбар ажлын хуудас ашиглах • Багш өөрөө “Сайн сонсох арга”-ын үлгэр жишээ байх • 3-4 хүүхдийг нэг баг болгон харилцан ярилцах цаг өгөх.

	Тама 3-р бага сургууль
Хичээл сургалтын зорилт	Ухаалаг, Зөв, Эрч хүчтэй
Судалгааны сэдвээ сонгох	Багш болон сурагчидтай эелдэг дотно харилцаж, идэвхи чармайлттай суралцдаг хүүхэд болгон хөгжүүлэх (Байгалийн ухаан) - Асуудлыг шийдвэрлэж сургах
Зөв төлөвшсөн хүүхэд ямар байх ёстойг тодорхойлно	“Ойлголт авах”, “Таамаглах”, “Бататгах”, “Дүгнэх” бүх үе шатуудад бага, дунд, ахлах ангийн хүүхэд тус бүрийг хэрхэн хөгжүүлэхээ тодорхойлох.
Судалгааны таамаглалаа дэвшүүлнэ	Байгалийн ухааны хичээлээр асуудлыг шийдвэрлэж сургах ажлыг тасралтгүй, төлөвлөгөөтэй зохион байгуулснаар, урам зоригтой суралцдаг хүүхэд болгон хөгжүүлж чадна.
Судалгааны агуулга (1,2-р ангийн жишээ)	<ul style="list-style-type: none"> Хүүхдийн “Илрүүлэх”, “Харьцуулах”, “Жиших” зэрэг үйл ажиллагааг оруулах. “Ойлголт авах”, “Бататгах”, “Дүгнэх” гэсэн дарааллын дагуу хичээлийг явуулж, асуудал шийдвэрлэх чадварыг эзэмшүүлэх.

Хүснэгт 4.2. Сургуульд суурилсан хичээлийн судалгаа хийх график, төлөвлөгөөний жишээ

• Эхний жил

• 2 дахь жил

4	5	6	7	8	9	10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	1	2	3										
Багш нарын хурал (Тухайн жилд хийх судалгааны чиглэлийг судлах)	Багш нарын хурал (Тухайн жилд хийх судалгааны чиглэлээ судлах)	Багш нарын хурал (Бүх судалгааны дэд тэнхимүүд судалгааг хичээлийн төлөвлөгөөг гаргах)	Судалгааг хичээл	Зуны амралт	Бага ангиудын судалгааны дэд тэнхим	Судалгааг хичээл	Дунд ангиудын судалгааны дэд тэнхим	Судалгааг хичээл	Ахлах ангиудын судалгааны дэд тэнхим	Судалгааг хичээл	Багш нарын хурал (Судалгааны илтгэл тайлангийн сэтгүүл дэх агуулгыг тодорхойлох)	Багш нарын хурал (Бүх тэнхимийн хурлын үр дүн, тулгамдсан асуудал)	Багш нарын хурал, Дэд тэнхимийн хурал (Судалгааны илтгэл тайлангийн сэтгүүл дэх агуулгыг тодорхойлох)	Багш нарын хурал (Тухайн жилийн үр дүн, тулгамдсан асуудал болон дараа жилийн сургуульд суурилсан хичээлийн судалгааны чиглэлийг судлах)	Судалгааны нэгдсэн хурал (Дараа жилийн сургуульд суурилсан хичээлийн судалгааны чиглэлийг судлах)	Багш нарын хурал (Тухайн жилд хийх судалгааны чиглэлийг судлах, бүх дэд тэнхимийн судалгааг хичээлийн төлөвлөгөөг батлах)	Судалгааг хичээл	Багш нарын хурал (Судалгааны илтгэл тайлангийн сэтгүүл дэх агуулгыг тодорхойлох)	Дунд ангиудын судалгааны дэд тэнхим	Судалгааг хичээл	Багш нарын хурал (Дэд тэнхим, судалгааны илтгэлийн хуралд бэлтгэх)	Бага ангиудын судалгааны дэд тэнхим	Судалгааг хичээл	Ахлах ангиудын судалгааны дэд тэнхим	Судалгааг хичээл	Судалгааны илтгэлийн хуралд бэлтгэх	Ахлах ангиудын судалгааны дэд тэнхим	Судалгааг хичээл	Багш нарын хурал (судалгааны илтгэлийн хуралд зориулсан хичээлийн хөтөлбөрийг судлах, Судалгааны илтгэл тайлангийн сэтгүүл дэх агуулгыг тодорхойлох)	Бүх тэнхимийн хурлын үр дүн, тулгамдсан асуудал	Судалгааны илтгэлийн хурал	Багш нарын хурал (Тухайн жилийн үр дүн, тулгамдсан асуудал болон дараа жилийн сургуульд суурилсан хичээлийн судалгааны чиглэлийг судлах)	Судалгааны нэгдсэн хурал (Дараа жилийн сургуульд суурилсан хичээлийн судалгааны чиглэлийг судлах)

ВШУЯ-ны вебсайт: http://www.mext.go.jp/a_menu/shotou/kenshu/1244827.htm

Сургуульд суурилсан хичээлийн судалгааг хийхдээ, эхлээд энэ ажиллагааг гүйцэтгэх бүтцүүд бий болгож, сургууль дотроо зохион байгуулалтад орох шаардлагатай. Бага сургуулиудад боловсролын шатлалаар 1-2-р анги хариуцах “Бага ангийн салбар комисс”, 3-4-р анги хариуцах “Дунд ангийн салбар комисс”, 5-6-р анги хариуцах “Ахлах ангийн салбар комисс” бүрдүүлж ажиллах явдал нийтлэг байдаг. Харин дунд, ахлах сургуулийн хувьд судлагдахуун бүрээр салбар комиссууд байгуулагддаг.

Багшийн ажил бол зөвхөн хичээл заах бус, дугуйлан секц удирдах, сурагчдын санаачилга, үйл ажиллагааг чиглүүлэх зэрэг олон төрлийн үйл ажиллагааг хамардаг. Багш нарт эдгээр үйл ажиллагаанд зарцуулах цаг боломж хязгаарлагдмал байдаг тул сургуульд суурилсан хичээлийн судалгааг сургуулийнхаа жилийн төлөвлөгөөнд урьдчилан тусгах хэрэгтэй болно. Долоо хоног бүрээр, тухайлбал долоо хоног бүрийн даваа гаригт хичээл тарсны дараа сургуульд суурилсан хичээлийн судалгааны салбар комисс хуралдана гэх мэтчилэн төлөвлөх шаардлагатай.



Зураг 4.1. Нээлттэй судалгааны өдөрлөг

Судалгааны сүүлийн жил тайлан гаргахын зэрэгцээ, нээлттэй судалгааны өдөрлөг зохион байгуулж, судалгааны үр дүнгээ нийтэд танилцуулдаг. Нээлттэй судалгааны өдөрлөгийн үеэр судалгаат хичээл болон судалгааны үр дүнгийн тухай илтгэх, судалгаа хийх явцад зөвлөхөөр ажилласан гадны сургагч багш (их дээд сургуулийн багш, сургуулийн туршлагатай захирал), боловсролын зөвлөлийн арга зүйч мэдээлэл өгөх, судалгааны сэдэвтэй холбоотой лекц унших зэрэг үйл ажиллагааг зохион байгуулна. Боловсролын чиглэлийн сонин, вебсайт зэрэгт өдөрлөг зохион байгуулагдах тухай мэдээ мэдээлэл нийтлэгдэх тул бусад сургуулиудаас ч олон тооны багш оролцдог байна. Ялангуяа, Боловсролын их сургуулийн харьяа сургууль дээр зохион байгуулагдах нээлттэй судалгааны өдөрлөгүүд нь тухайн бүс, орон нутгийн хичээл зохион байгуулалт, хичээлийн чанарыг дээшлүүлэхэд багагүй хувь нэмэр оруулдаг.

Сургуульд суурилсан хичээлийн судалгааг Японы Боловсрол, шинжлэх ухааны яамны “Сургуулиудын судалгааны үйл ажиллагааг дэмжих тогтолцоо” болон Үндэсний боловсролын бодлогын судалгааны хүрээлэн болон хот мужийн Боловсролын зөвлөл, дүүрэг хороо тосгодын Боловсролын зөвлөл зэрэг байгууллагуудын “Тодорхой сургуулиудад сургалт судалгаа хийх тогтолцоо”-гоор тус тус дамжуулан хөхүүлэн дэмжиж байдаг.

Нэг талаас, тус яамны “Сургуулиудын судалгааны үйл ажиллагааг дэмжих тогтолцоо” гэдэг нь, сургуулийн хичээл сургалтын үйл ажиллагаан дахь тулгамдсан асуудлууд, гэнэтийн шинж чанартай нийгмийн өөрчлөлт, хөгжилтэй уялдан сургуулийн сургалтын үйл ажиллагаанд тавигдсан янз бүрийн шаардлагад хариу өгөх зорилгоор сургуулиуд өөрийн гэсэн онцлогтой сургалт, судалгаа зохион байгуулах, хэрэгжүүлэхийг нь хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ ийм судалгаагаар дамжуулан хичээл сургалтын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх аргачлалыг боловсруулахад чиглэсэн тогтолцоо юм. Нөгөө талаас, Үндэсний боловсролын бодлогын судалгааны хүрээлэн болон хот муж, дүүрэг хороо тосгодын Боловсролын зөвлөлийн “Тодорхой сургуулиудад сургалт судалгаа хийх тогтолцоо” гэдэг нь тодорхой сэдвээр сургуульд суурилсан хичээлийн судалгаа хийх хүсэлтээ гаргасан сургуулиудад Боловсролын зөвлөл зэрэг холбогдох байгууллагын зүгээс мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, судалгааны төсөв зардал олгох зэрэг дэмжлэг үзүүлэх тогтолцоо юм.

Төрийн байгууллагуудын багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт дахь хичээлийн судалгаа

Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах Япон Улсын тогтолцоог доорхи хүснэгтэд үзүүлэв³⁰. Үүнээс төрийн байгууллагын зүгээс зохион байгуулдаг сургалтыг үндэсний ба орон нутгийн түвшний сургалт гэж хоёр ангилдаг байна. Үндэсний түвшний мэргэжил дээшлүүлэх сургалт нь гол төлөв багш ажлын ур чадварыг хөгжүүлэх шаардлагад нийцсэн сургалт байх бөгөөд ажилласан жилийнхээ хувьд дунд зэргийн туршлагатай багшийн сургалт болон захирал, хичээлийн эрхлэгчид зориулсан сургалтууд энд хамаарна. Эдгээр сургалтыг Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын төвөөс (National Center for Teacher’s Development) зохион байгуулдаг. Түүнчлэн орон нутгийн түвшний сургалт нь ч багшийн туршлага, ажилласан жилд нийцүүлсэн сургалтууд байдаг.

³⁰ Бусад сургалтын боломж болгож, багшлах эрхийг шинэчлэх тогтолцоо (2007 он), Ахисан түвшинд мэргэжлийн багш бэлтгэхэд чиглэсэн Багшлах ажилтны аспирантур (2007 он) г.м

Хүснэгт 4.3. Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах тогтолцоо

	1жил	5жил	10жил	15жил	20жил	25жил	30жил
Үндэсний түвшний сургалт	<ul style="list-style-type: none"> Бүх бүсэд сургуулийн хичээл сургалтад голлох үүрэгтэй захирал, хичээлийн эрхлэгч зэрэг багш ажилтанд зориулсан сургуулийн удирдлагын сургалт 						
			Ажилласан жилээрээ дунд зэргийн туршлагатай багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт		Захирал, хичээлийн эрхлэгчийн сургалт		
			Офисын ажилтны сургалт (бага, дунд,ахлах сургууль)				
			Гадаадын сургалт(3 ба 6 сараас доош)				
Хот мужийн Боловсролын зөвлөлийн сургалт	<ul style="list-style-type: none"> Нэн чухал тулгамдсан асуудлын талаар, орон нутгийн олон нийтийн байгууллагаас зохион байгуулах сургалт, сургагч багш болон төлөвлөлт хариуцсан чиглүүлэгч багш бэлтгэх сургалт 						
		<ul style="list-style-type: none"> Сургуулийн зохион байгуулалт, менежмент болон Япон хэлний чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн чиглүүлэгч багш бэлтгэх сургалт Хичээл сургалтын тулгамдсан асуудлаар явуулах сургалтын чиглүүлэгч багш нарын гадаад улс орон дахь хөтөлбөр (2 долоо хоног) 					
	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн олон нийтийн байгууллагын нийтийн ашгийн төлөө үйл ажиллагаа болгон итгэмжлэлээр зохион байгуулах сургалт 						
		Үйлдвэрлэлийн боловсролын чиглүүлэгч багш бэлтгэх сургалт					
Хот мужийн Боловсролын зөвлөлийн сургалт	<ul style="list-style-type: none"> Хуулинд заасан сургалт(Нийт багш хамрагдана) 						
	Шинэ залуу багш нарын сургалт		10 жил ажилласан багшийн сургалт				
	<ul style="list-style-type: none"> Багш ажилтны туршлагад нийцүүлсэн сургалт 						
		5жил ажилласан багшийн сургалт			20жил ажилласан багшийн сургалт		
	<ul style="list-style-type: none"> Ур чадварт нийцүүлсэн сургалт 						
			Сурагч хариуцсан арга зүйчдийн сургалт г.м				
					Ахлах багш нарын сургалт		
						Хичээлийн эрхлэгч, захирлын сургалт	
Хот мужийн Боловсролын зөвлөлийн сургалт	<ul style="list-style-type: none"> Урт хугацааны сургалт 						
			Хувийн хэвшилд зохион байгуулах урт хугацааны сургалт				
	<ul style="list-style-type: none"> Мэргэжлийн мэдлэг, сургалтын технологийн сургалт 						
Бусад		Судлагдахуун хариуцсан арга зүйч, сурагч хариуцсан арга зүйчдийн мэргэжлийн сургалт					
	<ul style="list-style-type: none"> Хот тосгон, дүүрэг хорооны Боловсролын зөвлөл, сургууль, хувийн сургалт 						
		Хот тосгон, дүүрэг, хорооны Боловсролын зөвлөлийн зохион байгуулах сургалт, Сургууль дээрхи сургалт,боловсролын судалгаа шинжилгээний байгууллагын зохион байгуулах сургалт,багшийн хувийн сургалт					

Шинэ залуу багш нарт зориулсан сургалтыг 1988 онд, 10 жил ажилласан багш нарт зориулсан сургалтыг 2003 онд тус тус хуулинд заагдсан сургалт гэж тогтоосон.

Шинэ залуу багш нарт зориулсан сургалт нь Боловсролын тусгай ажилтны хуулинд үндэслэсэн одоо ажиллаж буй багшид зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалт бөгөөд дотор нь сургуулиас гадуурх болон сургууль дээрх сургалт гэж хуваана.

Сургуулиас гадуурх сургалт нь жилд 25-аас дээш өдрөөр байх бөгөөд хот мужийн сургалтын төв, хот муж доторхи бүс тойрог дахь Боловсролын байгууллага, хот тосгодын Боловсролын зөвлөлөөс зохион байгуулна. Зуны амралтаар 3 хоног 4 өдрийн сургалтад өөр хотуудад очиж оролцох сургалт ч

бий. Сургуулийн захирал нь сургуулийн сургалтыг чиглүүлэгч багш нартай хамтран жилийн ажлын төлөвлөгөө боловсруулах үндсэн дээр долоо хоногт 10-аас дээш, жилд 300-аас дээш цагийн сургалтууд зохион байгуулна. Ахмад багшийн хичээлд ажиглалт хийх, шинэ залуу багшаар хичээл заалгах зэргээр хичээлийн судалгаа хийх ажил ч үүнд хамаардаг.

10 жил ажилласан багш нарт зориулсан сургалт ч сургуулиас гадуурх болон сургууль дээрх сургалтаас бүрдэнэ. Хот мужийн Сургалтын төв болон Боловсролын байгууллагад жилд 8-12 хоногийн хугацаанд киррикулимийн сургалт, ахуйн хүмүүжлийн сургалт, төрийн албан хаагчийн ур чадвар дээшлүүлэх сургалт гэх мэт сургуулиас гадуурх сургалтад хамрагдана. Киррикулимийн сургалтад хичээлийн судалгааг багтаана. Сургууль дээрх сургалт нь захирал болон чиглүүлэгч багшийн заавар зөвлөгөөгөөр төлөвлөгөө боловсруулж, орон нутгийн Боловсролын зөвлөлийн зөвшөөрлөөр зохион байгуулдаг сургууль дээрх 90 цагийн сургалт юм.

Их дээд сургууль дахь хичээлийн судалгаа

Японы их, дээд сургуульд хичээлийн судалгаа нь дараах хоёр чиглэлээр явагддаг. Үүнд:

Судалгааны чиглэлийн хичээлийн судалгаа

Японд хичээлийн судалгаа нь боловсрол судлалын судалгааны нэг объект гэж үздэг бөгөөд хичээлд хийсэн тоон, хөндлөнгийн, системийн шинжилгээний дүнг багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалтаас гадна, багш бэлтгэх дамжааны оюутны багшлах дадлагыг боловсронгуй болгох, багшлах дадлагын өмнөх болон дараах хичээлийг сайжруулах зэрэгт ашигладаг. Тухайлбал, багш бэлтгэдэг сургуулиудын харъяанд ажилладаг ЕБС-аас зохион байгуулдаг хичээлийн судалгаанд дадлагын оюутнууд оролцож, хичээлийн бэлтгэл судалгаа, хичээлийн ажиглалт, хэлэлцүүлэгт оролцдог.

Их дээд сургуулиар багш бэлтгэх цйл ажиллагаан дахь хичээлийн судалгаа

Японд зөвхөн багш бэлтгэх мэргэжлийн их дээд сургууль төдийгүй, улсын болон хувийн, олон нийтийн аль ч их дээд сургуулийн сургалтын төлөвлөгөөнд багшлах эрх авахад шаардлагатай кредиттэй хичээлүүдийг суулгаж өгсөн бол тэр сургууль багшлах боловсон хүчин бэлтгэх боломжтой болдог.

Урьд өмнө нь Японд “Багш хүн чин сэтгэлтэй, эрдэмтэй бол заах аргаа өөрөө бодож олох боломжтой” гэдэг хандлага хүчтэй байснаас, багш бэлтгэх их дээд сургуулиуд дидактикийн болон боловсролын арга зүйн судалгаанд төдийлөн хүч хөдөлмөр зарцуулдаггүй байжээ. Харин 1960-аад оноос судлагдахуун тус бүрээр боловсрол судлалыг хөгжүүлэх хөдөлгөөн эрчимжиж эхэлсэн байна. Судлагдахууны боловсрол судлал гэдгийг судлагдахууны мэргэжил (заах агуулга) ба багшийн мэргэжил (сургалтын арга зүй)-д тулгуурлан тодорхой асуудал буюу тохиолдлын судалгаа хийх өөрөөр хэлбэл, хичээлийн бэлтгэл судалгаа болон багшлах арга зүйн судалгааг хамтатган авч үздэг гэж ойлгож болно. Энэ судалгаанд хичээлийн судалгааны үзэл баримтлал агуулагддаг.

Багш бэлтгэх сургуульд судлагдахууны сургалтын арга зүйн хичээлээр оюутнууд ихэнхдээ багаар ажиллан хичээлийн хөтөлбөр боловсруулж, өөрсдөө сурагчийн дүрд тоглон туршилт хичээл явуулна. Хичээлийн дараа хэлэлцүүлэг зохион байгуулж, сайжруулах санал хэлэх зэргээр хичээлийн судалгааны аргад суралцдаг байна. Зарим тохиолдолд сургалтын ач холбогдол, боловсролын арга технологийн тухай хичээлүүдээр сайн багшийн заасан хичээлийн видео бичлэгийг үзэн “Сурагчдын алдаа”, “Үнэлгээ” зэрэг анхаарвал зохих асуудлуудаар хэлэлцүүлэг явуулан, дүн шинжилгээ хийдэг байна. Мөн, хичээлийн бэлтгэл судалгаа хийх, хичээлийн хөтөлбөр боловсруулах тухай ойлголтоо гүнзгийрүүлдэг.

4.2. Хичээлийн судалгааг түгээн дэлгэрүүлж буй Индонез улсын туршлага

Индонез улсын ерөнхий боловсролын тогтолцоо

Индонез улс нь 250 гаруй сая хүн амтай, тэдгээрийн 70 гаруй хувь нь Ява арал дээр амьдардаг. Тус улсад боловсролын асуудал хоёр яаманд хамаардаг. Сургуулиудын тал хувь нь Үндэсний Боловсролын Яам, тал нь Шашны Яаманд хамааралтай. Сургууль нь 6+3+3 гэсэн бүтэцтэй. Бүх нийтээрээ заавал сурах хугацаа нь 6 жил. Тухайн жилийн 7 сараас дараа жилийн 4 сар хүртэл хичээлийн жил үргэлжилдэг ба 2 улиралтай. Мацаг барьдаг долоо хоногт хичээллэдэггүй хэдий ч энэ нь тогтсон хугацаагүй.

2011 оны статистик мэдээгээр бага 147793 сургууль, 22274 дунд сургууль, 8899 ахлах сургуульд нийт 2,9 сая багш ажиллаж байна.

Индонез улсын хувьд суурь боловсролын чанар сул ялангуяа, багшийн чанар тун хангалтгүй байгаад анхаарал хандуулж, боловсролыг 2005-2009 онд хөгжүүлэх төлөвлөгөөнд энэ чиглэлд ахиц гаргахаар дараах шинэчлэлийг хийж байна. Үүнд:

- Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх
- Сургуулийг хөгжүүлэх
- Багшийг хөгжүүлэх

Хичээлийн судалгааны талаар боловсролын яамнаас баримталж буй бодлого, стратеги

Тус улсад боловсролын удирдлагын төвлөрлийг сааруулах бодлогыг хүрээнд сургалтын хөтөлбөрийг шинэчлэх үүрэг хариуцлагыг мужуудад хүлээлгэсэн нь мужуудын ард түмний зан заншил, соёлын ялгаатай байдлыг давхар тооцсон хэрэг ажээ. Харин сургуулийг шинэчлэх ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан шийдвэрлэж байгаа бол багшийн хөгжлийг “Хичээлийн судалгаа”-аар дамжуулан хангах стратеги барьж байна.

Хүүхэд сургах чадвар, мэргэжлийн мэдлэг чадвар, нийгмийн харилцааны чадвар, хувийн зан чадвар зэргийг багшийн цогц чадамжид багтаан үзэж, эдгээрцогц чадамжийг үнэлж, сертификатаар баталгаажуулан цалингийн нэмэгдэл олгодог ажээ.

Японы олон улсын хамтын ажиллагааны Жайка байгууллага 1998 оноос эхлэн Индонезийн боловсролын чанарыг дээшлүүлэх ялангуяа, байгалийн ухаан, математикийн боловсролын чанарыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байгаа аж.

Индонез улсад хичээлийн судалгааг хоёр төрлөөр хэрэгжүүлж байна.

- Судлагдахуунд суурилсан хичээлийн судалгаа
- Сургуульд суурилсан хичээлийн судалгаа

Судлагдахуунд суурилсан хичээлийн судалгаа нь хэд хэдэн сургуулийн ижил мэргэжлийн багш нар хамтарч хичээлийн судалгаа хийх (Математик, байгалийн ухаан)

Сургуульд суурилсан хичээлийн судалгаа нь тухайн нэг сургуулийн бүх мэргэжлийн багш нар хамтарч судалгаа хийх.

Үндэсний боловсролын яамнаас суурь боловсролын шинэчлэлд хичээлийн судалгааг гол арга хэрэгсэл гэж үзэж, түүнийг түгээн дэлгэрүүлэхдээ “дороосоо санаачилга гаргах нөхцөлд дэмжлэг үзүүлэх” стратеги гаргасан байна. Бүх сургуулийг хичээлийн судалгаа хий гэж шаарддаггүй ч хичээлийн судалгаанд хамрагдвал нэмэлт төсөв олгодог. Өөрөөр хэлбэл, хичээлийн судалгааг үр дүнтэй гэдгийг нь яам зөвшөөрч, дараах бодлогыг баримталдаг байна. Тухайлбал:

- Хичээлийн судалгааг албан шаардлагаар бус, үүсгэл санаачилга дээр нь суурилж хөгжүүлэх
- Сургуульд суурилсан хичээлийн судалгааг хөгжүүлэхэд түлхүү анхаарах
- 2013 оноос шинээр төгссөн багш нарыг тусгай сургалтад хамруулах

Хичээлд суурилсан хичээлийн судалгааг сургууль бүр математик, байгалийн ухааны хичээлээр заавал хийх үүрэгтэй бол сургуульд суурилсан хичээлийн судалгааг үүсгэл санаачилгаараа хийх эрх зүйн орчин бүрдсэн байна.

Хичээлийн судалгааг түгээн дэлгэрцүлэх тогтолцоо.

Үндэсний боловсролын яамнаас хичээлийн судалгааг түгээн дэлгэрүүлэхдээ дараах арга хэлбэрийг ашигладаг байна. Үүнд:

Тусгай вебсайт ажиллуулах www.lessonstudyindonesia.org

Үндэсний хэмжээний бага хурал зохион байгуулах

Хичээлийн судалгаатай холбоотой ном, гарын авлагаар хангах

Шинэ багш нарыг хамруулах “Танилцах хөтөлбөр” хэрэгжүүлэх

Сургалтууд зохион байгуулах

- *Захирлуудын сургалт.* Сургуулийн захирлуудын сургалтыг жилд нэг удаа хийж, бүх захирлыг хамруулдаг. Хичээлийн судалгаа хийх эсэх нь сургуулийн захирлын санаачилгаас шууд хамаарах бөгөөд захирлаас хичээлийн судалгааны үр дүнгийн 80 хувь хамаарна гэж үздэг.

- *Мэргэжлийн сургагч багш нарын сургалт.* Жилд дөрвөн удаа явагддаг. Төсөл хэрэгжиж байгаа сургуулиудаас математик, байгалийн ухаан тус бүр нэгээс доошгүй багш оролцдог.
- *Сайн дурын багш нарын сургалт.* Сар бүр хоёр удаа зохион байгуулдаг. Математик, байгалийн ухааны багш нар баг зохион байгуулж, сар бүр 2 удаа хичээлийн хэлэлцүүлэг хийдэг.
- *Үнэлгээний уулзалт.* Жилд 2 удаа хийдэг. Боловсролын бүх шатны байгууллагын төлөөлөл оролцож, хичээлийн судалгааны явцад үнэлгээ дүгнэлт өгдөг.
- *Түгээн дэлгэрцүлэх форум.* Жилд 2 удаа зохион байгуулдаг. Хичээлийн судалгааг бусад дүүрэгт сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилготой бөгөөд төсөл хэрэгжиж байгаа сургуулийн зэргэлдээ дүүргийн удирдлага, багш нар оролцдог.

Яамнаас их сургуулиудыг хичээлийн судалгааг амжилттай хэрэгжүүлэхэд бодлогын болон мэргэжлийн дэмжлэг үзүүлж, орон нутгийн боловсролын газруудад хичээлийн судалгаа зохион байгуулахад нь зориулж, харьцангуй бага хэмжээний нэмэгдэл төсвийг өгдөг. Харин боловсролын газрууд нь сургуулийн захиралд нь мэдэгдэж сургалтад хамрагдах багшийн хичээлийн цагийг нь зохицуулдаг ба сургуулиас нь өөр газар зохион байгуулагдах судалгаанд оролцох зардлыг нь санхүүжүүлдэг байна.

Хичээлийн судалгаа хийхэд голлон анхаардаг асуудлууд

Хичээлийн судалгаа хийхэд анхаардаг асуудал:

- Сургуульд нэмэлт ачаалал бий болгохгүй байх
- Аль болох хөрөнгө мөнгө бага зарах
- Багшид нэмэлт хөлс төлөхгүй байх
- Сурлагын амжилтыг ахиулах

Сургууль дээр хичээлийн судалгаа хийхдээ сургалтын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байхыг эрхэмлэдэг. Нэг сэдвийг тухайн ангид дахин заахгүйгээр өөр бүлэгт заадаг бол нэг бүлэгтэй ангийн тухайд дараагийн сэдвийг заахдаа өмнөх сэдвийг заахдаа гаргасан дутагдлыг гаргахгүй байхад анхаардаг. Жишээ нь, гурвалжин заахад гарсан алдааг дөрвөлжин заахдаа засаж болно гэсэн үг юм.

ЖАЙКА-аас энэ улсад төсөл хэрэгжүүлэхэд тохиолдсон хоёр гол бэрхшээл

- Багш нар хичээл заахдаа хүүхэд хэрхэн сурдагт анхаарал тавьдаггүй.
- Хүүхдийн сурч чадахгүй байгаад багш өөрийгөө буруутгадаггүй.

Хичээлийн судалгаан дахь орон нутгийн оролцоо

Баруун Ява мужийн Боловсролын газархичээлийн судалгааны асуудал 2001 оноос эхлэн яригдаж, Сумидан аймаг, 2008 оноос Караван аймаг хамрагдаж эхэлсэн. 2010 оноос БИС-тай хамтарч ажилласан. Мужийн боловсролын газраас хичээлийн судалгааны талаар тайлбарлан таниулах ажил хийхийн зэрэгцээ сургуулийн захирал, мэргэжилтнүүдэд жилд 2 удаа, багш нарт 20 удаа сургалт явуулжээ. Эдгээр үйл ажиллагаанд мужийн төсвөөс санхүүжилт хийдэг байна.

Баруун Ява мужийн Сумидан аймаг 166 сургуулийг 8 бүс болгон хичээлийн судалгааг хэрэгжүүлснээс 108 нь сургуульд суурилсан судалгаа хийжээ. Сургуульд суурилсан хичээлийн судалгааг сургуулиуд өөрсдийн санаачилгаар хэрэгжүүлдэг ба индонез хэл, түүх, нийгмийн ухаан зэрэг математик, байгалийн ухаанаас бусад мэргэжлийн багш нар хамрагддаг.

Харин судлагдахуун суурилсан хичээлийн судалгааг аймгийн Боловсролын газраас зохион байгуулдаг бөгөөд энэ судалгааг сургуулиуд заавал хийх үүрэгтэй. Судлагдахуунд суурилсан хичээлийн судалгааг тус аймгийн бүх сургууль хийхэд бэрхшээлтэй. Сургуулиуд аймгийн Боловсролын газраас гаргасан математик, байгалийн ухааны хичээлийн судалгааны нэгдсэн хуваарийн дагуу судалгаат хичээл зохион байгуулдаг. Тус аймгийн хувьд долоо хоногийн лхагва, бямба гарагт судалгаат хичээл байхаар график гаргаж, сургуулийн бусад үйл ажиллагааг зохицуулдаг ба Боловсролын газраас судалгаат хичээлийн хуваарийг Багшийн их сургууль руу явуулж, зөвлөгөө өгөх багшийг урьдаг. Энэ хуваарийн дагуу багш нар хичээлд ажиглалт хийж, хэлэлцүүлэгт оролцдог бол боловсролын газрын мэргэжилтнүүд хэрэгжилтэд хяналт тавьдаг.

Индонезийн хичээлийн судалгааны онцлог нь ажиглалт хийхдээ хүүхдүүд хэрхэн сурч байгааг ажиглаж, хичээлдээ анхаарахгүй хүүхэд байвал түүний шалтгааныг нь олох, хичээл дээр ийм хүүхэдтэй багш хэрхэн ажиллаж байгаа

харахад голлон анхаарч байгаа тул судалгаат хичээл бүрээр видео бичлэг хийдэг бөгөөд видео бичлэгийг яаж сайн хийх вэ гэдэгт онцгой анхаарч байна.

Хичээлийн судалгааг Боловсролын яамнаас гадна муж, аймгийн төсвөөс санхүүжүүлдэг нь сургуульд том дэмжлэг болдог аж. Тус аймгийн Боловсролын газарт 120 гаруй мэргэжилтэн ажилладгаас 16 нь хичээлийн судалгааны хэрэгжилтийг үндсэн ажилтайгаа хавсран ажиллаж, сургуулиудыг бүс бүсээр хариуцаж байгаа ч сургуульд бүрд хүрч чадахгүй бэрхшээл учирдаг.

Багш нар эхлээд хичээлээ үзүүлэх дургүй байсан бол одоо аль болох бусдад үзүүлснээр бусдаас зөвлөгөө авч, хичээлээ сайжруулах боломжтойг мэдэрсэн бөгөөд багш нар хичээлд бэлтгэхдээ хүүхдийг огт анхаардаггүй байсан бол одоо өөр болж байгаа явдал нь хичээлийн судалгааны багшид үзүүлж буй гол нөлөө гэж үзэж байна.

Хичээлийн судалгааг төлөвлөсний дагуу хэрэгжүүлдэггүй захирлууд байсаар байгаа бөгөөд аймгийн Боловсролын газрын даргыг ойр ойрхон сольж байгаа явдал нь хичээлийн судалгааг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулдаг.

Хичээлийн судалгаа-Багш бэлтгэх, багшийн мэргэжил дээшлүүлэх ажиллагаа

Нийт 330 их дээд сургуулиас 42 нь багш бэлтгэдэг бөгөөд тэдгээрийн 33 нь хичээлийн судалгааг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцдог. Математик, байгалийн ухааны багш бэлтгэх сургалтын мэргэжлийн зарим хичээлийн агуулгад хичээлийн судалгааг хэрэгжүүлж байгаа. Оюутанд хичээлийн судалгаагаар тусгайлан онолын хичээл ордоггүй ч тэд 4 жил сурахдаа 3 сарын хугацаатай хийдэг багшлах дадлагын үед хичээлийн судалгааны арга зүйд суралцдаг. Багш бэлтгэх сургуулийн багш нар өөрсдийн хичээлд хичээлийн судалгаа хийж эхэлсэн.

Яамнаас багшийг идэвхжүүлэх хөтөлбөр (INDUCTION PROGRAM) боловсруулан 2013 оноос хэрэгжүүлэхээр төлөвлөж, Боловсролын сайдын тушаал 2010 онд гарчээ.

Энэ хөтөлбөрт зөвхөн шинэ багшийг нэг жилийн хугацаатай сургалтад хамруулах аж. Хөгжсөн багш бусдыг сайн сургадаг гэсэн үзэл баримтлалыг үндэс болгосон.

Хичээлийн судалгааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд Бандун хотын Индонезийн Их сургууль их үүрэгтэй оролцсон байна. Тус сургууль ЖАЙКА-ийн төсөлд 1998 оноос хамрагдаж, туршилтын төслийг цөөн хэдхэн сургуулийн хүрээнд явуулж эхэлсэн бол ийм сургуулийн тоо одоо хэдэн зууд хүрээд байна. 2004 оноос математик, байгалийн ухааны багш нартай хамтран багшийн чанарыг сайжруулахад анхаарч ажилласан. Энэ ажлын үр дүнд гарын доорх материал бэлтгэн хичээлийн туршилт хийх арга зүйг боловсруулж, бага, дунд сургуулийн багш нар их дээд сургуулийн багш нартай хамтарч ажиллах боломжтойг харуулсан. Төслийн үйл ажиллагааг 2006 оноос Сумидан аймгийн хэмжээнд өргөжүүлснээр зөвхөн судалгаат хичээл төдийгүй бусад хичээлийн арга зүй ч сайжирсан үр дүнд гарсан байна. Ийнхүү Сумидан аймагт хэрэгжүүлсэн төсөл амжилттай болсон тул 2008 оноос Караван, Сураван, Пасаөрван гурван аймагт төсөл хэрэгжүүлсэн бөгөөд энэ амйгийн сургуулиуд Жайкагаас гадна өөр байгууллагаас дэмжлэг нэмж авчээ.

Хичээлийн судалгааг 2009 оноос багш бэлтгэдэг бусад сургуулиудад нэвтрүүлж эхэлсэн. 2010 онд тус төсөл баруун Явагийн 4 аймагт хэрэгжсэн. Ийнхүү хичээлийн судалгааг хэрэгжүүлсэн ажлын үр дүнд их сургууль, дунд сургуулийн багш нарын аль аль нь мэдээлэлтэй болоход тус болсон. Тухайлбал:

- Их сургуулийн багш нар бага, дунд сургуульд ямар ямар сургалтын хэрэглэгдэхүүн хэрэгтэй байгааг нь мэдэх боломжтой болсон.
- Бага, дунд сургуулийн багш нарын хувьд сургалтад хамрагдах боломжтой болсон.

Хичээлийн судалгааг хэрэгжүүлж байгаа Индонез Улсын туршлагаас харахад тухайн улсын нийгэм, соёл, нийтийн удирдлагын болон боловсролын салбарын контекст нэлээд ялгаатай учир хичээлийн судалгааны арга зүйг түгээн дэлгэрүүлэх менежмент ялгаатай байх нь ойлгомжтой.

Гэхдээ сургуулийн захирлын санаачилга, хүлээх үүрэг хариуцлагыг өндөржүүлж, үйл ажиллагаанд шаардагдах зардлыг сургуульд нэмж олгодог байдал нь манай сургуулиудад хэрэгжүүлж болохоор туршлага гэж үзэж болно. Учир нь 2008-2015 онд хэрэгжүүлэх “Багш бэлтгэх, багшийн мэргэжил дээшлүүлэх Үндэсний хөтөлбөр”-т хэрэгжиж амжаагүй байгаа 2

үйл ажиллагааны нэг нь сургууль бүрийн төсөвт багш нар ажлын байрандаа мэргэжил дээшлүүлэхэд нь зориулж сургуулийн төсөвт төсвийн тусгайлсан анги зүйлээр мэргэжил дээшлүүлэх зардлыг тусган төрөөс санхүүжүүлж байх заалтыг өнөөг хүртэл хэрэгжиж амжаагүй байгаа болно. Иймд Үндэсний хөтөлбөрийн энэ заалтыг хэрэгжүүлэхдээ сургалтын технологид хичээлийн судалгааг нэвтрүүлэх менежменттэй холбож шийдвэрлэх боломж байгаа юм.

ТОВЧИЛСОН ҮГ

АББТ	Албан бус боловсролын төв
АХБ	Азийн хөгжлийн банк
АС	Азийн сан
БМДИ	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт
БОБ	Байгал орны боловсрол
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БСХХ	Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөр
БСТ	Боловсрол, соёлын төв
БСГ	Боловсрол, соёлын газар
БХАН	Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг
ГЯ	Гэгээрлийн яам
ГХАН	Германы хамтын ажиллагааны нийгэмлэг
ДБ	Дэлхийн Банк
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЖАЙКА	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗАН	Заах аргын нэгдэл
ЗГ	Засгийн газар
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МУВИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
МДССТ	Мэргэжлийн дидактикийн сургалт судалгааны төв
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
READ	Хөдөөгийн боловсрол
МННХ	Монголын нээлттэй нийгмийн хүрээлэн
ТХБ	Тогтвортой хөгжлийн боловсрол
ТББ	Төрийн бус байгууллага
ХАС	Хүн амын сан
ХС	Хүүхдийн сан
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ЮНЕСКО	Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага
ЮНИСЕФ	Хүүхдийн сан

НОМ ЗҮЙ

1. Сургалтын технологийн шинэчлэл. ГЯ, УБ, 1999,
2. Хичээл хоорондын холбоо-Багш нарын хамтын ажиллагаа ГЯ, УБ, 1999,
3. Сургалтын арга зүй ГЯ, УБ, 1999
4. Чанартай боловсрол-Хөгжлийн баталгаа, Үндэсний форумын илтгэлүүд, МННХ, УБ, 2001
5. Сургалтын менежмент, ГЯ, УБ, 2001
6. Сургууль соёлын хөгжлийн шинэ чиг хандлага: Киррикулим хөгжлийн онол, арга зүй. МУИС, УБ, 2002
7. Багш боловсролын хөгжлийн шинэ чиг хандлага: Стандарт, киррикулимийн онол арга зүй. МУИС, УБ, 2003
8. Монголын бага, дунд боловсролын киррикулим ба стандартыг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал. Боловсролын салбартай холбоотой тогтоол, тушаалын эмхэтгэл, 2002, №10
9. Бага, дунд боловсролын стандартын ерөнхий зөвлөмж. УБ, 2003
10. Тогтвортой хөгжлийн боловсрол. УБ, 2008
11. Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх бодлого, төлөвлөлт, арга зам. БСШУЯ, УБ, 2008
12. Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 1, (2, 3, 4, 5, 6, 8, 9, 10, 11) ба шилжилтийн 7 дугаар ангийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, зөвлөмж: Хичээлүүдээр. БСШУЯ, УБ 2008 (2009, 2010, 2011, 2012 он)
13. Зургаан настай хүүхдийн сурах, сургах арга зүй. БСШУЯ, УБ, 2008
14. Зургаан настай суралцагч. БСШУЯ, УБ, 2008
15. Сурлагын амжилтын үнэлгээ. БСШУЯ, УБ, 2008
16. БСШУЯ-ны жил бүрийн үйл ажиллагааны тайлангууд, УБ, (1998-2012 он)
17. Т.Ганбаатар болон бусад, Хичээлийн судалгааны арга зүйн үндэс. БШУЯ, ЖАЙКА, УБ, 2013
18. Ө.Цэндсүрэн болон бусад, Хичээлийн судалгаан дахь удирдлагын үүрэг, оролцоо. БШУЯ, ЖАЙКА, УБ, 2013
19. Ч.Нямгэрэл болон бусад, Багш бэлтгэдэг их, дээд сургуулиудын сургалтад зориулсан хичээлийн хөтөлбөр. БШУЯ, ЖАЙКА, УБ, 2013
20. “ОЕСД Суралцагчдын суралцах чадварын үнэлгээ судалгаа (Programme for International Student Assessment): 2009 оны судалгааны олон улсын үр дүнгийн товчлол”, Үндэсний боловсролын бодлогын судалгааны хүрээлэн, Токио, 2009.
21. Олон улсын Математик, Байгалийн ухааны боловсрол чиг хандлагын судалгаа: 2011 оны судалгааны олон улсын үр дүнгийн тайлан (TIMSS2011). Үндэсний боловсролын бодлогын судалгааны хүрээлэн, Токио, 2011
22. Саппоро хотын Боловсролын төвийн вебсайт: <http://www.sec.sapporo-ed.jp/download/tebiki.html>
23. Японы хичээлийн судалгаа: “Lesson Study in Japan”. Японы Боловсролын арга зүйн эрдмийн зөвлөл, Гакүбүншя, 2009
24. Хаттори Акира “Хуулинд заагдсан сургалт” дахь багш ажилтан, шинэ залуу багш нарт зориулсан сургалтын өнөөгийн байдал ба тулгамдсан асуудал (The Present Status of Induction Training in Law for Beginning Teachers). Японы Боловсролын мэдээллийн судалгааны эрдмийн зөвлөл, Токио, 2009
25. Мицүхаша Коичи (MITSUHASHI Koichi) Японы хичээлийн судалгааны гарал үүслийн зураглалын танилцуулга. Японы хичээлийн судалгааны онол арга зүйн системчлэл ба гарал үүслийн талаархи хөгжлийн судалгаа (Development Research on Genealogy and System of Methodology in Research on Teaching in Japan). Японы боловсролын технологийн хөгжлийн нийгэмлэг, Токио, 2003 он

ХАВСРАЛТ 1. ЖАЙКА, БСШУЯ-наас хамтран хэрэгжүүлсэн төслийн загвар аймаг, сургууль

Загвар аймаг	Загвар сургууль
<i>Төслийн I шат: 2006-2009 он</i>	
Сэлэнгэ аймаг	Сүхбаатар сумын 1 дүгээр сургууль
	Сүхбаатар сумын 4 дүгээр сургууль
	Хушаат сумын сургууль
Дорнод аймаг	Чойбалсан сумын “Хан-Уул” цогцолбор сургууль
	Чойбалсан сумын 5 дугаар сургууль
	Матад сумын сургууль
Улаанбаатар	Баянзүрх дүүргийн “Сэтгэмж” цогцолбор сургууль
	Баянзүрх дүүргийн 45 дугаар сургууль
	Баянзүрх дүүргийн 97 дугаар сургууль
<i>Төслийн II шат: 2010-2013 он</i>	
Булган аймаг	Булган сумын 1 дүгээр сургууль
	Сэлэнгэ сумын сургууль
	Хутаг-Өндөр сумын сургууль
	Хишиг-Өндөр сумын сургууль
	Гурванбулаг сумын сургууль
Завхан аймаг	Улиастай сумын Чандмань-Эрдэнэ цогцолбор сургууль
	Завханмандал сумын сургууль
	Шилүүстэй сумын сургууль
	Сонгино сумын сургууль
	Тосонцэнгэл сумын 1 дүгээр сургууль
	Баянтэс сумын сургууль
Улаанбаатар	Сонгинохайрхан дүүргийн “Ирээдүй” цогцолбор сургууль
	Сонгинохайрхан дүүргийн 12 дугаар сургууль
	Сонгинохайрхан дүүргийн 67 дугаар сургууль

ХАВСРАЛТ 2. Төслийн эхний шатанд боловсруулж хэвлэсэн гарын авлага

№	Судлагдахуун	Түвшин	Зөвлөмжийн нэр
<i>Зөвлөмж - I (2007 он)</i>			
1	Физик	суурь	Хялбар туршилтаар мэдлэг бүтээлгэх арга зүй
2	Хими	суурь	Сорил тооцоогоор мэдлэг бүтээлгэх арга зүй
3	Математик	бага	Бодит юмсыг загварчлан тооцоолох үйлд хүүхдийг сургах арга зүй
4	Математик	суурь	Хүүхдээр математикийн хялбар мэдлэг бүтээлгэх арга зүй
5	Байгалийн ухаан	суурь	Сорил туршилтаар мэдлэг бүтээлгэх арга зүй (Зөвлөмж)
6	Байгалийн ухаан	суурь	Сорил туршилтаар мэдлэг бүтээлгэх арга зүй (Сурагчийн гарын авлага)
7	Хүн орчин	бага	Амьд биеийн хөгжлийг таниулах арга зүй
8	Мэдээлэл зүй	бага	Айн киррикулим боловсруулах арга зүй
9	Төсөлт ажил	бага	Төсөлт ажлын арга зүй
<i>Зөвлөмж - II (2008 он)</i>			
10	Физик	суурь	Сургалтад сурагчдын өмнөх төсөөллийг тооцох арга зүй
11	Хими	суурь	Мэдээлэл боловсруулж химийн мэдлэг бүтээлгэх арга зүй
12	Математик	бага	Бодит юмсыг загварчлан тооцоолох үйлд хүүхдийг сургах арга зүй
13	Математик	суурь	Сурах үйлийн баримжаагаар суралцахуйг дэмжих арга зүй
14	Хүн байгаль	бага	Сорил туршилтаар мэдлэг бүтээлгэх арга зүй
15	Хүн орчин	бага	Монгол орны бүс нутгийн байгаль ба нийгэм ахуйн шүтэлцээг таниулах арга зүй
16	Мэдээлэл зүй	суурь	Асуудал шийдвэрлэх замаар мэдээллийг мэдлэг болгон хувиргах арга зүй
17	Төсөлт ажил	суурь	Төсөлт ажлын арга зүй
<i>Зөвлөмж - III (2009 он)</i>			
18	Физик	суурь	Контекст төвтэй сургалтаар мэдээлэл харилцааны цогц чадамж төлөвшүүлэх арга зүй
19	Хими	суурь	Контекстэд суурилан мэдлэг бүтээлгэх арга зүй
20	Математик	бага	Хийж бүтээх, зурах, дүрслэх үйлээр дамжуулан математикийн агуулгыг эзэмшүүлэх арга зүй
21	Математик	суурь	Хүүхдээр асуудал шийдүүлэх арга зүй
22	Хүн байгаль	бага	Сорил туршилтаар мэдлэг бүтээлгэх арга зүй
23	Хүн орчин	бага	Хүрээлэн буй орчинг тоглоомын явцад таниулах арга зүй
24	Мэдээлэл зүй	суурь	Хэрэглээнд суурилсан сургалт зохион байгуулах арга зүй
25	Төсөлт ажил	бага, суурь	Төсөлт ажлын арга зүй
26	Зөвлөмж боловсруулах гарын авлага		
27	Хичээлд мониторинг хийх зөвлөмж		